



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2021

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааны захиалагч:

Батлан хамгаалах яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг гүйцэтгэсэн:

Ж.Бариаширсүрэн

Хуульч, судлаач

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
УДИРТГАЛ	5
НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.....	6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	7
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох	8
1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	8
1.3.2. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	8
1.4. Үнэлгээний арга зүй	9
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	10
2.1. ЗОРИЛГОД ХҮРЭХ ТҮВШИН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ	10
ЦАтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.4, 12 дугаар зүйлийн 12.5, 12.7, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ	10
ЦАтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ	21
ЦАтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ	25
ЦАтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ	29
ЦАтХ-ийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.2 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ	33
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	50
ЦАтХ-ийн 4.4, 12.5, 12.7 болон 34.4 дэх хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь.....	50
ЦАтХ-ийн 7.5 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь	52
ЦАтХ-ийн 7.7 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь	53
ЦАтХ-ийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь	54
ЦАтХ-ийн 36 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь	54
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	58
ТАВ. ЗӨВЛӨМЖ.....	61
Бодлогын түвшинд анхаарах асуудал	61
Хэрэгжилтийн төвшинд анхаарах асуудал.....	61
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	63
ХАВСРАЛТ №1 “ЦАтХ-д тусгагдсан шинэ зохицуулалт”	65
ХАВСРАЛТ №2 Батлан хамгаалах салбарын төрийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийн жагсаалт	70

ХАВСРАЛТ №3 ЦАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зорилгоор хугацаат цэргийн алба хаагчдаас болон цэргийн жинхэнэ алба хаагчдаас авсан анкетын судалгааны үр дүн.....	76
ХАВСРАЛТ №4 УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хүргүүлсэн албан бичгийн хуулбар.....	80

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БХИС	Батлан хамгаалах их сургууль
БХЯ	Батлан хамгаалах яам
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗтХ	Зөрчлийн тухай хууль
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ТАтХ	Төрийн албаны тухай хууль
УИХ	Улсын Их хурал
ЦАтХ	Цэргийн албаны тухай хууль
ЦАХЭЗБтХ	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/

ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 Шүүхийн шийдвэрийн цахим санд бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл, тоо	39
Хүснэгт № 2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэрэгт холбогдсон цэргийн алба хаагчдын тоо	40
Хүснэгт № 3 Гэмт хэргийн төрөл, гэмт хэргийн тоо оноор	40
Хүснэгт № 4 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг осол, төрөл, тоо	41
Хүснэгт № 5 Гэмт хэрэг, ослын төрөл, амь нас хохирсон тоо	41

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График № 1 Цэргийн алба хаахыг хүсдэг эсэх	12
График № 2 Цэргийн албанд ажиллах хүсэл	13
График № 3 Цэргийн насныхны эрх зүйн мэдлэгийн түвшин	13
График № 4 Хугацаат цэргийн албанаас чөлөөлөгдөх асуудлаар	15
График № 5 Хугацаат цэргийн алба хаагчдын боловсролын түвшин	18
График № 6 Хугацаат цэргийн алба хааснаар үүсэх давуу тал	18
График № 7 Хугацаат цэргийн алба хаагчдын ажлын байрны баталгаа	23
График № 8 Хугацаат цэргийн алба хаагчдын боловсролын түвшин	24
График № 9 Хугацаат цэргийн алба хаагчдын ажиллаж байсан салбар	24
График № 10 Цэргийн дүйцүүлэх албаны талаар мэдлэгийн түвшин	31
График № 11 Сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээний тухай	45

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлийн 1-ийн 4/-т “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” иргэний ёсчлон биелүүлэх үүргийг тодорхойлж өгсөн. Энэ нь 18-25 насны эрэгтэй хүн бүр цэргийн алба хаах үүргийн тодорхойлж өгсөн бөгөөд энэхүү үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг 2016 онд баталсан Батлан хамгаалахын багц хуулиуд, түүн дотор Цэргийн албаны тухай хууль бүрдүүлж байна.

Цэргийн албаны тухай хуулийг боловсруулахдаа “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг болон бусад батлан хамгаалах салбарт хамаарал бүхий бодлого, хөтөлбөр зэрэг баримт бичгээр тогтоосон зорилго, чиглэлүүдэд тусгагдсан асуудлуудаас гадна зарим дүрэм, журмаар зохицуулагдаж байсан харилцааг хуульчилж өгсөн байна.

УИХ-аас 2016 онд баталсан Цэргийн албаны тухай хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3-т заасан шаардлагыг хангасан, хуулийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл үүссэн, мөн сүүлийн үед зэвсэгт хүчний салбар, цэргийн албанд үүсээд буй зарим асуудалтай холбогдуулан уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн. Иймээс ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.1.3-т заасан “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу шинээр нэмэгдсэн заалт болох Оюутан-цэрэг сургалт болон хуулийн хэрэгжилтэд нөлөөлдөг байж болзошгүй цэргийн бүртгэлийн асуудал, сахилга хариуцлагын асуудалд хамаарах хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 7 дугаар зүйлийн 7.5, 7.7, 12 дугаар зүйлийн 12.5, 12.7, 16 дугаар зүйлийн 16.1, 34 дүгээр зүйлийн 34.4, 36 дугаар зүйлийн 36.1, 36.2 дахь хэсгүүдэд тусгасан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт “үнэлгээ хийж тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхой таамаглал дэвшүүлэх, асуулт тавих замаар тогтоохыг зорьлоо.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ шаардлагатай мэдээллийг аргачлалын 3.7.3.1, 3.7.3.2-т заасан арга болон холбогдох байгууллагаас гаргасан мэдээ мэдээлэл, мөн аргачлалын заасан холбогдох субьектээс судалгаа авах зэргээр бүрдүүлсэн бөгөөд уламжлалт судалгааны аргуудыг ашиглан үнэлэлт, дүгнэлт өглөө.

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлийн 1-ийн 4/-т “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах”¹ иргэний ёсчлон биелүүлэх үүргийг тодорхойлж өгсөн байх ба энэхүү иргэний цэргийн үүрэг² нь “Монгол Улсын иргэн цэргийн албанд татагдах, элсэх, цэргийн мэргэжил эзэмших, цэргийн байгууллагад цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэх, цэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн бүртгэлд байх, цэргийн дайчилгааны цугларалт, сургуульд оролцох” гэсэн ойлголтоор тодорхойлогдох ба 18-25 насны эрэгтэй хүн бүр цэргийн алба хаах үүргийн эрх зүйн үндэс болж байна. Энэ тодорхойлолтын хүрээнд иргэн нь “офицерын алба”, “ахлагчийн алба”, “хугацаат цэргийн алба”, “цэргийн дүйцүүлэх алба” “гэрээт цэргийн алба”, “оюутан-цэрэг” зэрэг цэргийн албыг биеэр болон хуульд заасан хэлбэрээр хаахыг ойлгож болно.³

Цэргийн алба хаахтай холбоотой харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажил 2015 онд Улсын Их хурлаас /цаашид УИХ гэх/-аас “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” бодлогын баримт бичгийг баталснаар сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж байна. Тухайлбал, 2016 онд Улсын Их Хурлаас Монгол Улсын батлан хамгаалахын багц хууль буюу Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулиудыг тус тус баталсан. Үүний үр дүнд 1992 онд баталсан “Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай”⁴ хуулийг боловсронгуй болгож цэргийн албаны ерөнхий зохицуулалтаас цэргийн жинхэнэ алба хаагчийн эрх зүйн байдлыг зааглан салгаж тус тусдаа бие даасан хуулиар буюу “Цэргийн албаны тухай” болон “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулиудаар зохицуулах болсон нь өмнөх хуульд тусгагдаагүй байсан зарим харилцааг шинээр болон нарийвчлан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Цэргийн албаны тухай хуулийг боловсруулахдаа “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”⁵, “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг⁶ болон бусад батлан хамгаалах салбарт хамаарал бүхий бодлого, хөтөлбөр⁷ зэрэг баримт

¹ Монгол Улсын Үндсэн хууль. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/367> Сүүлд үзсэн 2021.06.25.

² Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 4.1

³ Батлан хамгаалахад иргэний оролцоо, иргэдийг бэлтгэх зарим арга зам. Б.Нэргүй. БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор(Ph.D), дэд хурандаа. “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл. №39 /29/2020. Эх сурвалж: <http://mids.gov.mn/images/stories/setguul/29392020.pdf>

⁴ <https://www.legalinfo.mn/law/details/349>

⁵ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.2.2-т “...зэвсэгт хүчний нэгдмэл тогтолцоог төлөвшүүлж, зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ” гэж

⁶ Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана”

⁷ Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 92 дугаар зарлигт “Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа 18-25 насны ... эрэгтэйчүүдийг... үндсэн сургалтын чөлөөт цагт нь цэргийн жинхэнэ албыг хаалгах”

бичгээр тогтоосон зорилго, чиглэлүүдэд тусгагдсан асуудлуудаас гадна зарим дүрэм, журмаар зохицуулагдаж байсан харилцааг хуульчилж өгсөн байна. Тухайлбал, цэргийн алба болон түүнд хамаарал бүхий нэр томъёоны нэгдмэл байдлыг хангах зорилгоор нэр томъёоны хэсгийг хуульд тусгасан, мөн цэргийн албанд татагдах, хугацаат цэргийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх үндэслэл, хугацаат цэргийн болон цэргийн гэрээт алба хаах, цэргийн жинхэнэ албанд авах болзол, албан үүрэгт томилох, чөлөөлөх, шилжүүлэх, хавсран болон түр орлох, бууруулах, халах, мөн цэргийн цол олгох, хэрэглэх, хураахтай холбогдсон зарим асуудлыг шинээр болон нарийвчлан тогтоож өгчээ. Түүнчлэн өмнө нь УИХ-ын 2009 оны 33 дугаар тогтоолын⁸ хавсралтаар баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр хаах болзол” болон “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоох сүлжээ”, “Цэргийн цол олгох журам”⁹ болон Монгол Улсын Засгийн газар /цаашид ЗГ гэх/-ын 2014 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Оюутан-цэрэг хөтөлбөр”¹⁰-ийн хүрээнд хэрэгжиж байсан их, дээд сургуулийн оюутнууд цэргийн алба хаах эрх зүйн орчныг бүрдүүлж хуульчилжээ.

УИХ-аас 2016 онд баталсан Цэргийн албаны тухай хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3¹¹-т заасан шаардлагыг хангасан, хуулийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл үүссэн, мөн сүүлийн үед зэвсэгт хүчний салбар, цэргийн албанд үүсээд буй зарим асуудалтай холбогдуулан уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

ЗГ-ын “Аргачлал батлах тухай” 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д¹² зааснаар Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлохдоо хэрэгжилтийг нь шалгаж үнэлгээ хийх гэж буй хууль тогтоомжийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг сонгох¹³ боломжтой байдаг.

Иймээс УИХ-аас 2016 онд баталсан Цэргийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо уг хуулийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан “Хуулийн төсөл батлагдсанаар

⁸ “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол”, “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоох сүлжээ”, УИХ-ын тогтоол. “Болзол батлах тухай”, 2009 оны 4 сарын 30 өдөр, Дугаар 33. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/5864>

⁹ МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг. Журам батлах тухай /Цэргийн цол олгох журам/ Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/58?lawid=730>

¹⁰ ЗГ-ын тогтоол. “Хөтөлбөр батлах тухай”, 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдөр, Дугаар 40. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/9807>

¹¹ Хууль тогтоомжийн тухай хууль. 51 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 51.3. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно. Эх сурвалж: <https://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>

¹² Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

¹³ ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.6.2 дахь заалт. <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

Монгол Улсын иргэн эх орноо батлан хамгаалах бэлтгэлийг эзэмших, батлан хамгаалах үйл хэрэгт оролцох, цэргийн бүртгэлд хамрагдах, ... тайван цагт иргэнийг хугацаат цэргийн албанаас чөлөөлөх, ... үндэслэл илүү тодорхой, ойлгомжтой болно. ... их, дээд сургуулийн оюутан цэргийн алба хаах эрх зүйн үндэс бүрдэнэ. Мөн ... төрийн цэргийн байгууллагуудын нэгдмэл харилцаа улам боловсронгуй болох юм.” гэх үндсэн зорилгуудын хүрээнд уг хуулийг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд чухал ач холбогдолтой гэх зүйл заалтуудаас сонгосон болно.

1992 оны “Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай”-хуулиар зохицуулагдаагүй байсан Цэргийн албаны тухай хуульд шинээр нэмэгдсэн зүйл заалтыг түүвэрлэж үзвэл нийт 92 зүйл, хэсэг, заалт байна. /Хавсралт №1/ Үүнээс ЗГ, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын болон цэргийн мэргэжлийн байгууллага зэрэг эрх бүхий субъектэд дүрэм, журам боловсруулах, жагсаалт батлахтай холбоотой үүрэг хүлээлгэсэн зохицуулалтууд болон зарим заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх шаардлагагүй тул хассан болно.

Судалгааг гүйцэтгэхдээ батлан хамгаалах, цэргийн албатай холбоотой мэдээ мэдээллийн нууц байдлаас хамааран үнэлгээний үр дүнг нийтэд танилцуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор энэхүү судалгаанд Төрийн болон албаны нууцын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжид зааснаас /Хавсралт №2/ бусад нууцад үл хамаарах мэдээлэл ашиглах боломж бүхий зүйл, заалтуудыг сонгосон болно.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох ажлын хүрээнд ЦАТХ-ийн сонгосон зүйл заалтын “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлээ.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасан “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхой таамаглал дэвшүүлэх, асуулт тавих замаар тогтоохыг зорьдог¹⁴

1.3.2. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ЦАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг аргачлалын 3.7.3.1-т заасан бэлэн байгаа мэдээлэл цуглуулах арга буюу холбогдох ном, товхимол, эмхтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, Батлан хамгаалах яам /цаашид БХЯ гэх/, Зэвсэгт хүчний жанжин штаб /цаашид ЗХЖШ гэх/, Батлан хамгаалахын их сургууль /цаашид БХИС гэх/, Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг холбогдох байгууллагаас гаргасан мэдээ мэдээлэл, мөн аргачлалын 3.7.3.2-т

¹⁴ ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4.1 дэх заалт. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

заасан холбогдох субъектээс судалгаа авах аргын дагуу холбогдох албаны алба хаагч, цэргийн алба хааж буй болон бэлтгэл/чөлөөнд гарсан албан хаагчдаас зарим шаардлагатай мэдээ, мэдээллийг нарийвчлан тодруулах зорилгоор хийсэн уулзалт, ярилцлага, анкетын судалгааны үр дүн зэргээр бүрдүүлсэн болно. /Цэргийн жинхэнэ алба хаагчдаас болон хугацаат цэргийн алба хаагчдаас авсан анкетын судалгааны үр дүнг Хавсралт 3-аас үзнэ үү/

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хийж, гүйцэтгэв. Түүнчлэн ЦАТХ-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлахдаа харьцуулах, түүхчлэх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх гэсэн хууль зүйн судалгааны үндсэн арга зүйг ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон үнэлгээ хийх хүрээнд багтсан зүйл заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл буюу хууль тогтоомж, илтгэл, нийтлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ном, эмхтгэл зэрэг олон нийтийн хүртээл болгосон бүтээлүүд болон холбогдох байгууллагуудаас гаргасан мэдээлэлд үндэслэн ЦАтХ-ийн сонгогдсон заалтууд уг хуулийн 1 дүгээр зүйлд заасан “Монгол Улсын иргэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан үүргийнхээ дагуу эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмших, цэргийн алба хаахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэх зорилтод нийцэж буй эсэх, мөн тухайн асуудлыг хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэв хангалтгүй бол ямар шалтгаан байгааг тодорхойлохыг зорьсон.

2.1. ЗОРИЛГОД ХҮРЭХ ТҮВШИН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ЦАтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.4, 12 дугаар зүйлийн 12.5, 12.7, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	4 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүрэг	4.4.Цэргийн бүртгэлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд нэг удаа зохион байгуулах ба түүнд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана.	Жил бүр зохион байгуулагдаж буй цэргийн бүртгэлд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана.
	12 дугаар зүйл. Хугацаат цэргийн албанд татах	12.5.Зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр болон товлосон газарт ирсэн байх үүрэгтэй.	
		12.7.Хугацаат цэрэг татлагын үед байнга оршин суугаа газраасаа өөр газарт түр хугацаагаар яваа иргэн тухайн нутаг дэвсгэрийн цэрэг татлагын байранд очиж бүртгүүлэх үүрэгтэй.	
	34 дүгээр зүйл. Цэргийн бүртгэл	34.4.Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ.	

Судалсан байдал

Цэргийн албаны тухай хуулийн хууль /цаашид ЦАтХ гэх/-ийн 4.4-т “Цэргийн бүртгэлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд нэг удаа зохион байгуулах ба түүнд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана”, 12 дугаар зүйлийн 12.5-д “Зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр болон товлосон газарт ирсэн байх үүрэгтэй”, 12.7-д “Хугацаат цэрэг татлагын үед байнга оршин суугаа газраасаа өөр газарт түр хугацаагаар яваа иргэн тухайн нутаг дэвсгэрийн цэрэг татлагын байранд очиж бүртгүүлэх үүрэгтэй”, 34 дүгээр зүйлийн 34.4-т “Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ” гэж тус тус заасан байна.

Цэргийн албаны тухай хуулийг баталснаар “Монгол Улсын иргэн эх орноо батлан хамгаалах бэлтгэлийг эзэмших, батлан хамгаалах үйл хэрэгт оролцох, цэргийн бүртгэлд хамрагдах ... үндэслэл илүү тодорхой, ойлгомжтой болно” гэж хуулийн төслийн Үзэл

баримтлалд тусгажээ. Түүнчлэн уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14-т “цэргийн бүртгэл” гэж цэргийн бэлтгэл үүрэгтний тоо, чанарт дүн шинжилгээ хийх бүртгэлийн тогтолцоог ойлгоно хэмээн нэр томъёог тодорхойлж өгсөн.

Иймээс ЦАТХ-ийн 4, 12 болон 34 дүгээр зүйлийн холбогдох хэсэгт заасан эрх зүйн зохицуулалтын үр дагаврыг тооцохдоо “Жил бүр зохион байгуулагдаж буй цэргийн бүртгэлд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана” гэх томъёоллын хүрээнд “**Зорилгод хүрэх түвшин**” шалгуур үзүүлэлтийн дагуу судалсан болно.

Өнөөдрийн байдлаар цэргийн бүртгэлтэй холбогдох асуудлыг Цэргийн албаны тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/, Дайны байдлын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай зэрэг хууль тогтоомж болон Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам” зэрэг холбогдох ЗГ-ын тогтоол, “Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай” Батлан хамгаалах сайдын 2017 оны А/331 дугаар тушаал зэрэг эрх зүйн актуудаар зохицуулж байна.

ЦАТХ-ийн 34 дүгээр зүйлд 1992 оны “Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуульд тусгагдаагүй байсан цэргийн бүртгэлд бүртгүүлэх иргэний үүрэг, цэргийн бүртгэлд хамрагдахгүй иргэний талаар тодорхой тусгаж хуульчилсан бол цэргийн бүртгэл явуулах журмыг Батлан хамгаалах сайдын 2017 оны А/331 дугаартай “Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай” тушаалаар¹⁵ баталж 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Хуулийн 4.4-т заасан цэргийн бүртгэлд хамаарах эрх зүйн зохицуулалт нь нэг талаас цэргийн бүртгэлд хамрагдах үүрэг бүхий иргэнд үүрэг хүлээлгэж байгаа бол нөгөө талаас цэргийн бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагуудад үүрэг хүлээлгэсэн байна.

Төрийн буюу аймаг, нийслэл /дүүргийн/ Засаг даргын Тамгын газар¹⁶ болон Засаг даргын шууд удирдлага дор ажилладаг батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг орон нутагт хангах ажлыг тайван болон онцгой нөхцөлийн үед зохион байгуулах, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэргэшил, арга зүйн удирдлага, туслалцаа үзүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх Цэргийн штаб нь цэргийн бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг засаг захиргааны анхдагч нэгж болох баг, хороотой хамтран зохион байгуулна.¹⁷ Энэхүү үйл ажиллагаанд батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргаас захиргааны удирдлагын чиглэлээр, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд

¹⁵ Батлан хамгаалах сайдын 2017 оны “Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай” А/331 дугаар тушаал. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/13005>

¹⁶ Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл.

¹⁷ Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм. Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолын хавсралт. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/941?lawid=2261>


байгууллагаас мэргэжлийн удирдлагын чиглэлээр дэмжлэг үзүүлж ажилладаг байна. Тухайлбал, цэргийн штабууд цэрэг татлага, цэргийн бүртгэлээс гадна ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөний дагуу цэрэг, техникийн тоо бүртгэл явуулах, нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад шалган туслах ажил гүйцэтгэж тухайн байгууллагын цэргийн насны иргэдийг шалгах, хуулийн дагуу зөрчлийг арилгуулах, хууль сурталчлах, таниулах зэрэг ажлыг гүйцэтгэдэг.

Төрийн байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй цэргийн бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа нь олон жилийн туршид тасралтгүй хэрэгжиж ирсэн тул хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл бага байна.

Харин цэргийн бүртгэлд бүртгэлтэй иргэн жил бүр цэргийн бүртгэлд хамрагдах тухайд асуудал үүсдэг тул хуулийн 4.4 дэх хэсгийн хэрэгжилтийг үнэлэхдээ жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг цэрэг татлага зохион байгуулах болон цэргийн бүртгэл хөтлөх захиргааны үйл ажиллагаанаас илүүтэй цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтний тухайд нөхцөл байдлыг тодруулахыг зорьлоо.

Хууль тогтоомжид зааснаар цэргийн бүртгэлд цэргийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 18-50 насны эрэгтэйчүүдээс гадна цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг бүртгэдэг бөгөөд статистик мэдээнээс харахад 2019 онд 780 мянга гаруй, 2020 онд 806 мянга орчим эрэгтэй¹⁸ буюу хүн амын ойролцоогоор 4 хүн тутмын 1 нь цэргийн бүртгэлд хамрагдах насны эрэгтэй байна. Үүнээс хуульд заасан үндэслэлээр цэргээс чөлөөлөгдсөн иргэд тодорхой хувийг эзэлнэ.

График № 1 Цэргийн алба хаахыг хүсдэг эсэх




ЦАТХ-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор хугацаат цэргийн алба хаагчдаас авсан судалгааны¹⁹ дүнгээс харахад 80 хувь цэргийн алба хаахыг хүссэн, 20 хувь нь хүсээгүй гэжээ. Цэргийн алба хаахыг хүсэхгүй байх шалтгааныг тодруулсан асуултад судалгаанд оролцогсдын 72 хувь нь хариулсан бөгөөд тэдгээрийн 58,6 хувь нь “хүнд захирагдахыг хүсдэггүй”, 27,5 хувь нь “цэргийн дэглэлтээс айдаг”, 13,7 хувь нь “өөрийгөө эрүүл мэндээр тэнцэхгүй” гэж хариулсан байна.

¹⁸ ҮСХ. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Эр сурвалж: https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_071V3&Group_select_all=0&GroupSingleSelect=_10404_10405_105_106_107_108_109_110_11101&Sex_select_all=0&SexSingleSelect=_11&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019&viewtype=table

¹⁹ ЦАТХ-ийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх зорилгоор хугацаат цэргийн алба хаагч болон цэргийн жинхэнэ албан хаагчдаас 70 ширхэг анкетын судалгааг 2021.07.20.-2021.07.23-ны өдрийн хооронд авч, дүн шинжилгээ хийсэн болно.

Харин хугацаат цэргийн алба хааж дууссаны дараа цэргийн байгууллагад үлдэж ажиллах хүсэлтэй эсэхийг тодруулахад эсрэгээрээ 15 хувь нь “тийм”, 85 хувь нь “үгүй” гэж хариулжээ.

График № 2 Цэргийн албанд ажиллах хүсэл



ЦАТХ-ийн 4 болон 12 дугаар зүйлд холбогдох эрх зүйн зохицуулалтын үр дагаврыг үнэлэх зорилгоор хийгдсэн ярилцлагын судалгаанд өөрийн хүсэлтээр оролцсон 18-25 насны 10 залуугийн ихэнх нь цэргийн албыг дүйцүүлэн хаах талаар тодорхой мэдлэггүй, эсхүл энэ төрлийг сонгох сонирхолгүй, бас цэргийн албыг биеэр хаах хүсэлгүй байгаагаа илэрхийлж байсан. Гэхдээ БХЯ-ны зүгээс өгсөн мэдээллээс харахад жилээс жилд цэргийн алба хаах хүсэлтэй залуусын тоо өсөх хандлагатай байгаа аж. Энэ нь УИХ-аас 2017 онд баталсан Төрийн албаны тухай хуулийн²⁰ 22 дугаар зүйлд заасан “Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах шаардлага”-д цэргийн жинхэнэ алба хаах үүргээ биелүүлсэн байх нийтлэг шаардлагыг оруулж өгсөн, цэргийн алба хаах хугацаандаа улс орны томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцох боломж нээгдсэнтэй холбож болохоор байна.

График № 3 Цэргийн насныхны эрх зүйн мэдлэгийн түвшин



Хугацаат цэргийн алба хаагчдаас авсан судалгаанаас харахад цэргийн дүйцүүлэх албаны талаарх мэдлэг тааруу байна. Судалгаанд оролцогчдын 45 хувь нь цэргийн алба хаах энэ төрөл, түүнд тавигдах шаардлагын талаар мэдлэггүй байгаа бол ердөө 0,07 хувь нь “сайн мэднэ” гэж хариулжээ. Мөн 47,5 хувь нь энэ тухай сонсож байсан гэж хариулснаас харахад хугацаат цэргийн алба хаах насны залуусын 90 гаруй хувь цэргийн албыг дүйцүүлэн хаах боломжийн талаарх мэдлэг муутай байна.

Харин төрийн жинхэнэ албанд ажиллахын тулд цэргийн алба хаах шаардлагатай талаар хугацаат цэргийн алба хаагчдын 80 гаруй хувь нь мэдээлэл авсан байна.

Одоогийн залуус цэрэгт явах сонирхол ихтэй болсон. Өмнө нь бид цэргийн тоогоо яаж гүйцээх талаар санаа зовдог байсан бол одоо өөрийн хүсэлтээр цэрэгт явах хүсэлтэй

²⁰ <https://www.legalinfo.mn/law/details/13025>

хүнээ багтаахааргүй болсон. Тэр байтугай хаана цэргийн алба хаах хүсэлтэйгээ хүртэл илэрхийлдэг болсон зэрэг давуу талтай. Гэхдээ тухайн хүний эрүүл мэнд, бие бялдрын онцлогийг харгалзан хуваарилдаг.

БХЯ-ны хэлтсийн дарга, хурандаа Энхболд

Цэргийн бүртгэлд бүртгүүлэх цэрэгт бүртгэлтэй иргэдийг цэргийн бэлтгэл албанаас чөлөөлж, бүртгэлээс хасах зохицуулалтыг ЦАТХ-ийн 32 дугаар зүйлд тусгасан. Хуулийн 32.3-т “Цэргийн бэлтгэл албанд дээд офицер 65 нас, ахлах офицер 60 нас, дунд офицер, ахлагч 55 нас, эмэгтэй офицер, ахлагч болон байлдагч, түрүүч 50 нас хүртэл бүртгэлтэй байна”, 32.5-д “Цэргийн бэлтгэл албанд байх нас хэтэрсэн, эрүүл мэндээр цэргийн албанд тэнцэхгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан бэлтгэл үүрэгтнийг чөлөөнд гаргаж, бүртгэлээс хасна” гэж тус тус заасан.

Цэргийн бүртгэлд хамрагдах идэвх нас насанд харилцан адилгүй байна. Ялангуяа цэргийн албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаасан цэргийн бэлтгэл албан хаагчид бүртгэлд харьцангуй идэвхтэй оролцдог бол цэргийн алба хаагаагүй, эрүүл мэндийн шалтгааны улмаас цэргийн албанаас түр болон бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэд, мөн цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн алба хаагчдын хувьд бүртгэлд хамрагдахгүй байх тохиолдол элбэг байна.

Би 1997 онд Төв аймаг дахь ... дугаар ангид цэргийн алба хаасан. Цэргийн бүртгэлд бүртгүүлэхэд ямар ч асуудал гардаггүй. Хороон дээрээ очоод л СБД-ийн иргэн Г. Нас 47

Цэрэгт татагдах нас дуусахаас өмнө Өвөрхангайгаас хотод ирж ажиллаж эхэлсэн. Эхлээд хөдөө гэрт зарлан ирж байгаад сүүлдээ ирэхээ больсон. Мөнгө төгрөг төлөөгүй. Одоо бүртгүүлдэггүй. БЗД-ийн оршин суугч Б. Нас 32.


Цэрэг татлагын штаб дээр очих болгондоо цэрэгт явчих вий гэсэн айдастай байдаг. Оюутан биш болохоор. Цэргээс яаж бултах талаар найзуудаасаа зөвлөгөө авдаг. Миний үеийхэн дунд цэргээс эрүүл мэндээрээ хасагдсан найз бий бас өөр аргаар цэргээс хасуулаад байдаг ч бий. Надад тийм шалтгаан, танил байхгүй болохоор хэцүү. Найзуудын дунд цэрэгт явах хүсэлтэй хүн цөөн. БГД-ийн иргэн Д. Нас 20.

Зэвсэгт хүчин, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хийл хамгаалах газруудад ажиллаж байгаад чөлөөндөө гарсан хүмүүс ирж бүртгүүлэх нь хомс байна. БЗД-ийн Цэргийн штаб, дэд хурандаа Амарбат

Хугацаат цэргийн алба хаагчдаас авсан судалгаанаас харахад цэргийн бүртгэлд жил бүр бүртгүүлэх нь “хүндрэлтэй” гэж 37,5 хувь нь, “хүндрэлгүй” гэж мөн л 37,5 хувь нь үзсэн бол “мэдэхгүй” гэж 25 хувь нь хариулжээ. Түүнчлэн хугацаат цэргийн албанаас танил талтай эсхүл мөнгөтэй бол чөлөөлөгдөж болох талаар тавьсан асуултад 65 хувь нь “тийм”, 22,5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол 12,5 хувь нь “үгүй” гэсэн хариулт өгсөн. Үүнээс харахад

цэргийн бүртгэлд бүртгүүлэхдээ төвөгшөөх хандлага цэргийн бүртгэл үүрэгтнүүдийн дунд их байна. Түүнчлэн хугацаат цэргийн алба хаахгүй байхад танил тал, мөнгө нөлөөлдөг гэж үзсэн байна.

График № 4 Хугацаат цэргийн албанаас чөлөөлөгдөх асуудлаар



ЦАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.4-т заасан цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд бүртгэх асуудал дээрхээс ч илүү хүндрэлтэй байна. Хэдийгээр Цэргийн албаны тухай хуульд 34.4-т "Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ." гэж тодорхой үүрэгжүүлэн заасан боловч энэ үүргээ мэдэх эмэгтэйчүүд бараг байхгүй байна. Энэ нь нэгдүгээрт, Засгийн газраас баталсан цэрэгт шаардлагатай мэргэжлийн жагсаалт²¹ нийтэд ил тод бус, чухам ямар мэргэжилтэй эмэгтэй цэргийн бүртгэлд хамрагдах үүрэгтэй болох талаарх мэдээлэл хүртээмжгүй, хоёрдугаарт, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг ажиллуулдаг албан байгууллагууд Цэргийн штабтай мэдээлэл солилцдоггүй зэргээс шалтгаалдаг байна.

Цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн судалгааг засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооноос тухайн хороонд оршин суугаа цэрэгт бүртгэлтэй мэргэжилтэй эмэгтэйчүүдийн талаарх тоо мэдээллийг авдаг. Бас эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, гадаад харилцаа, харилцаа холбоо зэрэг асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас шаардлагатай мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн талаарх мэдээлэл авна. Гэхдээ энэ зохицуулалтыг заавал хэрэгжүүлдэг байхад хөшүүрэг болохуйц хуулийн зохицуулалт байхгүй байгаа нь цэргийн бүртгэлд эмэгтэйчүүдийг хамруулахад хүндрэл учруулдаг байна.

Цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай талаар мэдээлэлгүй байдаг. Цэргийн салбарт ажиллаж байсан эмэгтэйчүүд бол энэ талын мэдлэг сайтай, бүртгэлдээ хамрагдаад явдаг.

Чингэлтэй дүүргийн Цэргийн штаб, дэд хурандаа Цэдэн

Монгол Улсын хэмжээнд Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэгт мөрдөж байгаа өнөөгийн орон тоогоор жил тутам цэргийн насанд буюу 18 насанд хүрч байгаа²² нийт залуусын 30 хувийг л хугацаат цэргийн албанд татах боломжтой.²³ Үүнээс харахад жилд дунджаар 7000 орчим 18 насанд хүрсэн эрэгтэй цэргийн албанд татагддаг бөгөөд энэ нь нийт цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй эрчүүдийн 1%-ийг эзэлж байна. Гэхдээ хугацаат цэргийн алба хаах үүрэгтэй иргэдийн дунд ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан "эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын

²¹ ЦАТХ-ийн 6.4

²² ҮСХ-ний мэдээнээс харахад 2018 онд 24520, 2019 онд 22904, 2020 онд 22203 залуу 18 насанд хүрсэн байна. Эх сурвалж: <https://www.1212.mn/>

²³ Оюутан-цэрэг хөтөлбөр. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/9807>

үзлэгээр тогтоогдсон” үндэслэлээр цэргийн бүртгэлээс хасагдах цэргийн насны залуусын тоо өсөж байгаа нь, мөн залуучуудын дунд эрүүл мэндийн боловсрол дутмаг, өвчтэй эсэхээ цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт орж байж мэдэх тохиолдол их гардаг нь анхаарах асуудлын нэг болжээ. Тухайлбал, Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор баталсан “Иргэний цэргийн албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам” -ын дагуу эрүүл мэндийн шалтгаанаар тэнцэхгүй байх, уушгины шохойжилт, олон өнгөт үлд, чихний хэнгэрэг цүлхийсэн, хиймэл болор тавиулсан зэрэг 18 төрлийн өвчин эмгэг нэмэгдсэн байна. Жишээлбэл 2020 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт нийт 12874 иргэн хамрагдаж, цэргийн насны залуучуудын 5209 буюу 40 хувь нь эрүүл мэндийн хувьд тэнцээгүй байна. Оношийн бүлгээр авч үзэхэд мэс заслын өвчнөөр 1090, дотрын өвчнөөр 735, чих хамар хоолойн өвчнөөр 672, гэмтлийн улмаас 570, арьс харшлын өвчтэй 350 иргэн цэргийн алба хаах боломжгүй болжээ.²⁴

“Эх орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээх цэргийн насны залуусын эрүүл мэндийн асуудлыг цэцэрлэг, бага сургуулиас нь эхлэн эцэг эхчүүд, биеийн тамирын багш нар, тухайн дүүрэг, хороодын эмч, эрүүл мэндийн ажилтнууд онцгойлон анхаарч, суурь өвчлөлүүдийг багаас нь оношлон эмчилж байх шаардлагатай байна”

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга асан, хурандаа Ж.Болдбаатар²⁵

Энэ нь зөвхөн эх орноо батлан хамгаалах, цэргийн алба хаах үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл болохоос гадна цаашид улс орны нийгэм, эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Өнөөдөр цэргийн албанд татагдаж байгаа залуучуудын 40 хувь нь эрүүл мэндээр тэнцэхгүй байна. Зөвхөн эрүүл мэндээр тэнцэхгүй байна гээд орхих биш Эрүүл мэндийн яамтай хамтраад залуучуудыг яаж эрүүлжүүлэх энэ талаар анхаарч ажиллах нь чухал. Мөн Боловсролын яамтай хамтарч залуучуудынхаа хүмүүжил төлөвшил, эх оронч иргэн болж төлөвшихөд анхаарч, төлөвлөгөө гарган ажиллах хэрэгтэй.

Батлан хамгаалахын сайд асан Б.Бат-Эрдэнэ²⁶

Цэргийн насны залуус 8 жилийн турш цэргийн зарлан авч байгаа. Энэ бүрт эрүүл мэндийн цогц үзлэгт хамрагдана. Энэ нь эрчүүдэд эрүүл мэндээ хянах маш том боломж ч гэж харж болно. Маш олон хүн энд ирээд эрүүл мэндийн хувьд ямар асуудал байгаагаа мэдэх тохиолдол их. Бид цэргийн насны бүртгэлд хамрагдсан залуусын эрүүл мэндийн байдалд хяналт тавих зорилгоор Mhealth програмыг ашигладаг. Тодорхой үр дүн гарч байгаа. Бид шаардлагатай үед эх орноо хамгаалах залуусын эрүүл мэндэд анхаарах шаардлага маш их байна.

НЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр

²⁴ Цэргийн албанд тэнцэхгүй байх 18 төрлийн өвчин эмгэг нэмэгджээ 2020-10-08 <https://news.mn/r/2357975/>

²⁵ Ж.Болдбаатар: Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудлыг цэцэрлэгээс нь эхлээд анхаармаар байна. <https://zasag.mn/news/view/23637>

²⁶ Б.Бат-эрдэнэ: Цэргийн насны залуус өвчтэй байна гэж шүүмжлэх биш эрүүлжүүлэхэд анхаарах нь чухал. 2017 он. Засгийн газрын мэдээ сонин. Эх сурвалж: <https://zasag.mn/news/view/15529>


Цэргийн алба хаах хуулиар тогтоосон үүргийг хэрэгжүүлэхэд батлан хамгаалах салбарт тулгамдаж буй бас нэг асуудал бол цэргийн насны залуучуудын төлөвшил, үзэл бодол, сэтгэлгээ нь цэргийн алба, цэргийн хөдөлмөрийн онцлогтой зөрчилдөж, хувь хүний зан чанарын онцлог зэргээс шалтгаалан цэргийн албанаас шантрах, цэргийн алба хаагчийн эрх зөрчигдөх, сахилга дэг журмын зөрчил, гэмт хэрэгт холбогдох зэрэг асуудал байна. Ялангуяа боловсролын салбарт хүний эрхийн сургалтыг түлхүү явуулдаг ч эх оронч, үндэсний үзэл суулгах, үүрэг хариуцлагаа ухамсарлах чиглэлийн болон биеийн тамир, спортын сургалт, хөтөлбөр хангалтгүй байна. Энэ нь цэргийн насны залуусын төлөвшил, бие даах чадварт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн Монгол Улс боловсролд хамрагдах түвшний үзүүлэлтээр, ялангуяа залуучуудын хувьд, бүс нутагтаа тэргүүлж байгаа боловч ядуу ба ядуу бус хүн ам боловсролын түвшнээрээ илт ялгаатай байна. Манай улсын ойролцоогоор 3 хүн тутмын 1 нь ядуу. Гэтэл ядуу давхаргын хүмүүсийн ихэнх нь дунд буюу ахлах ангийн боловсролоос цааш суралцаагүй, тэдний арвын нэг нь л дээд боловсролтой бол хамгийн өндөр амьжиргааны түвшинтэй 20 хувийн тэн хагас нь дээд боловсролтой байна.²⁷

Зэвсэгт хүчинд орж ирж байгаа залуус нийгмийн бүх давхрагаас ирдэг. Амьдралд золгоход хүндрэлтэй газраас ч ирж байдаг. Энэ бүхэнтэй бид жилийн хугацаанд ажиллаад, засаад явуулахад хүндрэлтэй.

ЗХЖШ-ын дарга Д.Ганзориг²⁸

ЦАТХ-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор хийгдсэн анкетын судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан хугацаат цэргийн алба хаагчдын 62 хувь нь бүрэн дунд, 17,5 хувь нь дээд, 15 хувь нь мэргэжлийн боловсрол эзэмшжээ.

График № 5 Хугацаат цэргийн алба хаагчдын боловсролын түвшин



Дээрх мэдээллүүдээс харахад хугацаат цэргийн албанд татагдаж буй иргэдийн дийлэнх нь дунд болон дундаас доош нийгмийн давхаргаас ирж байна гэж дүгнэх боломжтой байна. Учир нь тэдэнд дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцах, гадаадад ажиллах зэргээр цэргийн албанаас түр чөлөөлөгдөх үндэслэл хомс байна. Хугацаат цэргийн алба хаагчдын дундах ялгаатай байдал, түүнээс үүдсэн зөрчилдөөн он удаан жил үргэлжилсээр ирсэн. Тухайлбал,

“хэдэн жилийн өмнө цэрэгт ирж байгаа залуус бичиг үсэг мэдэхгүй байсан бол өнөөдөр бие бялдар, эрүүл мэнд нь ямар нэгэн байдлаар өвчилсөн залуус ирж

²⁷ Ядуурлын дүр төрх. 2020. Эх сурвалж: <https://www.worldbank.org/mn/country/mongolia/publication/mongolia-poverty-update>

²⁸ Б.Баярсайхан: Батлан хамгаалах салбарт ёс суртахуун, ажлаа хийх сэтгэл дутаж байна. Эх сурвалж: <https://vip76.mn/content/75143>


байна. Энэ бол хилийн цэрэгт ч, манай зэвсэгт хүчинд асуудал болж байгаа сэдэв”
БХСайд асан Цолмон

Иймээс цэргийн албаны болон сургалт, бэлтгэлийн онцлогтой уялдуулан зэвсэг, байлдааны техник, хэрэгсэлтэй харьцаж буй хугацаат цэргийн алба хаагчдын дунд дунд хот, хөдөөгийн, боловсролын болон бие бялдрын ялгаатай байдал үүсч үүнээс үүдсэн сэтгэл санааны хямралд орох цаашлаад зөрчил, гэмт хэрэг гарах нөхцөл бүрдэх боломжтой байна.

ЗХЖШ дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийж, цэргийн албаны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, салбарт бэхжүүлэх талаар анхаарч БХЯ болон ЗХЖШ-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-өөс гадна Батлан хамгаалахын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 40 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд “Цэргийн албаны хэлтэс” болон зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна. Мөн ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтэс, Сургалтын бодлого зохицуулалтын хэлтэстэй хамтарч Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын бие бүрэлдэхүүнтэй явуулах “Цэргийн алба хаагчийн хөгжил-нийгмийн хариуцлага” сургалтын хөтөлбөр боловсруулж цэргийн алба хаагчаас албандаа хандах шинэ хандлага, эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, алба хаагчдын гэр бүл төлөвлөлт, эрүүл мэнд, санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ажлын байран дахь хамтын ажиллагаа ба ёс зүйн итгэл үнэмшлийг бий болгох, цаг үеийн өөрчлөлт, мэдээлэл, технологийн өндөр хурд, нийгмийн харилцааны онцлог энэ цаг үед харилцааны ёс зүй, стресс менежментийн мэдлэг олгож, улмаар ажил, амьдралын зөв дадалтай болгоход чиглэсэн сургалтыг цэргийн нэгтгэл анги, салбаруудад хуваарийн дагуу явуулахаар бэлтгэл хангажээ. Үүнээс харахад зэвсэгт хүчний байгууллагуудад сургагч багш, ухуулагч болон эрүүл мэндийн, ялангуяа сэтгэл зүйн эрүүл мэндийн ажилтны орон тоог анги, нэгтгэл бүрт бий болгох шаардлагатай байна.

Хэдийгээр цэргийн үүрэгтнүүдийн дунд хугацаат цэргийн алба хаах хүсэл бага байгаа боловч хугацаат цэргийн алба хааж буй байдлагчдын дийлэнх олонх нь буюу 90 орчим хувь нь цэргийн алба хааснаар эх орноо батлан хамгаалах мэдлэг олж авахаас гадна хувь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн тал дээр давуу байдал бий болно гэдэгт итгэдэг байна.

График № 6 Хугацаат цэргийн алба хааснаар үүсэх давуу тал



Анкетын судалгаанд оролцсон хугацаат цэргийн алба хаагчдын 65 хувь нь цэргийн алба хааснаар ёс суртахууны болон бие бялдрын хувьд төлөвшиж, хөгжинө гэж үзсэн бол 30 хувь нь ажил эрхлэх боломж нээгдэнэ гэж үзжээ. Үүнээс харахад хугацаат цэргийн алба хааж буй залуусын 95 хувь нь цэргийн алба хааснаар өөрийгөө хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэх боломжоо нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

Үнэлсэн байдал

ЦАТХ-ийн 4.4-т “Цэргийн бүртгэлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд нэг удаа зохион байгуулах ба түүнд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана”, 12 дугаар зүйлийн 12.5-д “Зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр болон товлосон газарт ирсэн байх үүрэгтэй”, 12.7-д “Хугацаат цэрэг татлагын үед байнга оршин суугаа газраасаа өөр газарт түр хугацаагаар яваа иргэн тухайн нутаг дэвсгэрийн цэрэг татлагын байранд очиж бүртгүүлэх үүрэгтэй”, 34 дүгээр зүйлийн 34.4-т “Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ” гэж тус тус заасан. Эдгээр заалтуудын хэрэгжилтийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Жил бүр зохион байгуулагдаж буй цэргийн бүртгэлд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдсан байна.” гэх томьёолон үнэлэхэд **“Зорилгодоо хүрэхгүй”** гэж үнэллээ.

Хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах явцад цугларсан мэдээллээс харахад цэргийн бүртгэл явуулж буй захиргааны үйл ажиллагаа хэвийн буюу уламжлалт байдлаар хийгдэж байна. Харин цэргийн бүртгэлд хамрагдах цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтний оролцоо, хандлага, мэдлэг дутмаг байгаагаас дээрх хуулийн заалтууд бүрэн хэрэгжих боломжгүй байна.

Цэргийн бүртгэлд цэргийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд бүртгүүлэх үүрэгтэй. Үндсэндээ Монгол Улсын хүн амын 4 хүн тутмын 1 нь цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэг хүлээж байна. ЦАТХ-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэхэд дараах хүндрэлүүд гардаг гэж үзлээ. Үүнд:

1. Хугацаат цэргийн алба хаах насны буюу 18-25 насны залуусын дунд цэргийн алба хаах сонирхол бага байна. Цэргийн насны залуус нийгмийн болон ар гэрийн нөлөөлөлд автагдан хугацаат цэргийн албанаас зайлсхийх нөхцөл байдал ажиглагдаж байна. Ялангуяа уламжлалт болон цахим мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээ, мэдээлэл тэдэнд илүү их нөлөөлж байна. Цэргийн алба хаах, хүүхдээ цэргийн алба хаалгах эсэхээ шийдэхдээ төрийн бодлого, хууль тогтоомжоор олгосон боломжийг судлахаас илүүтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээлэлд үндэслэдэг байна. Тухайлбал, цэргийн амьдралыг харуулсан кино контент цацагдах, үндэсний бүтээн байгуулалтад гар бие оролцож тодорхой цалин урамшуулалтай ажиллах боломж нээгдэх зэрэгт өөрийн хүсэлтээр цэргийн албанд татагдах хүсэлтэй залуусын тоо нэмэгддэг бол бусад үед буурах хандлагатай байдаг аж.
2. Цэргийн бүртгэлд хамрагдах идэвх харилцан адилгүй байна. Ялангуяа цэргийн дүйцүүлэх алба хаасан цэргийн бэлтгэл албан хаагчид бүртгэлд харьцангуй идэвхтэй оролцдог бол цэргийн алба хаагаагүй, эрүүл мэндийн шалтгааны улмаас цэргийн албанаас түр болон бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэд, мөн цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн алба хаагчдын хувьд бүртгэлд хамрагдахгүй байх тохиолдол элбэг байна. Үүнийг хугацаат цэргийн алба хаагчдаас авсан судалгаанд оролцогчдын 37,5 хувь нь 50 нас хүртлээ цэргийн бүртгэлд бүртгүүлэх нь

хүндрэлтэй, 25 хувь нь “мэдэхгүй” гэж хариулснаас харж болно Түүнчлэн хугацаат цэргийн алба хаахгүй байхад танил тал, мөнгө нөлөөлдөг гэж цэргийн насны залуусын 60 гаруй хувь нь үздэг байх магадлалтай үр дүн анкетын судалгаагаар гарсан. Үүнээс харахад цэргийн бүртгэлд бүртгүүлэхдээ төвөгшөөх хандлага цэргийн бүртгэл үүрэгтнүүдийн дунд нас харгалзахгүйгээр өндөр байна.

3.ЦАтХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.4-т заасан цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд бүртгэх асуудал хүндрэлтэй байна. Хэдийгээр Цэргийн албаны тухай хуульд 34.4-т ”Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ.” гэж тодорхой үүрэгжүүлэн заасан боловч энэ үүргээ мэдэх цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд цөөн байна. Энэ нь нэгдүгээрт, Засгийн газраас баталсан цэрэгт шаардлагатай мэргэжлийн жагсаалт нийтэд ил тод бус буюу ямар мэргэжилтэй эмэгтэй цэргийн бүртгэлд хамрагдах үүрэгтэй болох талаарх мэдээлэл хүртээмжгүй, хоёрдугаарт, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг ажиллуулдаг албан байгууллагууд Цэргийн штабтай мэдээлэл солилцдоггүй зэргээс шалтгаалж байна. Цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн судалгааг засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хороо, мөн эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, гадаад харилцаа, харилцаа холбоо зэрэг асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас авах замаар бүртгэл хөтөлдөг. Гэхдээ энэ зохицуулалтыг заавал хэрэгжүүлдэг байхад хөшүүрэг болохуйц хуулийн зохицуулалт байхгүй байгаа нь цэргийн бүртгэлд эмэгтэйчүүдийг хамруулахад хүндрэл учруулдаг байна.

4.Монгол Улсын хэмжээнд жил бүр 7000 орчим иргэн хугацаат цэргийн албанд татагддаг. Цэргийн насны залуусын эрүүл мэндэд анхаарах зайлшгүй шаардлага үүссэн байна. Учир нь хугацаат цэргийн алба хаах үүрэгтэй иргэдийн дунд ЦАтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан “эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдсон” үндэслэлээр цэргийн бүртгэлээс хасагдах цэргийн насны залуусын тоо өсөж байгаа нь, мөн залуучуудын дунд эрүүл мэндийн боловсрол дутмаг, өвчтэй эсэхээ цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт орж байж мэдэх тохиолдол их гардаг нь анхаарах асуудлын нэг болжээ.

5. Цэргийн алба хаах хуулиар тогтоосон үүргийг хэрэгжүүлэхэд батлан хамгаалах салбарт тулгамдаж буй бас нэг асуудал бол цэргийн насны залуучуудын төлөвшил, үзэл бодол, сэтгэлгээ нь цэргийн хөдөлмөрийн онцлогтой зөрчилдөж, хувь хүний зан чанарын онцлог зэргээс шалтгаалан цэргийн албанаас шантрах, цэргийн алба хаагчийн эрх зөрчигдөх, сахилга дэг журмын зөрчил, гэмт хэрэгт холбогдох зэрэг асуудал юм. Үүнийг боловсролын салбарт хүний эрхийн сургалтыг түлхүү явуулдаг ч эх оронч, үндэсний үзэл суулгах, үүрэг хариуцлагаа ухамсарлах чиглэлийн болон биеийн тамир, спортын сургалт, хөтөлбөр орхигдсон, хангалтгүй хэрэгждэг, техник технологийн хөгжлөө дагаад залуусын сонирхол өөрчлөгдсөн, Монгол Улсын ядуурлын түвшин өндөр 3 хүн тутмын 1 нь ядуу байгаа зэрэг боловсрол, нийгмийн тогтолцооны асуудлууд үүссэн, энэ нь цэргийн насны

залуусын төлөвшил, бие даах чадварт сөргөөр нөлөөлж байгаатай холбож болох байна. Иймээс цэргийн албаны болон сургалт, бэлтгэлийн онцлогтой уялдуулан зэвсэг, байлдааны техник, хэрэгсэлтэй харьцаж буй хугацаат цэргийн алба хаагчдын дунд дунд хот, хөдөөгийн, боловсролын болон бие бялдрын ялгаатай байдал үүсч үүнээс үүдсэн сэтгэл санааны хямралд орох цаашлаад зөрчил, гэмт хэрэг гарах нөхцөл бүрдэх эрсдэл байна.

6. Хэдийгээр хугацаат цэргийн алба хаах, цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүргээ хэрэгжүүлэхдээ хойрго хандаж байгаа боловч хугацаат цэргийн алба хаагчдын дийлэнх олонх нь буюу 90 орчим хувь нь цэргийн алба хааснаар эх орноо батлан хамгаалах мэдлэг олж авахаас гадна хувь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн тал дээр давуу байдал бий болно гэдэгт итгэдэг байна.

ЦАтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
3	7 дугаар зүйл. Хугацаат цэргийн алба	7.5.Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангана.	Ажил олгогч нь байнгын ажлын байранд хөдөлмөр эрхэлж байгаад хугацаат цэргийн албанд татагдсан ажилтнаа эргүүлэн авч ажиллуулна.

Судалсан байдал

ЦАтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангах” үүрэгтэй болохыг 2016 онд баталсан хуульд шинээр нэмж тусгасан. Энэ зохицуулалт нь ажил, хөдөлмөр эрхэлж байгаад хугацаат цэргийн албанд татагдсан иргэн халагдсаны дараа үргэлжлүүлэн ажлын байрандаа ажиллах боломжийг олгох зорилготой.

Иймээс 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан эрх зүйн зохицуулалтын үр дагаврыг тооцохдоо “Ажил олгогч нь байнгын ажлын байранд хөдөлмөр эрхэлж байгаад хугацаат цэргийн албанд татагдсан ажилтнаа цэргийн албанаас халагдсаны дараа эргүүлэн авч ажиллуулна” гэх томъёоллын хүрээнд “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу судалсан болно.

ЦАтХ-ийн 7 дугаар зүйлээр хугацаат цэргийн алба хаах харилцааг зохицуулсан. Үүнээс харахад ЦАтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт тусгасан эрх зүйн зохицуулалт нь зөвхөн хугацаат цэргийн алба хаах хугацаанд ажил олгогч тухайн алба хаагчийн ажлын байрыг хадгалах үүрэг болохоос цалин олгох, холбогдох татвараас хөнгөлөх, чөлөөлөх, аливаа төрлийн урамшуулал олгох зэрэг ойлголтыг агуулахгүй юм.

Хугацаат цэргийн алба хаагчийн нийт алба хаах хугацаа нь 12 сар байх²⁹ бөгөөд онцгой нөхцөл бий болсон үед Монгол Улсын Ерөнхийлөгч буюу зэвсэгт хүчний ерөнхий

²⁹ ЦАтХуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг

командлагч гурав хүртэл сараар хугацааг сунгах боломжтой³⁰ бол цэргийн албаа үлгэр жишээчээр хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчийг хугацаа дуусахаас гурван сарын өмнө бэлтгэлээр халж болохоор³¹ байна. Энэ нь хугацаат цэргийн алба хаагч 9-15 сарын хугацаанд цэргийн алба хаах боломжтойг илэрхийлнэ.

Хууль тогтоомжид зааснаар цэргийн алба хаах насны дээд хязгаар 27 байх бөгөөд цэрэгт татагдах боломжтой нас нь 18–25 нас. Иймээс 18-25 насны иргэнийг ажиллуулж байгаа байгууллагад ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан зохицуулалт үйлчилнэ. Гэхдээ энэхүү хуулийн заалт төрийн байгууллагуудын хувьд илүү хэрэгждэг бол хувийн хэвшилд төдийлөн хэрэгждэггүй. Энэ зохицуулалтын хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэхэд шаардагдах судалгаа мэдээлэл, статистик одоогоор байхгүй байна. Тухайлбал, Монгол Улсын шүүхийн цахим санд “Цэргийн албаны тухай хуулийн 7” гэх түлхүүр үгээр хайлт хийж үзэхэд цэргээс халагдаад ирэхэд нь ажлын байрыг нь хадгалаагүйгээс захиргааны хэргийн шүүхэд хандсан тохиолдол гараагүй байна.³² Харин цэргийн алба хаасан 1 жилийн хугацааг хөдөлмөр эрхэлсэнд жилийн хугацаанд оруулан тооцоогүй тухайд 1 маргаан үүсгэсэн байдаг байна.

Түүнчлэн 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлд ажилтан ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг хэвээр хадгалах тухай зохицуулалт бий. Үүнд зааснаар “цэргийн зарлан дуудах хуудас авсан ажилтныг цэргийн жинхэнэ албанд татсан тухай цэрэг татлагын комиссын шийдвэр гартал”³³ ажлын байрыг нь хадгалах үүрэг хүлээлгэсэн. Харин Хөдөлмөрийн тухай хуульд ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан ажлын байр хадгалах тухай зохицуулалтыг нэмж тусгаагүй нь уг хуулийн дагуу хугацаат цэргийн алба хаагчийн ажлын байрыг хадгалах тухай хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байх нэг шалтгаан байх боломжтой байна.

Монгол Улсын хэмжээнд 2021 оны 1 сарын байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн 5210, Монгол Улсын иргэний хувийн хэвшлийн 81862, гадаадын хөрөнгө оруулалттай 942 аж ахуйн нэгж, байгууллага³⁴ үйл ажиллагаа явуулж байна. 2019 онд хийгдсэн судалгаанаас³⁵ харахад ажил олгогчид сүүлийн 12 сард давхардсан тоогоор 89.1 мянган ажиллагчдыг ажлын байраар хангасан бол мөн хугацаанд 59.8 мянган иргэд ажлаас гарсан байна. Ерөнхийдөө ажил олгогчид шинээр ажилтан авч ажиллуулахад хамгийн их тохиолддог бэрхшээлд дараах шалтгаануудыг дурдсан. Үүнд, 18.8 хувийг ажиллагч тогтвортой ажиллах хүсэлгүй байх, 15.0 хувийг тухайн ажил хайгчийн ажлын туршлагагүй байдал, 14.5 хувийг ажлын ачаалал даах чадваргүй байдал, 13.9 хувийг ажлын байрны нөхцөл, цалин хөлс голдог гэсэн бэрхшээлүүд эзэлж байгаа нь нийт бэрхшээлийн 62.2 хувийг

³⁰ ЦАТХуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг

³¹ Цэргийн албаны тухай хуулийн 15.3

³² Монгол Улсын шүүхийн цахим сан. Эх сурвалж: <http://new.shuukh.mn/zahirgaaanhan>

³³ Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1.6-д

³⁴ Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог өмчийн хэлбэр болон ажиллагчдын тооны бүлгээр харуулсан статистик. Эх сурвалж. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2600_008V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_5&01_select_all=0&01SingleSelect=_2_3_4&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202101_202001&viewtype=table

³⁵ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. 2019 он. Эх сурвалж: https://mlsp.gov.mn/uploads/files/Final_Report_Barometr_2019_MON.pdf

бүрдүүлж байна. Үүнээс харахад ажил хайгч иргэн тогтвортой ажиллах хүсэлгүй байх, ажлын хангалттай туршлагагүй байдал нь ажил олгогчдод шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл болдог байна. Эдгээр шалтгаанууд нь тодорхой мэргэжил эзэмшээгүй, тогтмол ажил эрхлэх тухайд төлөвшөөгүй цэргийн насны залууст илүү хамааралтай байна. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн ажилгүй иргэдийн 20.9 хувь нь 15-24 насны, 36.5 хувь нь буюу хамгийн их нь 25-34 насны, 24.1 хувь нь 35-44 насных байна. Үүнээс харахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн 20 гаруй хувь нь цэргийн насны, 40 орчим хувь нь цэргийн наснаас хэтэрсэн ид хөдөлмөрлөх насны иргэд байна.³⁶


Хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар 2019, 2020 онд хамгийн их эрэлттэй мэргэжилд мотоцикл, машины засварчин, барилгын засалчин, шаварчин зэрэг мэргэжил бүхий хүн, барилгын туслах ажилтан, жолооч, хамгаалагч, цахилгаанчин, механикч зэрэг мэргэжлүүд орсон байна. Иймээс ЗХЖШ, аймаг, нийслэлийн цэргийн штабын зүгээс Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран хугацаат цэргийн алба хаагчдыг мэргэжил олгох сургалтад хамруулах, мэргэжил эзэмшсэн цэргийн алба хаагчдыг ажлын байранд зуучлах зэрэг ажлыг хэрэгжүүлдэг байна.

Нийслэлийн цэргийн штабаас цэрэг халагдах үеэр нээлттэй ажлын байрны өдөрлөг зохион байгуулдаг. Хугацаат цэргийн албанаас халагдаад ирсэн залуусаа бүртгэлд оруулаад нээлттэй ажлын байруудыг санал болгодог. Цэргээс ирсэн залуусаас дотоодын цэрэг, цагдаа, харуул хамгаалалт, барилгын зэрэг салбаруудад ажилд орсон байгаа.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр

ЦАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг гүйцэтгэхдээ хугацаат цэргийн алба хааж буй 40 хүнээс судалгаа авсан бөгөөд энэ нь тухайн цэргийн ангид хугацаат цэргийн алба хааж буй байлдагчдын 40 орчим хувийг эзлэх юм. Хугацаат цэргийн алба хаагчдаас авсан судалгаанаас харахад цэргийн алба хаагчдын 25 хувь нь ажлын байрандаа буцаж орж чадах эсэхээ “мэдэхгүй” байгаа бол 40 хувь нь “үгүй” гэж хариулжээ. Харин 35 хувь нь ажлын байрандаа эргэн орж чадна гэж хариулсан байна. Үүнээс харахад хугацаат цэргийн алба хаагчдын 65 гаруй хувь нь хуучин ажиллаж байсан байгууллагадаа эргэж ажиллах боломжтой эсэх нь тодорхойгүй болдог байна.

График № 7 Хугацаат цэргийн алба хаагчдын ажлын байрны баталгаа




³⁶ https://mlsp.gov.mn/uploads/files/Final_Report_Barometr_2019_MON.pdf

Хугацаат цэргийн алба хаагчдаас авсан судалгаанаас харахад цэргийн алба хаагчдын 25 хувь нь ажлын байрандаа буцаж орж чадах эсэхээ “мэдэхгүй” байгаа бол 40 хувь нь “үгүй” гэж хариулжээ. Харин 35 хувь нь ажлын байрандаа эргэн орж чадна гэж хариулсан байна. Үүнээс харахад цэргийн алба хаагчдын 65 гаруй хувь нь хуучин ажиллаж байсан байгууллагадаа эргэж ажиллах боломжтой эсэх нь тодорхойгүй болдог байна.


ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан аж ахуйн нэгж байгууллага цэргийн алба хаасан ажилтнаа ажлын байраар хангах тухай зохицуулалтад хамаарах асуултад 26 хугацаат цэргийн алба хаагч “үгүй” болон “мэдэхгүй” гэж хариулсан байна.

График № 8 Хугацаат цэргийн алба хаагчдын боловсролын түвшин



Ажлын байрандаа эргэж ажиллах боломжгүй буюу энэ тухай тодорхой мэдэхгүй байгаа хугацаат цэргийн алба хаагчдын 53 хувь нь бүрэн дунд боловсролтой, 23 хувь нь дээд боловсролтой, 15 хувь нь мэргэжлийн боловсролтой бол 0,7 хувь нь дунд ба түүнээс доош түвшний боловсролтой гэжээ.

График № 9 Хугацаат цэргийн алба хаагчдын ажиллаж байсан салбар



Харин өмнө ажиллаж байсан ажлын байрандаа эргэж ажиллах боломжгүй болон энэ тухай тодорхой мэдэхгүй байгаа хугацаат цэргийн алба хаагчийн ажиллаж байсан салбарыг авч үзвэл 30 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, 23 хувь нь их, дээд сургуулийн оюутан, 15 хувь нь ажилгүй буюу тогтмол ажилгүй иргэн байгаа бол 0,3 хувь буюу 1 хүн төрийн байгууллагад ажилладаг байна.

Үнэлсэн байдал

ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан “Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангана” гэсэн үүрэгжүүлсэн зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй буюу “Зорилгодоо хүрээгүй” гэж үзлээ.

ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор 40 хугацаат цэргийн алба хаагчаас анкетын судалгаа авахад 65 хувь нь цэрэгт явахаас өмнө ажиллаж байсан ажлын байрандаа эргэж ажиллах боломжгүй болон энэ тухай тодорхой мэдэхгүй гэж хариулснаас харахад хуулийн энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй 88,000 гаруй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд Үндсэн хуульд заасан журамт үүргээ биелүүлэн, хугацаат цэргийн алба хаасан ажилтнаа эргүүлэн ажлын байранд нь авч буй эсэхийг хянах, дүн бүртгэл хөтлөх тогтолцоо, нэгж хөдөлмөр, нийгмийн хамгаалал, улсын бүртгэл болон батлах хамгаалах салбарын хаана нь ч байхгүй байна.

Мөн хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй суурь хууль болох Хөдөлмөрийн тухай хуульд зөвхөн цэргийн зарлан дуудах хуудас авсан ажилтны ажлын байрыг цэргийн жинхэнэ албанд татсан тухай цэрэг татлагын комиссын шийдвэр гартал хадгалах зохицуулалттай бөгөөд 2016 онд батлагдсан ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангах” үүргийг нэмж оруулаагүй нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлж байна гэж үзлээ

Судалгааны дүнгээс харахад ерөнхийдөө ажлын байрандаа эргэж ажиллаж чадах эсэх нь тодорхойгүй гэж хариулсан хугацаат цэргийн алба хаагчдын 53 хувь нь бүрэн дунд, 23 хувь нь дээд боловсролтой байх ба 30 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад, 23 хувь нь их, дээд сургуулийн оюутан байсан бол 0,3 хувь нь төрийн байгууллагад ажиллаж байсан байна.

Үүнээс харахад бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байсан иргэд ажлын байрандаа эргэж ажиллах боломж хамгийн тааруу байгаа бол төрийн байгууллагуудын тухайд энэ заалтын хэрэгжилт хангалттай сайн гэж дүгнэж болох байна.

Мөн цэргийн алба хаасан иргэдийн дунд хуулиар олгогдсон эрхээ эдлэх, ЦАТХ-ийн уг заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хууль, шүүхийн байгууллагад хандахгүй байгаа нь уг заалтыг хаа хаанаа мөрдөхгүй байх нэг шалтгаан болж байна.

Харин батлан хамгаалах салбарын зүгээс хугацаат цэргийн алба хаагчдад цэргийн мэргэжил олгохоос гадна мэргэжлийн сургалтад хамруулах замаар тэдний хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг дээшлүүлж байгаа нь сайшаалтай байна.

ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	7 дугаар зүйл. Хугацаат цэргийн алба	7.7.Цэргийн сургуулиас бусад их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эрэгтэй суралцагч сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдаж болно.	Их, дээд сургууль, МСҮТ-ийн оюутнууд суралцах хугацаанд “Монгол Улсын Үндсэн хууль”-аар хүлээсэн “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” үүргээ биелүүлэх боломж бүрдэнэ.

Цэргийн албаны тухай хуулийн 7.7-д “Цэргийн сургуулиас бусад их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн /цаашид МСҮТ гэх/ эрэгтэй суралцагч сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдаж болно” гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 92 дугаар зарлигийг³⁷ хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын 2014 оны 40 дүгээр тогтоолоор³⁸ анх “Оюутан цэрэг хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд уг арга хэмжээг дэмжиж ажиллах тухай “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017-2021 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөр”³⁹-т мөн адил тусгагдсан нь энэ үйл ажиллагаа нийгэмд эрэлттэй байсныг илтгэж байна. “Оюутан цэрэг” хөтөлбөр 2014 оноос эхлэн хэрэгжсэн бөгөөд эхний хоёр жил хөтөлбөр хэлбэрээр явсан бол 2016 оноос эхлэн цэргийн мэргэжил олгох сургалт болж цэргийн алба хаах нэг хэлбэр болсон юм.

Иймээс “Цэргийн албаны тухай” хуулийг боловсруулахдаа “Оюутан цэрэг хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжиж байсан үйл ажиллагааг хуульчилснаар их, дээд сургуульд болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургуулийн эрэгтэй оюутныг цэргийн мэргэжил олгох сургалтад хамруулах замаар Үндсэн хуульд заасан Монгол Улсын иргэний журамт үүрэг болох “Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” заалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэн хуулийн төслийн Үзэл баримтлалд тусгасан байна. Иймээс Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 хэсгийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхдээ уг хэсгийг “Их, дээд сургууль, МСҮТ-ийн оюутнууд суралцах хугацаанд “Монгол Улсын Үндсэн хууль”-аар хүлээсэн “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” үүргээ биелүүлэх боломж бүрдэнэ.” гэж томъёолон “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэллээ.

Өнөөдрийн байдлаар “Оюутан цэрэг” сургалт явуулах эрх зүйн орчныг УИХ-аас 2016 онд баталсан Цэргийн албаны тухай хууль⁴⁰, ЗГ-ын 2014 оны “Хөтөлбөр батлах тухай” 40 дүгээр тогтоол⁴¹, ЗГ-ын 2017 оны Журам батлах тухай” 32 дугаар тогтоол⁴² тус тус бүрдүүлж байна. Оюутан, суралцагчдын хувьд Үндсэн хуульд заасан иргэний журамт үүргээ суралцаж байх хугацаандаа богино хугацааны эрчимжүүлсэн сургалтад хамрагдах замаар биелүүлэх нь

³⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг. 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдөр. Дугаар 92. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/9535>

³⁸ Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдөр. Дугаар 40 “Хөтөлбөр батлах тухай”. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/9807>

³⁹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 97 дугаар зарлигийн хавсралт “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017-2021 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөр”. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/8341?lawid=13253>

⁴⁰ Цэргийн албаны тухай хууль. Эх сурвалж: 2016. <https://legalinfo.mn/law/details/12124?lawid=12124>

⁴¹ Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдөр. Дугаар 40 “Хөтөлбөр батлах тухай”. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/9807>

⁴² ЗГ-ын 2017 оны Журам батлах тухай” Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/7619?lawid=12460>

цаашдын ажил, амьдралаа төлөвлөхөд чухал нөлөөтэй байдаг тул энэ сургалтад хамрагдах хүсэл, сонирхол өндөр байна.

Хуулийн дээрх зохицуулалт нь богино хугацаанд эрчимжүүлсэн сургалтаар цэргийн ерөнхий бэлтгэл болон цэргийн тусгай бэлтгэл эзэмших, цэргийн алба хаасанд тооцуулах нөхцөлийг бүрдүүлснээрээ оюутан залуучуудад шинэ боломж олгосон. Тодруулбал, оюутан цэрэг нь “Цэргийн ерөнхий бэлтгэл” хичээлийг 2 кредит, 96 цаг сонгон суралцдаг бол “Цэргийн тусгай бэлтгэл” сургалтад 12 кредит, 560 цаг, нийт 656 цагийн сургалтад хамрагдсанаар⁴³ “Цэргийн тангараг” өргөн дайчилгааны нөөцийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдэж, хугацаат цэргийн албыг хаасанд тооцогддог байна. Уг сургалтын хүрээнд 2015-2019 онд буюу таван жилийн хугацаанд нийт 60 гаруй их, дээд сургуулийн 5,000 гаруй оюутан, суралцагчийг “Оюутан-цэрэг” хөтөлбөр, сургалтад хамруулжээ.⁴⁴

Оюутан цэрэг сургалт нь богино хугацаанд хэрэгждэг, зөвхөн цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагддаг гэдгээрээ хугацаат цэргийн албанаас ялгагдана. Сургалтыг “Хүний ёсоор хандаж, цэргийн ёсоор сургана” гэх жанжин зарчмаар явуулдаг бөгөөд уг сургалтад хамрагдаж буй цэргүүд жигд маш сайн суралцдаг, зан авир, харилцааны хувьд ямар нэг асуудал гаргадаггүй, хот хөдөөгийн ялгаа үүсдэггүй нь цэргийн алба хаагчдын сэтгэгдэл өндөр байх нэг шалтгаан болдог байна. Үүнд сургалтыг зохион байгуулж буй арга хэлбэр ч нөлөөтэй юм. Тухайлбал, оюутан цэргийг 25-аар нь нэг салаа болгодог. Ингэхдээ 1 салаанд 25 өөр сургуулийн нэг нэг оюутныг оруулдаг. Энэ нь нэг сургууль, нэг нутгаараа ялгарахаас сэргийлсэн арга хэмжээ юм.

Түүнчлэн цэргийн сургалтыг богино хугацаанд эзэмжүүлэхэд оюутан, суралцагчдыг цэргийн албаны харуул манаа, аж ахуйн ажил зэрэг хугацаат цэргийн албан хаагчийн гүйцэтгэдэг ажил хөдөлмөрийг эрхлүүлэхгүйгээр ЗХЖШ-ын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зөвхөн 11 төрлийн цэргийн мэргэжлийг онол, дадлагын сургалтад хамруулдаг нь цэргийн алба хаах энэхүү шинэ төрөл залуусын дунд нэр хүндтэй байхад нөлөөлж байна.

"Орчин үед цаг хугацааны болон мэдлэг, чадварын үнэ цэнэ улам бүр нэмэгдэж байна. Оюутан залуус сонгосон мэргэжлээ эзэмшин суралцахын зэрэгцээ цэргийн алба хаах үүргээ давхар биелүүлэх нь хувь хүндээ наалдацтай ховор боломж төдийгүй улс орны батлан хамгаалах чадварыг бэхжүүлэх, цэргийн хэргийн мэдлэг, чадвартай иргэн болж бэлтгэгдэж байгаа нь нэн ач холбогдолтой юм" БСШУС-ын сайд асан Ё.Баатарбилэг.⁴⁵

⁴³ “Цэргийн ерөнхий бэлтгэл” хичээлд дөрөвдүгээр сарын 1-нээс эхлэн хоёр сарын тэнхимийн сургалтад бямба, ням гарагуудад хамрагдах, “Цэргийн тусгай бэлтгэл” сургалтаар карантенд хоёр сар дадлага, сургуулилт хийдэг.

⁴⁴ Цэргийн алба хаах боломжит хувилбарууд. 2019.04.18 Эх сурвалж: <https://legalinfo.mn/details/1105>

⁴⁵ Оюутан цэргүүд тангаргаа өргөн, халагдлаа. 2019-08-18. Эх сурвалж: <https://news.mn/r/2182374/>

Цэргийн мэргэжил олгох “Оюутан цэрэг” сургалтад хамрагдахад тодорхой шаардлага хангасан байх⁴⁶ эрх зүйн зохицуулалт хэрэгждэг. Тухайлбал, цэргийн сургуулиас бусад магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн нэгдүгээр дамжааны эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эрэгтэй суралцагч сурч байх хугацаандаа “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдан цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгүүлэх эрхтэй бөгөөд 18 насанд хүрсэн байх, голч оноо 2.8-аас дээш байх, сайн дурын үндсэн дээр хамрагдах хүсэлтээ хугацаандаа багтаж гаргасан байх⁴⁷, төлбөрийн 2 багц цагийн төлбөр төлсөн байх зэрэг шаардлагуудаас гадна бие бялдрын болон эрүүл мэндийн шаардлага хангасан байх зэрэг шаардлагыг дурдаж болно.

Суралцаж байх хугацаандаа цэргийн сургалтад хамрагдах хүсэлтэй оюутан, суралцагчид их байдаг ч нэг жилд дунджаар 1000 гаруй оюутан цэрэг элсүүлэх боломжтой уг сургалтад хамрагдаж чадаагүй тухай гомдол цөөнгүй гардаг байна. Үүний шалтгааныг нэгдүгээрт, оюутан цэрэг элсүүлэх орон тооны хязгаараас хамааран журамд заасан шаардлага хангасан ч хамрагдаж чаддаггүй, хоёрдугаарт, оюутан цэрэгт элсүүлэх үйл явц сургууль бүхэнд харилцан адилгүй байдаг, сонгон шалгаруулалт ил тод бус байдгаас үүддэг байна.

“Эрэлт хэрэгцээгээ дагаад тус сургалтын бүртгэл, хамрагдалт шударга бус байдаг гэж үзэх хүн бий. “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах байдлыг сургуулиар дамжуулалгүйгээр, олон нийтэд ил тод байдлаар явуулдаг болгохоор ажиллаж байгаа. “Оюутан цэрэг” сургалтад хамрагдаж чадаагүй ч цэргийн алба хаахыг хүсч байгаа хүн цэргийн алба хаах бусад хэлбэрээс сонгох боломжтой”.

*БХЯ-ны СБТГ-ын ахлах мэргэжилтэн С.Рагчаадорж*⁴⁸

Оюутан цэрэг хөтөлбөр хэрэгжүүлэх санаачлагыг анх Монголын Оюутны холбооны гаргаж МУ-ын Ерөнхийлөгч дэмжсэнээр эдүгээ 8 дахь жилдээ хэрэгжиж байна. Гэвч дэлхийн хэмжээнд нүүрлэсэн Ковид-19 цар тахлын улмаас сүүлийн 2 жилийн хугацаанд “Оюутан цэрэг” сургалт явагдаагүй учир оюутан, суралцагчид ЦАТХ-иар олгогдсон эрхээ эдлэх боломжгүй байна. Гэхдээ өнгөрсөн 2 жилд сургалтад хамрагдаагүй цэргүүдийн хувьд хугацаат цэргийн алба хаах боломж бий. Оюутан цэрэг сургалтад хамрагдахад заавал “1 дүгээр дамжааны оюутан байх” шаардлага тавигддаг нь зөвхөн 1 дүгээр дамжаа төгссөн зуны 2 сар ямар нэг дадлагын хичээл ордоггүйтэй холбоотой.

Оюутан цэрэг сургалтын ерөнхий зохицуулагчаар БХСайдын тушаалаар Батлан хамгаалахын их сургуулийн зөвлөх профессор, хурандаа Л.Мягмаржав ажилладаг бөгөөд оюутан сурагчдын дунд цэргийн албыг сурталчлах, эх оронч сэтгэлгээ суулгах нөлөөллийн

⁴⁶ “Оюутан-цэрэг”-т Цэргийн мэргэжил олгох сургалтын журам. ЗГ-ын 2017 оны 32 дугаар тогтоол “Журам батлах тухай. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/7619?lawid=12460>

⁴⁷ Журмын 2.1. “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдах хүсэлтэй оюутан, суралцагч тухайн жилийн 3 дугаар сарын 10-ны дотор суралцаж байгаа сургалтын байгууллага нь орших аймаг, нийслэл, дүүргийн Цэргийн штабт бүртгүүлнэ. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/7619?lawid=12460>

⁴⁸ “Оюутан цэрэг”-т бүртгүүлэхэд юуг анхаарах вэ?
2019-02-26 <https://news.mn/r/2093551/>

ажлыг Оюутан цэрэг ТББ-тай хамтран хэрэгжүүлдэг. Ерөнхийдөө залуусын дунд Оюутан цэрэг сургалтын нэгэн адил богино хугацааны, цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулах эрэлт нийгэмд их байгааг илэрхийлж байна.

Оюутан цэрэгт хамрагдаж чадаагүй талаар санал, гомдол оюутнуудын зүгээс маш их гардаг. Гэвч бид төсөв, нөөц бололцоондоо суурилан энэ тоог нэмэх боломжгүй. Харин зарим их, дээд сургуулиудын удирлагын зүгээс оюутнуудынхаа цэргийн зардлыг даагаад цэрэгт хамруулах санал гаргадаг. Энэ саналыг бодолцож үзэх хэрэгтэй санагддаг. Мөн залуусыг нээлттэй, олон хэлбэрээр цэргийн албаны сургалтад хамруулах нь эргээд цэргийн алба хаах, дайчилгааны бэлтгэл хангахад чухал үүрэгтэй гэж хардаг.

Оюутан цэрэг сургалтын ерөнхий зохицуулагч, хурандаа Л.Мягмаржав

Үнэлсэн байдал

Цэргийн албаны тухай хуулийн хуулийн 7.7-д “Цэргийн сургуулиас бусад их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн /цаашид МСҮТ гэх/ эрэгтэй суралцагч сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдаж болно” гэх зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлж үзэхэд уг хуулийн зохицуулалт нь нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тодорхой үр дүнд хүрсэн тул **зорилгодоо хүрсэн** байна.

Харин хууль хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагуудын зүгээс хуулийн хэрэгжилтийг тогтмол байлгах, шударга, ил тод зохион байгуулах үүднээс “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах оюутан, сурагчдын сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, нийтэд ойлгомжтой байдлаар зохион байгуулах, нийтийг хамарсан цар тахал, гамшгийн үед сургалт зохион байгуулах талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	16 дугаар зүйл. Тайван цагт хугацаат цэргийн албанд татахаас чөлөөлөх	16.1.Иргэнийг хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас дараахь үндэслэлээр чөлөөлнө: 16.1.1.эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдсон; 16.1.2.цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан; 16.1.3.эхнэр нь хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон.	Хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэл хууль тогтоомжид нийцсэн, бодит шаардлагад тулгуурласан байна

Судалсан байдал

ЦАТХ-ийн 16 дугаар зүйлд хугацаат цэргийн албанаас чөлөөлөх тухай зохицуулалтыг тусгажээ. Энд зааснаар цэргийн үүрэгтнийг эрүүл мэндийн шалтгаантай бол, цэргийн

дүйцүүлэх алба хааж буй болон хаасан бол, мөн эхнэр нь хөгжлийн бэрхшээлтэй бол гэх 3 үндэслэлээр цэргийн албанаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалт үйлчилж байна.

ЦАтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийг “Хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэл хууль тогтоомжид нийцсэн, бодит шаардлагад тулгуурласан байна” гэх томъёоллын хүрээнд “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээнд дээрх зохицуулалттай холбогдуулан хоёр сэдвийг хөндөнө. Үүнд: хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэлд нэмэлт оруулах эсхүл хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэл бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдөж байгаа эсэхийг тодруулахыг зорьлоо.

2019 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 107075 хүн хөгжлийн бэрхшээлтэй байгаагаас 0-4 насны 1976 хүүхэд, 5-9 насны 3727 хүүхэд байх ба тэдгээрийн 80 гаруй хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй гэсэн судалгаа гарчээ.⁴⁹

Монгол Улсын Их Хурал Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид НҮБ гэх)-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг⁵⁰ 1990 онд, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг⁵¹ 2008 онд тус тус соёрхон баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн эрхийг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээж байгаа билээ. Манай улс 2016 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамаарах эрх зүйн орчныг боловсронгуй болгосон хууль тогтоомжийг баталсан. Мөн Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”⁵² буюу дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулан хэрэгжүүлж байна.

НҮБ-ын ерөнхий ассамблейгаас баталсан, Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн Эрхийн Конвенцид “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь **тусгай халамж** болон ижил тэгш харьцааг хүлээн авах эрхтэй, боловсрол бол хүний үндсэн эрх, хүүхэд бүр өөрийн онцлогт тохирсон орчноор хангагдах эрхтэй хэмээн заасан.” байдаг. Иймд эдгээр тусгай халамж шаардлагатай бага насны хүүхэдтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор ЦАтХ-ийн 16 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй иргэнийг хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх тухай заалтыг нэмж оруулах шаардлагатай байна. Дээрх нөхцөл байдлыг харгалзан батлан хамгаалах салбараас бусад, тухайлбал боловсрол, нийгмийн халамж, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарт бага

⁴⁹ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. 2020 он. Эх сурвалж: https://mlsp.gov.mn/uploads/files/hbi_nom2020.pdf

⁵⁰ Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1990 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/1276>

⁵¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц. 2008 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/10034>

⁵² Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. 2017 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/8134?lawid=13031>


насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийг зохицуулсан эрх зүйн орчин сайжирч байгаатай уялдуулан тусгай халамж шаардлагатай хүүхдийн эцгийг хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас бүрмөсөн чөлөөлөх боломж олгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзлээ.

ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т “цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан,” тохиолдолд хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлнө гэж заасан байна.

Энэ хуулийн 3 дугаар зүйлд “цэргийн дүйцүүлэх алба” гэж Монгол Улсын иргэн шашин шүтлэг, ёс зүйн болон энэ хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн албыг дүйцүүлэн хаахыг;”⁵³ ойлгох ба Засгийн газар баталсан журмын дагуу зохион байгуулна.

Цэргийн дүйцүүлэх алба нь биеэр дүйцүүлэх болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах гэсэн хоёр хэлбэртэй⁵⁴ байна. Монгол Улсын иргэн шашин шүтлэг, ёс зүйн болон хуульд заасан бусад шалтгаанаар биеэр дүйцүүлэн хааж болох⁵⁵ ба хугацааны хувьд 24 сар байна. Харин хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаах⁵⁶ эрх зүйн зохицуулалттай.

Цэргийн 032 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж буй цэргүүдийн төлөөллөөс авсан анкетын судалгааны дүнгээс харахад цэргийн насны залуусын дийлэнх нь цэргийн албыг дүйцүүлэн хаах талаар мэдлэггүй байна.



Үүнээс харахад судалгаанд хамрагдсан цэргүүдийн 45 хувь нь дүйцүүлэх албаны талаар огт мэдээлэлгүй, 47,5 хувь нь бүрэн бус мэдээлэлтэй байгаа бол 1 хүрэхгүй хувь нь мэдээлэл сайтай байна. Энэ нь цэргийн насны залуучууд хугацаат цэргийн албыг дүйцүүлэн хаах талаар мэдээлэлгүй байгааг харуулж байна. Харин хэрэв цэргийн албыг дүйцүүлэн хаах боломж гарсан тохиолдолд дүйцүүлэн хаах 2 хэлбэрийн алийг нь илүү сонгох талаар тавьсан асуултад 52,5 хувь нь мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах, 47,5 хувь нь биеэр дүйцүүлэн хаах байсан гэжээ.

Цэргийн дүйцүүлэх алба хаах 2 төрлийн ялгаатай байдлыг анзаарч үзвэл Засгийн газраас тогтоосон тоон хязгаарт⁵⁷ багтан цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэд “Бие

⁵³ Цэргийн албаны тухай хууль. 2016 он. Эх сурвалж: <https://legalinfo.mn/law/details/12124?lawid=12124>

⁵⁴ ЦАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

⁵⁵ ЦАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

⁵⁶ ЦАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

⁵⁷ ЗГ-ын 2019 оны 249 дүгээр тогтоолоор 776, 2020 оны 336 дугаар тогтоолоор 824, 2021 оны 72 дугаар тогтоолоор 810 иргэний цэргийн дүйцүүлэх алба хаалгахаар дээд хязгаар тогтоож байжээ. Цэргийн дүйцүүлэх

бэлдрын бэлтгэл”, “Батлан хамгаалах хууль тогтоомж, цэрэг эх оронч хүмүүжил”, “Жагсаалын бэлтгэл”, “Үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх бэлтгэл”, “Талын бэлтгэл” зэрэг хичээлүүд багтсан тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөр, хичээлийн хуваарийн дагуу цэргийн сургалт бэлтгэлийн стандартад нийцсэн онол, дадлагын сургалтад хамрагддаг, мөн аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штабын шийдвэрээр гамшгаас хамгаалах, хил хамгаалалтад туслах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцох⁵⁸ зэргээр цэргийн мэдлэг эзэмшин цэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдэнэ.

Түүнчлэн ЦАТХ-ийн 30.6-д “Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний албанд цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр хоёроос дээш жил алба хаасан төрийн тусгай алба хаагчийг цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасанд тооцож, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ” гэж, мөн Засгийн газраас баталсан алслагдсан сумдын жагсаалтад⁵⁹ багтсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшаар гурван жил ажилласан иргэнийг цэргийн дүйцүүлэх албыг хаасанд тооцож, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ гэж тус тус заасны дагуу дээр дурдсан газар, байгууллагуудад цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр ажилладаг хүн бүр цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасанд тооцогдох боломжтой юм.

Цэргийн албыг дүйцүүлэн хаасан цэргийн бэлтгэл үүрэгтэн нь цэргийн алба хаасанд тооцогддог тул хугацаат цэргийн албаны цэрэг татлагад дууддаггүй, цэргийн зарлан ч хүргүүлдэггүй. ХУД-ийн Цэргийн штаб. Насанбат

Харин хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө Засгийн газраас тогтоосон үндсэн хэмжээнээс өөрт ногдох хэмжээний мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн албыг дүйцүүлэх нь цэргийн алба хаах насны дээд хязгаар хэтэрсэн иргэдэд нэг төрлийн торгуулийн арга хэмжээ хэлбэрээр хэрэгждэг гэж үзэж болох байна.

Дээрхээс харахад цэргийн албыг дүйцүүлэн хааж буй Монгол Улсын иргэн ЦАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.6⁶⁰, 30.7⁶¹ болон 31 дүгээр зүйлийн 31.3⁶²-т үндэслэн цэргийн алба хаасанд тооцогдож цэргийн бүртгэлд цэргийн бэлтгэл үүрэгнээр бүртгэгдэж байна. Гэтэл ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т “цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан,” тохиолдолд хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлнө гэж заасан нь ЦАТХ-ийн 30

алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/11206?lawid=15565>

⁵⁸ ЦАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг

⁵⁹ Засгийн газрын 2009 оны 246 дугаар тогтоолоор 18 аймгийн 75 сум энэ жагсаалтад багтсан. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 246 дугаар тогтоолын хавсралт. Эмч, багш нарыг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцох алслагдсан сумдын жагсаалт. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/2674>

⁶⁰ 30.6.Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний албанд цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр хоёроос дээш жил алба хаасан төрийн тусгай алба хаагчийг цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасанд тооцож, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

⁶¹ 30.7.Захиргааны санаачилгаар буюу өөрийн хүсэлтээр алслагдсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшаар гурван жил ажилласан иргэнийг цэргийн дүйцүүлэх албыг хаасанд тооцож, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

⁶² 31.3.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэнийг цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

дугаар зүйлийн 30.6, 30.7 болон 31 дүгээр зүйлийн 31.3-аар зохицуулсан харилцааг давхардуулан тусгасан байх тул энэ заалтыг хасах нь зүйтэй гэж үзлээ.

Үнэлсэн байдал

ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийг “Хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэл хууль тогтоомжид нийцсэн, бодит шаардлагад тулгуурласан байна” гэх томъёоллын хүрээнд “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлэн **Зорилгодоо хүрсэн** гэж дүгнэсэн.

Гэхдээ Хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэлтэй холбогдуулан дараах асуудлууд байгааг хөндлөө. Үүнд:

ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т “эхнэр нь хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон” бол хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөхөөр заасан. Харин хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх, хүүхдийн асуудлыг орхигдуулсан байна. Иймээс Батлан хамгаалах салбарын зүгээс Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлага, дотоодын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд харилцан уялдаатай ажиллах үүднээс “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй” иргэнийг хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалт бий болгох боломжийг судлах шаардлагатай байна.

ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т “цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан,” тохиолдолд хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлнө гэж заасан нь ЦАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.6, 30.7 болон 31 дүгээр зүйлийн 31.3-аар зохицуулсан харилцааг давхардуулан тусгасан байх тул энэ заалтыг хасах эсэх асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай гэж үзлээ.

ЦАТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.2 дахь хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
	36 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	36.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 36.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Хууль тогтоомж зөрчсөн бол хариуцлага тооцох хариуцлага гарцаагүй хүлээлгэнэ.

Судалсан байдал

ЦАТХ-ийн 36 дугаар зүйл буюу энэ хуулийг зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг “Хууль тогтоомж зөрчсөн бол хариуцлага тооцох хариуцлага гарцаагүй хүлээлгэнэ” гэх томъёоллын хүрээнд “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Цэргийн албаны холбогдох хууль тогтоомжийг сахин биелүүлээгүйн улмаас хуулийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг цэргийн бүртгэлд холбогдох хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд болон цэргийн жинхэнэ албан хаагч хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваан авч үзлээ.

Цэргийн бүртгэлд хамаарах асуудлын тухайд

Монгол Улсын 18 насанд хүрсэн эрэгтэй иргэн бүр Үндсэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн алба хаах журамт үүрэгтэй. Харин энэхүү үүргээс зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөгдөх боломжтой. Цэргийн бүртгэлд ЦАТХ-ийн 16.1-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн, цэргийн жинхэнэ алба хааж байгаа, ял эдэлж байгаа иргэн хамрагдахгүй. Тиймээс эдгээр тохиолдлоос бусад цэргийн бүртгэлд хамрагдах иргэн нутгийн захиргааны анхан шатны нэгж /баг, хороо/-ийн байранд тогтоосон хугацаанд ирж цэргийн бүртгэлд хамрагдах, цэргийн үүрэгтний үнэмлэхийг хаяж, үрэгдүүлэхгүй байх, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нөхөж авах, цэрэг татлагын үеэр гурван сараас дээш хугацаагаар гадаад улсад зорчих бол энэ тухайгаа мэдэгдэх, өөр газар шилжин суурьших тохиолдолд тухайн оршин суугаа газрынхаа цэргийн бүртгэлээс хасуулж, шилжин очсон газраа цэргийн бүртгэлд бүртгүүлэх зэрэг үүргийг хүлээдэг байна.

Цэргийн үүрэгтний сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” бодлогын баримт бичгийн 5.5-д “Эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгоно. Цэргийн албыг биеэр болон хуульд заасан бусад хэлбэрээр хаагаагүй иргэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Төрийн албанд анх орж байгаа иргэнд цэргийн алба хаасан байх шаардлага тавина.” гэж заажээ.

ЦАТХууль тогтоомжид заасан цэргийн бүртгэлд хамрагдах үүргээ зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн⁶³ 15 дугаар зүйлийн 15.17-д “Зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр, товлосон газарт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”, мөн “Цэргийн бүртгэлийн журам зөрчсөн, эсхүл дайчилгаатай сургууль, цугларалт, цэрэг татлагаас зайлсхийсэн цэргийн үүрэгтэн, цэргийн насны иргэнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж тус тус заасан байна.

Үүнээс харахад цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд ирээгүй, эсхүл цэргийн бүртгэлийн журам зөрчсөн тохиолдолд 100,000-150,000 төгрөгийн торгууль оногдуулж байгаа бөгөөд ЦАТХ зөрчсөний улмаас Зөрчлийн хуулиар хэрэг үүсгэж, шийдвэрлэсэн хэргийн талаарх тоо мэдээлэл Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон Шүүхийн шийдвэрийн мэдээллийн нэгдсэн санд байхгүй байна.

Цэргийн насны залуусын ихэнх нь хуулиа мэддэггүй. Үүнээс болоод асуудал их гардаг. Үүн дээр нэмээд цэргийн бүртгэлд хамрагдаагүй иргэнд Зөрчлийн

⁶³ Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 он. Жх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/12695>

хуулиар хүлээлгэх хариуцлагын хэмжээ бага байна гэж боддог. Зарим нь “за тэр 150000-ыг чинь төлчихнө, аль дансруу хийхийн” гээд уурладаг.

Цэргийн бүртгэлд бид хамгийн багадаа л 18 настай, хууль эрх зүйн болон бусад бүх зүйлээрээ эрийн цээнд хүрсэн залуустай харьцах учиртай. Гэтэл бодит байдал дээр дандаа эмээгээ, ээж, аавыгаа дагуулсан залуус ирж байна. Ээж нь, эмээ нь гачигдал тоочоод хүүхдээ цэрэгт явуулахгүй гэдэг. Зарим тохиолдолд өөрсдөө ч ирдэггүй, өнөө л ээж нь, эмээ нь тэрний, энэний гэсэн хэд хэдэн цэргийн үүрэгтний үнэмлэх бариад ирдэг.

Нийслэлийн дүүргүүдийн Цэргийн штабын холбогдох албан тушаалтнуудтай хийсэн уулзалтаас

Манай улс 18-50 насны эрэгтэйчүүд болон цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд, цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг цэргийн бүртгэлд бүртгэдэг. Цэргийн бүртгэлд хамрагдах идэвх сул байдагтай холбоотойгоор цэргийн бүртгэлийн үйл ажиллагаанд багагүй хүндрэл гардаг байна. Энэ нь цэргийн бүртгэлд хамрагдаагүй иргэнд хүлээлгэх хуулийн хариуцлага сул байгаатай холбоотой гэж холбогдох албан тушаалтнууд үзэж байна. Цэргийн бүртгэл явуулах үйл ажиллагааны явцад цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтнүүдээс шалтгаалсан цөөнгүй асуудал гардгаас энэ судалгааны хүрээнд 4 асуудлыг онцолж байна. Үүнд:

- ЦАТХ-ийн 12.11-т “Цэрэг татлага явуулах тухай Засгийн газрын тогтоол нийтлэгдсэн өдрөөс эхлэн цэрэг татлагын хугацаа дуусах өдөр хүртэл цэргийн албанд татагдах насны иргэн тухайн нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад зорчихыг хориглоно” гэсэн заалт бий. Энэ заалтын хэрэгжилтийг хянах тогтолцоо байхгүй, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хооронд мэдээлэл солилцох боломжгүй, энэ заалтыг зөрчсөн тохиолдолд цэргийн албанд татагдах насны иргэнд болон эдгээр хүмүүсийг гадаадад зорчих боломжоор хангасан байгууллагуудад хүлээлгэх хариуцлага тодорхойгүй, өөрөөр хэлбэл байхгүй учир огт хэрэгждэггүй хуулийн зохицуулалт юм.

Гадаадад ажиллаж, сурч байгаа хүмүүс бол бүр бүртгүүлдэггүй. Энэ хүмүүсийг хаана байгаа, хэзээ ирэх талаар манайд мэдээлэл өгөх газар байдаггүй. Улсын бүртгэлийн байгууллагаас энэ төрлийн мэдээллийг авах боломжгүй тул бид баг, хорооны ажилтнуудын тусламжтайгаар тухайн хороонд хэдэн цэргийн насны хүн гадаадад байгаа талаар судалгаа гаргаж мэдээллийн сандаа баяжилт хийдэг.

ХУД-ийн Цэргийн штаб, хошууч Насанбат

- Мөн цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд хамруулах зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мөн л төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох боломж, цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн дунд ЦАТХ-д заасан эрх зүйн зохицуулалтын талаарх мэдлэггүй байдлаас үүдэн хүндрэл үүсдэг. Энэ нь цэрэгт шаардлагатай мэргэжлийн жагсаалт нийтэд ил тод бус, эмэгтэйчүүд цэргийн алба, цэргийн бүртгэлийг зөвхөн эрчүүдэд хамаарах асуудал гэж хардагтай холбоотой гэж үзэж байна. Түүнчлэн цэргийн бүртгэлд хамрагдаагүй эмэгтэйд хариуцлага хүлээлгэх

ямар ч эрх зүйн зохицуулалт байхгүйн зэрэгцээ ядаж энэ үүргээ биелүүлэхийг шаардах боломжгүй аж. Харин цэргийн байгууллагуудад ажиллаж байсан эмэгтэйчүүд энэ тал дээр хариуцлагатай ханддаг байна.

Цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд бүртгэхэд их хэцүү. Хорооны ажилтан, хэсгийн ахлагч нар энд, тэнд нэг тийм хүн бий гэж хэлээд ихэнхдээ утсаар холбогдон бүртгэдэг. Уг нь бол ХХААХҮЯ, ЭМЯ, ГХЯ гээд холбогдох төрийн байгууллагууд цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийнхээ мэдээллийг ЗХЖШ-тай солилцдог бол бүртгэл бүрэн төгс хийгдэхийн зэрэгцээ их амар байх боломжтой.

ЧД-ийн Цэргийн штаб, дэд хурандаа Цэдэн

- Цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтнүүдийн дунд гардаг бас нэг түгээмэл зөрчил бол Цэргийн үүрэгтний үнэмлэхийг үрэгдүүлэх асуудал юм. Цэргийн үүрэгтэн энэхүү үнэмлэхээ гээгдүүлсэн тохиолдолд 2000 төгрөг, 2 хувь цээж зурагтай байхад ямар нэг торгууль төлөхгүйгээр хэдэн ч удаа нөхөж авах боломжтой байдаг нь баримт бичигт хайнга хандах гол шалтгаан болж байна. Гэтэл цэргийн алба хаасан иргэдийн Цэргийн үүрэгтний үнэмлэх дээрх мэргэжил, харьяалал тогтоох зорилготой шифрийг нөхөх боломжгүй байдаг байна.

Цэргийн үүрэгтний үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд иргэний үнэмлэх гээгдүүлсэнтэй адил торгууль төлдөг болох юм бол энэ үнэмлэхийг үрэгдүүлэхгүй байхад нөлөөлнө байх. Хэрэг гарахаар хайдаг, олохгүй бол шинээр авдаг. Одоо бол хэдийг л бол хэдийг өгч байна. Хаяна, угаана, урна гээд ямар ч албан бичигтэй харьцуулиггүй зовлон туулдаг. Уг нь бол цэргийн үүрэгтний үнэмлэх дээрх шифр маш чухал үүрэгтэй.

ХУД-ийн Цэргийн штаб, хошууч Насанбат

- Цэргийн бүртгэл хөтлөхөд гарч буй хамгийн том бэрхшээл нь шилжилт хөдөлгөөний асуудалтай холбоотой байна. Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх асуудлыг ЗГ-ын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам⁶⁴-аар зохицуулдаг. Уг журмын 2 дугаар зүйлд иргэний байнга оршин суух шилжилт хөдөлгөөнийг бүртгэх асуудлыг тусгасан. Журмын 2.1 дэх хэсэгт зааснаар иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суух иргэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19.1-д заасны дагуу 4 төрлийн баримт бичгийг бүрдүүлж, оршин суух сум, хорооныхоо улсын бүртгэгчид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд бүрдүүлэх баримт бичгийн нэг нь ЦАТХ-ийн 34.6.4-т заасны дагуу шилжин очсон газраа цэргийн бүртгэлд бүртгүүлсэн тэмдэглэгээ хийлгэсэн цэргийн үүрэгтний үнэмлэх байна. Харин сум, хорооны улсын бүртгэгч энэ журмын 2.1-д заасан баримт бичиг дутуу

⁶⁴ ЗГ-ын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/13744?lawid=13744>

эсхүл зөрчилтэй бол иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэхгүй⁶⁵ гэж тодорхой заасан. Гэвч зарим улсын бүртгэгч энэ зохицуулалтын талаар мэддэггүй, цэргийн үүрэгтний үнэмлэхгүйгээр бүртгэдэг. Ийм алдаа гаргасан улсын бүртгэгчид хүлээлгэх хариуцлага байхгүй, баримт бичгээ бүрдүүлээгүй хаягийн шилжилт хийсэн иргэнд ч мөн адил хариуцлага хүлээлгэдэггүй байна. Үүн дээр нэмээд сүүлийн үед шилжилт хөдөлгөөнийг цахимаар хийх боломж нээгдсэнтэй холбоотойгоор цэргийн бүртгэлд хамрагддаг иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хянах, улмаар цэргийн үүрэгтний бүртгэлд тогтмол шинэчлэл хийх үйл ажиллагаанд асуудал үүсч байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

Хан-Уул дүүрэг 21 хороотой. Зарим хороон дээр ажиллаж буй улсын бүртгэгчид шилжилт хөдөлгөөний бүртгэл хийхдээ цэргийн үүрэгтний үнэмлэх, түүн дээрх шилжилт хөдөлгөөний бичилтийг хянадаггүй. Үүнээс болоод дүүргийн Цэргийн штаб мэдэгдэхгүйгээр шилжилт хөдөлгөөн хийгдэж байна. Энэ нь эргээд цэргийн бүртгэлд нөхөн хангалт хийх асуудалд сөргөөр нөлөөлдөг. Ер нь улсын бүртгэлийн ажилтнуудад энэ чиглэлээр сургалт явуулж байх шаардлагатай гэж боддог.

Хан-Уул дүүргийн Цэргийн штаб. Хошууч Насанбат

Шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй буюу иргэд шилжилт хөдөлгөөн хийсэн даруйдаа шинэ хаягаа бүртгүүлдэггүй, банк санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх, нийгмийн халамж авах, цэцэрлэг, сургуулийн бүртгэл гэх зэрэг ямар нэг чухал шаардлага гараагүй бол бүртгэлээ шинэчилдэггүй. Үүнээс гадна сонгуулийн жилүүдэд “царцааны нүүдэл” болдог, сонгуулийн дараа ирсэн хаягнаасаа хасалт хийлгэхгүй “мартдаг”, энэ хүмүүсийн талаар хорооны ажилтнууд мэдээлэлгүй байдаг зэрэг нь цэргийн насныхныг цэргийн бүртгэлд бүрэн хамруулахад хүндрэл үүсгэж байна.

Түүнчлэн улсын бүртгэлийн байгууллагаас хугацаат цэргийн алба хаах насны буюу 18-25 насны эрэгтэйчүүдийн талаарх мэдээллийг Цэргийн штабуудад өгдөггүй тул нэгдсэн тоо мэдээлэл гаргах, бүртгэл хийхэд хүндрэлтэй байдаг байна.

Цэргийн бүртгэл зохион байгуулах анхдагч нэгж бол нийслэлийн 9 дүүргийн 173 хороо юм. Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас эдгээр хорооддоо цэргийн бүртгэл хийх програм хангамж хийж өгсөн. Цэргийн бүртгэлийн үед энэ програмаа ашиглаад бүртгэлдээ баяжилтаа хийгээд явдаг болсон.

НЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр

- Эцэст нь ЦАТХ-ийн 29 дүгээр зүйлд цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах нь цэргийн дүйцүүлэх албаны нэг төрөл гэж заасан бөгөөд хуулийн 29.3-т “Хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана” гэжээ. Гэвч хуулийн энэ заалтыг зөрчиж мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагаагүй иргэнд

⁶⁵ Журмын 2.5

хуулийн хариуцлага хүлээлгэх ямар ч эрх зүйн орчин байхгүй байгааг энд дурдах нь зүйтэй гэж үзлээ.

Цэргийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагын тухай

Цэргийн алба хаагчид хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дайчилгааны тухай зэрэг хууль тогтоомжуудад заасны дагуу Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга /цаашид ЭХ гэх/, Зөрчлийн тухай хууль /цаашид ЗтХ гэх/, Төрийн албаны тухай хууль /цаашид ТАтХ гэх/ иуд агуулж байна. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн 4 дүгээр хавсралтаар баталсан Цэргийн сахилгын дүрэм⁶⁶ болон бусад дотоод дүрэм, журам зөрчсөн тохиолдолд цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, хилийн ба дотоодын цэргийн командлагч, онцгой байдлын байгууллагын дарга болон төрлийн цэргийн командлагч, цэргийн анги, нэгтгэлийн удирдах албан тушаалтан шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалт хэрэгжиж байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний тухай хуульд зааснаар Зэвсэгт хүчний жанжин штабын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу албан тушаалын цол олгох, бууруулах, хураан авах, сахилга, ёс зүйн хариуцлага хүлээлгэх эрхтэй⁶⁷ бол сахилгын зөрчил гаргасан алба хаагчид захирагч, дарга зэрэг эрх бүхий албан тушаалтан нь сахилгын шийтгэл оногдуулна.⁶⁸

УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс бодлогын баримт бичгийн 7.4-т “Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь цэргийн нийтлэг дүрмүүдийг даган мөрдөж, цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээгээр олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасан. Харин сүүлийн үед эрхээ хэтрүүлсэн, үүргээ биелүүлээгүй цэргийн алба хаагч, албан тушаалтанд хариуцлага оногдуулах асуудал ихээр хөндөгдөх болсноос харахад цэргийн албаны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд онцгойлон анхаарч ажиллах шаардлага үүсжээ.

2015 онд батлагдсан ЭХ-д “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” гэж Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн, цэргийн дайчилгаа, сургууль, цугларалтад байгаа цэргийн үүрэгтэн энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно” гэж тодорхойлсон бөгөөд энэ төрлийн гэмт хэргийг гадаад улсад үйлдсэн цэргийн жинхэнэ алба хаагчид мөн адил ЭХ-ийн дагуу шийтгэл оногдуулах боломжтой.⁶⁹

⁶⁶ Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд. 2019 он. Эх сурвалж: http://www.internal-troops.police.gov.mn/media/huuli/tsereg_durem.pdf

⁶⁷ Зэвсэгт хүчний тухай (Шинэчилсэн найруулга) 15 дугаар зүйл. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын бүрэн эрх 2016 он <https://www.legalinfo.mn/law/details/12123>

⁶⁸ Цэргийн сахилгын дүрмийн 28 дугаар зүйл.

⁶⁹ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2015 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/11634> 1.6 дугаар зүйл. Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх. 3. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын цэргийн алба хаагчид энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ЭХ-ийн Тусгай ангийн 28 дугаар бүлэгт 19 төрлийн⁷⁰ “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг”-ийг тусгасан. Эдгээр гэмт хэрэгт ЭХ-иар хариуцлага хүлээлгэх ялын хэмжээ 6 сараас 1 жил хүртэл байх ба тухайн заалтын хүндрүүлэх нөхцөл⁷¹ бүрдсэн тохиолдолд ялын хэмжээ 1 жилээс 5 жил, 2 жилээс 8 жил, 12 жилээс 20 жил хүртэл нэмэгдэхээр байна. Дээрх цэргийн гэмт хэргүүдээс хамгийн хүнд ял эдлүүлэх зохицуулалттай цэргийн албаны эсрэг гэмт хэрэг нь Байлдааны талбарыг дур мэдэн орхисон бол 12 жилээс 20 жил, Сайн дураараа дайсанд бууж өгсөн бол 20 жил хүртэл ял шийтгэх зохицуулалттай байна.

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд⁷² хайлт хийж үзэхэд 2020 оны 1 сараас 2021 оны 6 сар хүртэлх хугацаанд ЭХ-ийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийтгэх тогтоол гаргасан 11 тохиолдол бүртгэгджээ. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хуулийн заалт бүрээр нь авч үзвэл өнгөрсөн 1,5 жилийн хугацаанд хамгийн олон үйлдэгдсэн нь цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэг байна.

Хүснэгт № 1 Шүүхийн шийдвэрийн цахим санд бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл, тоо

ЭХ-ийн зүйл, заалт	Гэмт хэргийн нэр	Тохиолдлын тоо
28.3	Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	3
28.5	Цэргийн албанаас оргон зайлах	4
28.7	Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших	1
28.10	Байлдааны машин жолоодох, ашиглалтын журам зөрчих	2
28.15	Хилийн алба хаах журам зөрчих	1
Нийт		11

Эх сурвалж: Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан

Харин ЭХ-ийн 4 дүгээр бүлгийн 4.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал буюу “цэргийн алба хаагч, хууль сахиулагч дээд шатны албан тушаалтны бичгээр, амаар өгсөн заавал биелүүлэх тушаал, даалгаврыг хууль бус болохыг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй бөгөөд хууль бус тушаал, даалгавар өгсөн албан тушаалтныг уг гэмт хэргийг үйлдсэн гүйцэтгэгчид тооцох” зохицуулалтаар дээр дурдсан 11 цэргийн албаны эсрэг

⁷⁰ Үүнд зааснаар Тушаал биелүүлэхгүй байх, Дарга, захирагчаа эсэргүүцэх, Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх, Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих, Цэргийн албанаас оргон зайлах, Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших, Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх, Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих, Байлдааны, сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих, Байлдааны жижүүр хийх журам зөрчих, Дотоод албаны журам зөрчих, Харуулын албаны журам зөрчих, Хилийн алба хаах журам зөрчих, Байлдааны талбарыг дур мэдэн орхих, дайсантай зэвсэг барьж байлдахаас зайлсхийх, Сайн дураараа дайсанд бууж өгөх, Байлдааны талбарт тонуул хийх, Байлдааны талбарт Улаан загалмайн тэмдгийг хууль бусаар зүүх, урвуулан ашиглах үйлдлийг гэмт хэрэгт тооцжээ.

⁷¹ Хүндрүүлэх нөхцөлд бүлэглэх, дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдэх; офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагч үйлдсэн, согтуугаар үйлдсэн; хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, хохирогч нас барсан, Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдалд ноцтой хохирол учруулсан зэрэг үйлдэл тооцогдоно.

⁷² Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан. Эх сурвалж: https://shuukh.mn/cases/2/1?item_id=50. Сүүлд нэвтэрсэн 2021.07.20

гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож, тушаал өгсөн албан тушаалтныг гэмт хэрэг үйлдсэнд тооцсон тохиолдол гараагүй байна.

Хүний эрхийн үндэсний комиссоос хүргүүлсэн зөвлөмж болон Монгол Улсын Их хурлын гишүүн С.Одонтуяагаас Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хүргүүлсэн 2021 оны 04 сарын 12-ны өдрийн “Асуулга тавих тухай” 15 тоот албан бичгийн /Хавсралт 4/ хүрээнд БХЯ-наас 2010 оноос хойш Батлан хамгаалах салбарын хэмжээнд гарсан хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан гэмт хэргийн талаар мэдээлэл боловсруулан хүргүүлсэн байна. Үүнд дурдсанаар Зэвсэгт хүчний 2011-2020 оны гэмт хэргийн статистик судалгаанаас харахад, тус салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчил, ёс зүйн зөрчлийн тоо 2018 оноос нэмэгдэж 2020 оноос хойш буурах хандлагатай байх ба сүүлийн 10 жилийн хугацаанд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт 12 төрлийн 54 гэмт хэрэг гэмт хэрэг бүртгэгдэж, нийт гэмт хэрэгт 78 цэргийн алба хаагч холбогдон шалгагдсан статистик гарчээ.⁷³

Хүснэгт № 2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэрэгт холбогдсон цэргийн алба хаагчдын тоо

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
Бүртгэгдсэн гэмт хэрэг	2	2	1	4	2	2	5	5	18	13	54
Холбогдсон хүний тоо	3	2	1	4	4	2	5	7	20	17	65

БХЯ-ны мэдээллээс

Хүснэгт № 3 Гэмт хэргийн төрөл, гэмт хэргийн тоо оноор

Гэмт хэргийн төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Анги, байрлалаа орхин оргон зайлсан	1	1								1
Хүний амь нас хохирсон	1		1		2				1	
Галт зэвсэг, галт хэрэглэлтэй холбоотой		1				1				
Бусдын бие махбодод гэмтэл учруулсан				4		1	2	2	2	4
Амиа хорлохыг завдсан							3			
Албан тушаалаа урвуулан ашигласан								1	1	
Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн								2	3	3
Хучиндэх									3	
Дээрэм									1	
Хууль бус ан агнах									3	
Хулгай									2	4
Цэргийн албаны эсрэг									2	1

БХЯ-ны мэдээллээс

Дээрх гэмт хэргүүдийн 5.5 хувь нь анги, байрлалаа орхин оргон зайлах, 9.2 хувь нь хүний амь нас хохироосон, 3.7 хувь нь галт зэвсэг, галт хэрэглэлтэй холбогдсон, 27.7 хувь нь бусдын бие махбодод гэмтэл учруулах, 5.5 хувь нь амиа хорлохыг завдсан, 3.7 хувь нь албан тушаалаа урвуулан ашигласан, 14.8 хувь нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй

⁷³ БХЯ-наас гаргасан мэдээлэл. 2021 он

байдал, ашиглалтын журам зөрчсөн, 5.5хувь нь хүчиндэх, 1.8 хувь нь дээрэм, 5.5 хувь нь хууль бус ан агнах, 11.1 хувь нь хулгай, 5.5 хувь нь цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд байна.

Энэхүү судалгаанд ашигласан Батлан хамгаалах яамнаас гаргасан статистик мэдээлэл, Шүүхий шийдвэрийн цахим сан дахь статистик мэдээллийн зөрүүтэй байдлыг салбарын яамнаас гаргасан мэдээллийн хамрах хугацаа өөр, цэргийн албаны гэмт хэргээс гадна цэргийн алба хаагч үйлдсэн бусад гэмт хэргийн мэдээлэл агуулагдсан зэргээс үүдэлтэй болно.

Зэвсэгт хүчний хэмжээнд 2016-2020 онд цэргийн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын ослын 90 тохиолдол бүртгэгдсэнээс, 48 хүн хөнгөн, 30 хүн хүндэвтэр гэмтэл авч, 12 хүн нас барсан /усанд живсэн-8, РГД-5 гранат тэсэрснээс-2, авто осол-2/байна. Үүнийг тухайн ослын шинж чанараар нь авч үзвэл дараах хүснэгтэд заасан байдалтай байна.⁷⁴

Хүснэгт № 4 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг осол, төрөл, тоо

№	Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол	Хөнгөн	Хүндэвтэр	Амь насаа алдсан
1	Санамсар болгоомжгүйгээс унах, бүдрэх, халтирах	19	3	
2	Эд зүйлд цохигдох, хавчуулагдах, дарагдах	10	5	
3	Хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн хийсний улмаас	6	3	
4	Галт зэвсэг, галт хэрэглэл, хортой бодистой буруу харьцах	4	15	2
5	Авто осолд орсон		4	2
6	Усанд живсэн			8
7	Бусад	9		
Дүн		48	30	12
Нийт		90		

БХЯ-ны мэдээллээс

Харин сүүлийн 3 жилийн байдлаар зэвсэгт хүчний салбарт гарсан осол, гэмтлийн улмаас хөнгөн, хүнд гэмтсэн болон амь насаа алдсан цэргийн алба хаагч болон энгийн ажилтны судалгаанаас харахад 2019 оны 1 сараас 2021 оны 4 сар хүртэлх хугацаанд Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэрэг болон дүрмийн бус харилцаанаас үүдэлтэй 2, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбогдолтой 6, авто ослоор 5, золгүйгээр буюу амиа хорлох, өвчний улмаас 8 цэргийн алба хаагч, 2 энгийн ажилтан амь насаа алджээ. Дурдсан хугацаанд гэмт хэргийн шинжтэй үйлдэл 3 гарсан бол Цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас 30 алба хаагч бэртэж гэмтсэн байна.⁷⁵

Хүснэгт № 5 Гэмт хэрэг, ослын төрөл, амь нас хохирсон тоо

Осол, гэмтлийн төрөл				2019	2020	2021.1
Амь нас эрсэдсэн гэмт хэрэг, осол	Гэмт хэрэг/ Дүрмийн бус харилцаа			1		1
	ХАБ-ын холбогдолтой осол			2	4	
	Авто осол			2	3	
	Золгүйгээр /амиа хорлох, өвчин/	ц/а хаагч	2	6		
		ажилтан	1	1		
Гэмт хэргийн шинжтэй үйлдэл				3		
Цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас гэмтсэн				8	20	2

БХЯ-ны мэдээллээс

⁷⁴ БХЯ-наас гаргасан мэдээлэл. 2021 он

⁷⁵ Батлан хамгаалах яамнаас гаргасан мэдээлэл. 2021 он

Дээрх мэдээллээс харахад Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд нуугдмал гэмт хэргүүд илэрч, гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлийн үзүүлэлт өсөх хандлагатай байна гэж БХЯ-ны зүгээс дүгнэжээ.

Зэвсэгт хүчний хэмжээнд гарч буй цэргийн алба хаагчтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгаа, мэдээлэл тодорхойгүй, нэгдсэн бүртгэлгүй байгаа нь 2000-аад оноос өмнө Зэвсэгт хүчинд хэрэг бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан Цэргийн хэрэг бүртгэх алба татан буугдсантай холбоотой байна. Тухайлбал, Зэвсэгт хүчинд бүртгэгдээгүй, өөрөөр хэлбэл, цэргийн алба хаагч цэргийн анги, байрлалаас гадна нийгмийн харилцаанд иргэний хувьд оролцож байхдаа үйлдсэн гэмт хэргүүд цагдаа, прокурор, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгддэг процессын онцлогоос хамаарч дүн бүртгэл зөрүүтэй гардаг байна.

“... 2010-2020 оны байдлаар зэвсэгт хүчний анги, байгууллагад 506 хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. Үүнээс өнөөдрийн байдлаар 92 хувийг нь шийдвэрлэсэн, 105 хэргийг нотлогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон. 506 хэргийн 10 орчим хувь нь ажлын байран дээр үйлдэгдсэн. Бусад нь зэвсэгт хүчний алба хаагчдын нийгмийн харилцаанд оролцох үед эсвэл ахуйн хүрээнд үйлдэгдсэн байдаг. Прокурор Ж.Ариунаа⁷⁶

“... Цагдаагийн байгууллагад цэргийн албан хаагч хохирсон хэргийн судалгааг 2017-2021 оны нэгдүгээр улирлын байдлаар гаргасан. Энд зөвхөн цэргийн алба хаагч хохирсон судалгаа байгаа. 37 гэсэн тоо үзүүлэлт гарсан. Амь нас хохирсон 16 тохиолдол байгаагаас хүний амь насыг санаатай хөнөөсөн 3 хэрэг бүртгэгдсэн. Дээр нь цэргийн алба хаагч гэмтсэн 21 хэрэг, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан 8 хэрэг, дарга захирагч нь хүч хэрэглэсэн 6 хэрэг, бие биедээ захирагдахгүй, цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн бус харьцсан 1 хэрэг тус тус бүртгэгдсэн. 37 хэргийн 15-д нь яллах дүгнэлт гарч, 14 нь хэрэгсэхгүй болсон. ЦЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Ц.Ням-очир⁷⁷

2020 онд ХЭҮК-т цэргийн албан хаагчдаас гомдол ирээгүй. Дотооддоо гомдол мэдээлэл авч, шийддэгтэй холбоотой. 2013-2020 онд 125 гэмт хэрэг цэргийн албанд үйлдэгдсэн. Үүний 98 нь хүч хэрэглэсэн гэж прокурорт шилжсэн.

ХЭҮК-ын гишүүн Б.Энхболд⁷⁸

Иймээс БХЯ, ЗХЖШ-ын зүгээс 2019 оноос эхлэн цэргийн алба хаагчдын ажлын бус цагаар, ахуйн орчинд үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдсон цэргийн алба хаагч болон хохирсон цэргийн алба хаагчдын талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага болон шүүх, бусад хууль хяналтын байгууллагаас улирал тутам авч, нэгтгэн судалгаа дүгнэлт гарган ажиллаж байгаагаас гадна зэвсэгт хүчний байгууллагуудад сахилга, дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, цэргийн албаны аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй “Цэргийн цагдаагийн алба”-ыг шинээр байгуулан цэргийн цагдаагийн бүлгүүдийг түшиглэн цэргийн хүрээ, хотхон бүрт цэргийн цагдаагийн 16 салбар, нэгжийг

⁷⁶ Д.Ганзориг: Цэргийн дэглэлтийг ЗХЖШ дангаараа шийдэж чадахгүй <https://news.mn/r/2419357/>

⁷⁷ Д.Ганзориг: Цэргийн дэглэлтийг ЗХЖШ дангаараа шийдэж чадахгүй <https://news.mn/r/2419357/>

⁷⁸ Д.Ганзориг: Цэргийн дэглэлтийг ЗХЖШ дангаараа шийдэж чадахгүй <https://news.mn/r/2419357/>

байгуулахаар шийдвэрлэсэн байна. Мөн шуурхай удирдлага, зохицуулалт, мэдээллийн тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр “Цэргийн цагдаа-2030” хөгжлийн хөтөлбөрийг 2021 оны 1 дүгээр сард баталжээ. Түүнчлэн энэ арга хэмжээтэй холбогдуулан “Цэргийн нийтлэг дүрмүүд”-д өөрчлөлт оруулах санал болон “Цэргийн цагдаагийн ажиллагааны журам”-ыг шинээр боловсруулсан байна.

УИХ-аас 2017 онд баталсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын⁷⁹ 13 дугаар зүйлд зааснаар зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага⁸⁰ болон зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн⁸¹-ийг төрийн тусгай албан тушаал хашиж буй албан хаагч гэж үзнэ.

ТАТХ-д зааснаар төрийн жинхэнэ албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сануулах; албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; төрийн албанаас халах; төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах; хуульд заасан бусад сахилгын арга хэмжээний аль нэгийг⁸² сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүүгүй хугацаанд төрийн жинхэнэ албан хаагчийг томилсон эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулах⁸³ боломжтой.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад ТАТХ-ийн дээрх үндсэн зохицуулалтаас гадна үндсэндээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн 4 дүгээр хавсралтаар баталсан Цэргийн сахилгын дүрэм⁸⁴-д заасан сахилгын шийтгэл оногдуулдаг. Цэргийн сахилгын дүрмийн 3 дугаар бүлэгт зааснаар цэргийн алба хаагчид оногдуулах сахилгын шийтгэлийн хэлбэр нь

- Хугацаат болон гэрээт цэргийн албаны байлдагч, түрүүч, цэргийн сургуулийн сонсогч, сурагч нарт сануулах, түр чөлөөг хасах, албан тушаалаас бууруулах, ахлах байлдагч, дэд түрүүч, түрүүч, ахлах түрүүч цолыг хураах, 10 хүртэл хоног тусгаарлан саатуулах;⁸⁵
- Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн гишүүнд: сануулах, ажиллагааны албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүй байгааг сануулах, ажиллагааны албан тушаалыг бууруулах, 3 хүртэл хоног тусгаарлан саатуулах, албан тушаалын үндсэн цалинг 2 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах саналыг холбогдох дээд

⁷⁹ Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга. 2017 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/13025>

⁸⁰ Төрийн албаны тухай хуулийн 13.1.4.

⁸¹ Төрийн албаны тухай хуулийн 13.1.6.

⁸² Төрийн албаны тухай хуулийн 48.1.1.-48.1.5

⁸³ Төрийн албаны тухай хуулийн 48.3

⁸⁴ Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд. 2019 он. Эх сурвалж: http://www.internal-troops.police.gov.mn/media/huuli/tsereg_durem.pdf

⁸⁵ Цэргийн сахилгын дүрмийн 30 заалт

шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, тухайн ЦАХ-ийн хувийн хэрэгт нь тэмдэглүүлэх,⁸⁶


- Цэргийн жинхэнэ болон цэргийн гэрээт албаны офицер, ахлагчид хууль тогтоомжид зааснаас гадна сануулах, 3 хүртэл хоног тусгаарлан саатуулах, албан тушаалын үндсэн цалинг 2 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүй байгааг сануулах байна.

Эдгээр үндсэн 7 төрлийн сахилгын шийтгэлийн аль нэгийг сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор⁸⁷ оногдуулах боломжтой бөгөөд сахилгын шийтгэлийг үндэслэлгүй оногдуулах, цэргийн алба хаагчийн нэр хүндийг гутаах, ширүүн догшин бүдүүлгээр харьцах, хамт олноор нь залхаахыг хатуу хориглодог.⁸⁸ Хэрэв цэргийн алба хаагч өөрт хүлээлгэсэн сахилгын шийтгэлийг үндэслэлгүй, буруу шийтгэгдсэн гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны ахлах даргад гаргаж болох ба гомдлыг “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн заасан журмын дагуу шийдвэрлэж байна.⁸⁹

Зэвсэгт хүчний салбарт албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан алба хаагчдад сахилгын шийтгэл оногдуулсан талаарх БХЯ-наас гаргасан мэдээллээс харахад 2020 онд нийт цэргийн удирдах байгууллага болон цэргийн нэгтгэл, анги, байгууллагын алба хаагч 3013 хүнд “Цэргийн сахилгын дүрэм”-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан байна. Тодруулбал, удирдлагын байгууллагын 9 офицер, 1 ахлагч, нэгтгэл, анги, байгууллагын 928 офицер, 1690 ахлагч, 13 цэргийн гэрээт алба хаагч, 30 хугацаат цэргийн алба хаагч, 342 ажилчин албан хаагч, нийт 3013 хүнд “Цэргийн сахилгын дүрэм”-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулжээ.⁹⁰

ЦАТХ-ийн хэрэгжилтийг үр дагаварт үнэлгээ хийх ажлын хүрээнд цэргийн удирдах байгууллагуудын алба хаагчдаас цэргийн жинхэнэ алба хаагчид оногдуулж буй сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээг хэр оновчтой болох талаар авсан судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 52 хувь нь “оновчтой” гэж хариулсан бол 22 хувь нь “оновчгүй”, 26 хувь нь “мэдэхгүй” гэж хариулжээ. Үүнээс харахад цэргийн алба хаагчид оногдуулах сахилгын арга хэмжээг цаг үедээ нийцүүлэн боловсронгуй болгох, алба хаагчдын дунд сахилгын болон хариуцлагын арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

График № 11 Сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээний тухай



⁸⁶ Цэргийн сахилгын дүрмийн 31 заалт

⁸⁷ Цэргийн сахилгын дүрмийн 38 заалт

⁸⁸ Цэргийн сахилгын дүрмийн 39 заалт

⁸⁹ Цэргийн сахилгын дүрмийн 44 заалт

⁹⁰ БХЯ-ны мэдээллээс

2016-2020 оны байдлаар хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 62 гарсан байна. Амиа алдсан хүн хоёр, гэр бүлийн хүчирхийлэл хоёр гарсан. Ёс суртахууны байдал дээр бид ажилладаг. Зэвсэгт хүчин өнгөрсөн 100 жилийн хугацаанд ёс зүйтэй ажилласаар ирсэн. Зэвсэгт хүчин рүү орж ирж байгаа хугацаат цэргийн албан хаагчид нийгмийн янз бүрийн давхаргаас, ялангуяа хамгийн амьдрал хүнд газраас ирж байна. Энэ бүх хүмүүстэй жилийн хугацаанд ажиллаад тухайн хүмүүсийг төлөвшүүлээд явуулахад хүндрэлтэй. Сэтгэл зүйчийн хувьд цэргийн анги байгууллагууд дээр нэг хүн байгаа. Тэр нь Цэргийн төв эмнэлэгт ажилладаг. Бусад нь тодорхой хэмжээний сургалт төгссөн хүмүүс байдаг.

ЗХЖШ-ын дарга Д.Ганзориг

ЗХЖШ-ын зүгээс алба хаагчдын ажлын байрны онцлог, харилцаа хандлага, сахилга, хариуцлагын нөхцөл байдалд дүгнэлт хийж, цэргийн албаны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, салбарт бэхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:⁹¹

- Батлан хамгаалахын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн н/40 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд “Цэргийн албаны хэлтэс”-ийг шинээр байгуулсан.
- БХЯ болон ЗХЖШ-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл” Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 23 дугаар зарлигаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийн зөвлөмж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан “Цэргийн нийтлэг дүрмүүд”, Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/335, А/336, ЗХЖШ-ын даргын 2017 оны А/535 дугаар тушаал, даалгавар, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг удирдлага болгон цэргийн алба хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, архи дан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, зэвсэг, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, гэмт хэрэг, осол, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг, чиглэлийг ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж байна.
- Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, үйл ажиллагаагаа нийгэмд илүү нээлттэй болгох зорилгоор БХСайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийг байгуулсан.
- Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт далд хэлбэрээр байж болзошгүй сахилгын болон харилцааны зөрчлийг илрүүлэх, бие бүрэлдэхүүний албандаа хандах хандлага, санал

⁹¹ БХЯ-наас боловсруулсан мэдээллээс эшлэв.

хүсэлтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор 5142 цэргийн алба хаагчийг хамруулсан социологийн судалгаа авч, үнэлэлт, дүгнэлт өгсөн.

- 24 цагийн ажиллагаатай “Батлан хамгаалах-Иргэний хяналт 1800-1144” тусгай дугаар ажиллуулж эхэлсэн,
- “Зэвсэгт хүчинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г ЗХЖШ-ын дарга батлан хэрэгжүүлж байна

Үнэлсэн байдал

ЦАТХ-ийн 36 дугаар зүйл буюу энэ хуулийг зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг “Хууль тогтоомж зөрчсөн бол хариуцлага тооцох хариуцлага гарцаагүй хүлээлгэнэ” гэх томьёоллын хүрээнд “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээд ЦАТХ-иар үүрэг хүлээлгэсэн зарим зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага байхгүй, эсхүл хариуцлагын хэмжээ бага байгаа зэргээс шалтгаалан “**Зорилгодоо хүрэхгүй**” гэж дүгнэв.

Цэргийн бүртгэлд хамаарах асуудлын тухайд

Монгол Улсын 18 насанд хүрсэн эрэгтэй иргэн бүр Үндсэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн алба хаах журамт үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээс зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөгдөх боломжтой.

ЦАТХууль тогтоомжид заасан цэргийн бүртгэлд хамрагдах үүргээ зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 15.17-д тусгасан бөгөөд хүлээлгэх хариуцлагын хэмжээ 100,000-150,000 төгрөгийн торгууль оногдуулж байна. Зөрчлийн хуулиар тогтоосон торгуулийн хэмжээ бага байгаа нь зарим тохиолдолд цэргийн бүртгэлд хамрагдах хөшүүрэг болж чадахгүй байна. ЦАТХ зөрчсөний улмаас Зөрчлийн хуулиар хэрэг үүсгэж, шийдвэрлэсэн хэргийн талаарх тоо мэдээлэл Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон Шүүхийн шийдвэрийн мэдээллийн нэгдсэн санд байхгүй байна.

Манай улс 18-50 насны эрэгтэйчүүд болон цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд, цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг цэргийн бүртгэлд бүртгэдэг. Цэргийн бүртгэлд хамрагдах идэвх сул байдаг нь цэргийн бүртгэлд хамрагдаагүй иргэнд хүлээлгэх хуулийн хариуцлага сул байгаатай холбоотой бөгөөд энэ нь цэргийн бүртгэлийн үйл ажиллагаанд багагүй хүндрэл үүсгэдэг байна. Тухайлбал,

- Цэрэг татлага явуулах тухай Засгийн газрын тогтоол нийтлэгдсэн өдрөөс эхлэн цэрэг татлагын хугацаа дуусах өдөр хүртэл цэргийн албанд татагдах насны иргэн тухайн нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад зорчихыг хориглоно” гэсэн ЦАТХ-ийн 12.11 дэх заалт хэрэгжихгүй байна. Энэ заалтын хэрэгжилтийг хянах тогтолцоо байхгүй, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хооронд мэдээлэл солилцох боломжгүй, энэ заалтыг зөрчсөн тохиолдолд цэргийн албанд татагдах насны иргэнд болон эдгээр хүмүүсийг гадаадад зорчих боломжоор хангасан байгууллагуудад хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин байхгүй байна.

- Цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд хамруулах зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох боломж, цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд ЦАТХ-д заасан эрх зүйн зохицуулалтын талаарх мэдлэггүй байгаа нь нөлөөлж байна. Энэ нь цэрэгт шаардлагатай мэргэжлийн жагсаалт нийтэд ил тод бус, эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд зөвхөн эрчүүд хамрагдана гэх ойлголттой байгаатай холбоотой гэж үзлээ.
- Цэргийн үүрэгтний үнэмлэхийг үрэгдүүлэх нь зөрчилд тооцогдохгүй байна. Иймээс цэргийн үүрэгтэн энэхүү үнэмлэхээ гээгдүүлсэн тохиолдолд 2000 төгрөг, 2 хувь цээж зурагтай байхад ямар нэг торгууль төлөхгүйгээр хэдэн ч удаа нөхөж авах боломжтой байдаг нь баримт бичигт хайнга хандах гол шалтгаан болж байна.
- Цэргийн бүртгэл хөтлөхөд гарч буй хамгийн том бэрхшээл нь шилжилт хөдөлгөөний асуудалтай холбоотой байна. Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх асуудлыг ЗГ-ын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам⁹²-аар зохицуулдаг хэдий ч энэ журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй улсын бүртгэгчдийн хайнга ажиллагаа, иргэдийн хайхрамжгүй байдалд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна. Түүнчлэн сүүлийн үед шилжилт хөдөлгөөнийг цахимаар хийх боломж нээгдсэнтэй холбоотойгоор цэргийн бүртгэлд хамрагддаг иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хянах, улмаар цэргийн үүрэгтний бүртгэлд тогтмол шинэчлэл хийх үйл ажиллагаанд асуудал үүсч байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.
- Зэвсэгт хүчний байгууллага болон төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин хангалтгүй байна. Тухайлбал, Цэргийн штабууд цэргийн насны залуучуудын бүртгэл мэдээллийг бүхэн гүйцэт авч чадахгүй байгаагаас цэргийн бэлтгэл үүрэгтний тоо, чанарт дүн шинжилгээ хийх бүртгэлийн үйл ажиллагаа доголдох, хариуцлагын асуудал хөндөгдөхгүй үлдэх эрсдэлтэй байна.
- ЦАТХ-ийн 29 дүгээр зүйлд “Хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана” гэж үүрэгжүүлсэн. Гэвч хуулийн энэ заалтыг зөрчиж мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагаагүй иргэнд ямар ч хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин байхгүй байна.

Цэргийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагын тухайд

Цэргийн алба хаагчид хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дайчилгааны тухай зэрэг хууль тогтоомжуудад заасны дагуу Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга /цаашид ЭХ гэх/, Зөрчлийн тухай хууль /цаашид ЗтХ гэх/, Төрийн албаны тухай хууль /цаашид ТАТХ гэх/ иуд агуулж байна. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн 4 дүгээр хавсралтаар баталсан Цэргийн сахилгын дүрэм болон бусад дотоод дүрэм, журам зөрчсөн тохиолдолд цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага,

⁹² ЗГ-ын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/13744?lawid=13744>

хилийн ба дотоодын цэргийн командлагч, онцгой байдлын байгууллагын дарга болон төрлийн цэргийн командлагч, цэргийн анги, нэгтгэлийн удирдах албан тушаалтан шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалт хэрэгжиж байна.

ЭХ-ийн Тусгай ангийн 28 дугаар бүлэгт 19 төрлийн “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг”-ийг тусгасан. Эдгээр гэмт хэрэгт ЭХ-иар хариуцлага хүлээлгэх ялын хэмжээ 6 сараас 1 жил хүртэл байх ба тухайн заалтын хүндрүүлэх нөхцөл бүрдсэн тохиолдолд ялын хэмжээ 1 жилээс 5 жил, 2 жилээс 8 жил, 12 жилээс 20 жил хүртэл нэмэгдэх зохицуулалттай бөгөөд Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд 2020 оны 1 сараас 2021 оны 6 сар хүртэлх хугацаанд ЭХ-ийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийтгэх тогтоол гаргасан 11 тохиолдол бүртгэгджээ.

Зэвсэгт хүчний байгууллагуудад цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагын асуудалтай холбоотой олон нийтийн анхаарлыг татсан хэдэн хэрэг гарсан, түүнийг олон нийтийн цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр давалгаалан шүүмжилж эхэлсэн нь УИХ болон хууль хяналт, хяналт шалгалтын байгууллагууд энэ салбарт гарч буй хүний эрхийн зөрчлүүдэд анхаарал хандуулах шалтгаан болжээ. Тухайлбал, Монгол Улсын Их хурлын гишүүн С.Одонтуяагаас Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд “Асуулга тавих тухай” албан тоот хүргүүлсэн бол ХЭҮК, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос БХЯ, ЗХЖШ-д зөвлөмж, чиглэл хүргүүлсэн байна.

БХЯ-наас гаргасан 2011-2020 оны гэмт хэргийн статистик судалгаанаас харахад, тус салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчил, ёс зүйн зөрчлийн тоо 2018 оноос нэмэгдэж 2020 оноос хойш буурах төлөвтэй байна. Үүнийг зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд нуугдмал гэмт хэргүүд илэрч, гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлийн үзүүлэлт өсөх хандлагатай байгаатай холбож болох юм. Гэхдээ зэвсэгт хүчний хэмжээнд гарсан, улсын хэмжээнд нэгдсэн тоо баримт гаргах боломжгүй байдал, Зэвсэгт хүчний хэмжээнд гарч буй цэргийн алба хаагчтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгаа, мэдээлэл тодорхойгүй, нэгдсэн бүртгэлгүй байгаа байдал, мөн цэргийн алба хаагчтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо энэ төрлийн хэргийг шалгах эрх бүхий байгууллага болох цагдаа, прокурор, шүүх бүрт өөр өөр байгаа байдал нь 2000-аад оноос өмнө Зэвсэгт хүчинд хэрэг бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан Цэргийн хэрэг бүртгэх албыг татан буулгасантай холбоотой байна. Иймээс Зэвсэгт хүчинд сахилга, дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, цэргийн албаны аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй “Цэргийн цагдаагийн алба”-ыг 16 салбар нэгжтэйгээр 2021 онд байгуулсан. Үүнээс өмнө 2019 оноос эхлэн цэргийн алба хаагчдын ажлын бус цагаар, ахуйн орчинд үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдсон цэргийн алба хаагч болон хохирсон цэргийн алба хаагчдын талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага болон шүүх, бусад хууль хяналтын байгууллагаас улирал тутам авч, нэгтгэн судалгаа дүгнэлт гаргаж байна.

Цэргийн алба хаагчид сахилгын арга хэмжээ авах эрх зүйн орчныг УИХ-аас 2017 баталсан ТАТХ болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн 4 дүгээр хавсралтаар баталсан “Цэргийн сахилгын дүрэм”-ээр зохицуулж байна.

Зэвсэгт хүчний байгууллагуудад алба хааж буй цэргийн алба хаагчдад ТАТХ-д сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, төрийн албанаас халах; төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах, хуульд заасан бусад сахилгын арга хэмжээний авахаас гадна Цэргийн сахилгын дүрэмд заасан 7 төрлийн сахилгын шийтгэлийн аль нэгийг сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор оногдуулах боломжтой байна. БХЯ-наас гаргасан мэдээллээс харахад 2020 онд нийт цэргийн удирдах байгууллага болон цэргийн нэгтгэл, анги, байгууллагын алба хаагч 3013 хүнд албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан үндэслэлээр “Цэргийн сахилгын дүрэм”-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулжээ.

ЗХЖШ-ын зүгээс алба хаагчдын ажлын байрны онцлог, харилцаа хандлага, сахилга, хариуцлагын нөхцөл байдалд дүгнэлт хийж, цэргийн албаны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, салбарт бэхжүүлэх зорилгоор Цэргийн албаны хэлтэс”, “Иргэний зөвлөл”-ийг шинээр байгуулсан, 24 цагаар мэдээлэл авах “Батлан хамгаалах-Иргэний хяналт 1800-1144” тусгай дугаар ажиллуулж эхэлсэн, “Зэвсэгт хүчинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх болон холбогдох байгууллага, дээд албан тушаалтны өгсөн цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон тушаал, даалгавар, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг удирдлага болгон цэргийн алба хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, архи дан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, зэвсэг, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, гэмт хэрэг, осол, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

ЦАТХ-ийн хэрэгжилтийг үр дагаварт үнэлгээ хийх ажлын хүрээнд цэргийн удирдах байгууллагуудын алба хаагчдын дунд цэргийн алба хаагчдад хүлээлгэх сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээ хэр оновчтой болох талаар хийсэн тандалт судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 52 хувь нь “оновчтой” гэж хариулсан бол 22 хувь нь “оновчгүй”, 26 хувь нь “мэдэхгүй” гэж хариулжээ. Үүнээс харахад цэргийн алба хаагчид оногдуулах сахилгын арга хэмжээг цаг үедээ нийцүүлэн боловсронгуй болгох, алба хаагчдын дунд сахилгын болон хариуцлагын арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах, цэргийн алба хаагчдын ажил, мэргэжлийн онцлогтой холбоотой сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх арга зам эрэлхийлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлийн 1-ийн 4/-т “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах”⁹³ иргэний ёсчлон биелүүлэх үүргийг тодорхойлж өгсөн байх ба энэхүү иргэний цэргийн үүрэг⁹⁴ нь “Монгол Улсын иргэн цэргийн албанд татагдах, элсэх, цэргийн мэргэжил эзэмших, цэргийн байгууллагад цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэх, цэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн бүртгэлд байх, цэргийн дайчилгааны цугларалт, сургуульд оролцох” гэсэн ойлголтоор тодорхойлогдох ба 18-25 насны эрэгтэй хүн бүр цэргийн алба хаах үүргийн эрх зүйн үндэс болж байна.

УИХ-аас 2016 онд баталсан Цэргийн албаны тухай хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3⁹⁵-т заасан шаардлагыг хангасан, мөн сүүлийн үед батлан хамгаалах салбар, цэргийн албанд үүсээд буй зарим асуудалтай холбогдуулан уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хэрэгцээ шаардлага үүссэн гэж үзсэн тул энэхүү судалгааг гүйцэтгэв.

ЦАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ ЗГ-ын “Аргачлал батлах тухай” 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг удирдлага болгон хуулийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран ЦАТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.4, 7 дугаар зүйлийн 7.5, 7.7, 12 дугаар зүйлийн 12.5, 12.7, 16 дугаар зүйлийн 16.1, 34 дүгээр зүйлийн 34.4, 36 дугаар зүйлийн 36.1, 36.2 дахь хэсгүүдэд тусгасан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийлээ.

ЦАТХ-ийн 4.4, 12.5, 12.7 болон 34.4 дэх хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь

Цэргийн албаны тухай хуулийн хуулийн 4.4-т “Цэргийн бүртгэлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд нэг удаа зохион байгуулах ба түүнд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана”, 12 дугаар зүйлийн 12.5-д “Зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр болон товлосон газарт ирсэн байх үүрэгтэй”, 12.7-д “Хугацаат цэрэг татлагын үед байнга оршин суугаа газраасаа өөр газарт түр хугацаагаар яваа иргэн тухайн нутаг дэвсгэрийн цэрэг татлагын байранд очиж бүртгүүлэх үүрэгтэй”, 34 дүгээр зүйлийн 34.4-т “Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ” гэж тус тус заасан байна. Цэргийн бүртгэлд Монгол Улсын 18-50 насны эрэгтэй иргэн, цэргийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд бүртгүүлэх үүрэгтэй. Үндсэндээ Монгол Улсын хүн амын 4 хүн тутмын 1 нь цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэг хүлээж байна. ЦАТХ-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэхэд дараах хүндрэлүүд гардаг бөгөөд үүнээс үүдэн хуулийн хэрэгжилт “Зорилгодоо хүрэхгүй” байна гэж үнэлсэн. Хуулийн зохицуулалт зорилгодоо хүрэхгүй байхад дараах хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзлээ. Үүнд.

⁹³ Монгол Улсын Үндсэн хууль. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/367> Сүүлд үзсэн 2021.06.25.

⁹⁴ Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 4.1

⁹⁵ Хууль тогтоомжийн тухай хууль. 51 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 51.3. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно. Эх сурвалж: <https://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>

- Хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах явцад цугларсан мэдээллээс харахад цэргийн бүртгэл явуулж буй захиргааны үйл ажиллагаа хэвийн буюу уламжлалт байдлаар хийгдэж байна. Харин цэргийн бүртгэлд хамрагдах цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтний оролцоо, хандлага, мэдлэг дутмаг байна.
- Хугацаат цэргийн алба хаах насны буюу 18-25 насны залуусын дунд цэргийн алба хаах сонирхол бага байна. Цэргийн насны залуус нийгмийн болон ар гэрийн нөлөөлөлд автагдан хугацаат цэргийн албанаас зайлсхийх нөхцөл байдал ажиглагдаж байна. Ялангуяа уламжлалт болон цахим мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээлэл тэдэнд илүү их нөлөөлж байна. Цэргийн алба хаах, хүүхдээ цэргийн алба хаалгах эсэхээ шийдэхдээ төрийн бодлого, хууль тогтоомжоор олгосон боломжийг судлахаас илүүтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээ, мэдээлэлд үндэслэдэг байна. Тухайлбал, цэргийн амьдралыг харуулсан кино контент цацагдах, үндэсний бүтээн байгуулалтад гар бие оролцож тодорхой цалин урамшуулалтай ажиллах боломж нээгдэх зэрэгт өөрийн хүсэлтээр цэргийн албанд татагдах хүсэлтэй залуусын тоо нэмэгддэг бол бусад үед буурах хандлагатай байдаг аж.
- Цэргийн бүртгэлд хамрагдах идэвх харилцан адилгүй байна. Ялангуяа цэргийн албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаасан цэргийн бэлтгэл албан хаагчид бүртгэлд харьцангуй идэвхтэй оролцдог бол цэргийн алба хаагаагүй, эрүүл мэндийн шалтгааны улмаас цэргийн албанаас чөлөөлөгдсөн иргэд, мөн цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн алба хаагчдын хувьд бүртгэлд хамрагдахгүй байх тохиолдол элбэг байна. Үүнийг хугацаат цэргийн алба хаагчдаас авсан судалгаанд оролцогчдын 37,5 хувь нь 50 нас хүртлээ цэргийн бүртгэлд бүртгүүлэх нь хүндрэлтэй, 25 хувь нь “мэдэхгүй” гэж хариулснаас харж болно Түүнчлэн хугацаат цэргийн алба хаахгүй байхад танил тал, мөнгө нөлөөлдөг гэж цэргийн насны залуусын 60 гаруй хувь нь үздэг нь судалгаанаас харагдаж байна. Хэдийгээр цэргийн насны эрэгтэйчүүд хугацаат цэргийн алба хаах, цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүргээ хэрэгжүүлэхдээ хойрго хандаж байгаа боловч хугацаат цэргийн алба хаагчдын дийлэнх олонх нь буюу 90 орчим хувь нь цэргийн алба хааснаар эх орноо батлан хамгаалах мэдлэг олж авахаас гадна хувь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн тал дээр давуу байдал бий болно гэдэгт итгэдэг байна. Үүнээс харахад цэргийн бүртгэлд бүртгүүлэхдээ төвөгшөөх хандлага цэргийн бүртгэл үүрэгтнүүдийн дунд нас харгалзахгүйгээр өндөр байна.
- ЦАТХ-д заасан цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд бүртгэх асуудал хүндрэлтэй байна. ЦАТХ-ийн 34.4-т “Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ.” гэж тодорхой үүрэгжүүлэн заасан боловч энэ үүргээ мэдэх цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд цөөн байна. Энэ нь нэгдүгээрт, ЗГ-аас баталсан цэрэгт шаардлагатай мэргэжлийн жагсаалт нийтэд ил тод бус буюу ямар мэргэжилтэй эмэгтэй цэргийн бүртгэлд хамрагдах үүрэгтэй болох талаарх мэдээлэл хүртээмжгүй, хоёрдугаарт, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг ажиллуулдаг албан байгууллагууд Цэргийн штабтай мэдээлэл солилцдоггүй зэргээс шалтгаалж байна. Цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн судалгааг засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хороо, мөн эрүүл мэнд,

нийгмийн хамгаалал, гадаад харилцаа, харилцаа холбоо зэрэг асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас авах замаар бүртгэл хөтөлдөг. Гэхдээ энэ зохицуулалтыг заавал хэрэгжүүлдэг байхад хөшүүрэг болохуйц хуулийн зохицуулалт дутмагаас цэргийн бүртгэлд эмэгтэйчүүдийг хамруулахад хүндрэл учруулдаг байна.

- Монгол Улсын хэмжээнд жил бүр 7000 орчим иргэн хугацаат цэргийн албанд татагддаг. Цэргийн насны залуусын эрүүл мэндэд анхаарах зайлшгүй шаардлага үүссэн байна. Учир нь хугацаат цэргийн алба хаах үүрэгтэй иргэдийн эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн бүртгэлээс хасагдах цэргийн насны залуусын тоо өсөж байгаа нь, мөн залуучуудын дунд эрүүл мэндийн боловсрол дутмаг, өвчтэй эсэхээ цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт орж байж мэдэх тохиолдол их гардаг нь анхаарах асуудлын нэг байна.
- Цэргийн насны залуучуудын төлөвшил, үзэл бодол, сэтгэлгээ нь цэргийн хөдөлмөрийн онцлогтой зөрчилдөж, хувь хүний зан чанарын онцлог зэргээс шалтгаалан цэргийн албанаас шантрах, цэргийн алба хаагчийн эрх зөрчигдөх, сахилга дэг журмын зөрчил, гэмт хэрэгт холбогдох зэрэг асуудал байна. Үүнийг боловсролын салбарт хүний эрхийн сургалтыг түлхүү явуулдаг ч эх оронч үзэл суулгах, ёс суртахууны хүмүүжил олгох, үүрэг хариуцлагаа ухамсарлах чиглэлийн болон биеийн тамир, спортын сургалт, хөтөлбөр хангалтгүй хэрэгждэг, техник технологийн хөгжлөө дагаад залуусын сонирхол өөрчлөгдсөн, Монгол Улсын ядуурлын түвшин өндөр 3 хүн тутмын 1 нь ядуу байгаа зэрэг боловсрол, нийгмийн тогтолцооны асуудлууд үүссэн, энэ нь цэргийн насны залуусын төлөвшил, бие даах чадварт сөргөөр нөлөөлж байгаатай холбож болох байна. Иймээс цэргийн албаны болон сургалт, бэлтгэлийн онцлогтой уялдуулан зэвсэг, байлдааны техник, хэрэгсэлтэй шууд харьцаж буй хугацаат цэргийн алба хаагчдын дунд дунд хот, хөдөөгийн болон боловсрол, бие бялдрын хөгжлийн ялгаатай байдал үүсч үүнээс үүдсэн сэтгэл санааны хямралд орох цаашлаад зөрчил, гэмт хэрэг гарах эрсдэл байна.
- Цэргийн бүртгэлд хамрагдах идэвх сул байдаг нь цэргийн бүртгэлд хамрагдаагүй иргэнд хүлээлгэх хуулийн хариуцлага сул байгаатай холбоотой бөгөөд энэ нь цэргийн бүртгэлийн үйл ажиллагаанд багагүй хүндрэл үүсгэж байна. Энэ талаар ЦАТХ-ийн 36 дугаар зүйлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнгээс харна уу.

ЦАТХ-ийн 7.5 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь

ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан “Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангах” үүрэгжүүлсэн зохицуулалтын хэрэгжилтийг “Зорилгодоо хүрэхгүй” гэж үзлээ. Үүнд дараах нөхцөл байдал нөлөөлсөн болно. Үүнд:

- Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй 88 мянга гаруй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан үүргийн дагуу Үндсэн хуульд заасан журамт үүргээ биелүүлэн, хугацаат цэргийн алба хаасан ажилтнаа эргүүлэн ажлын байранд нь авч буй эсэхийг хянах, дүн

бүртгэл хөтлөх тогтолцоо, нэгж хөдөлмөр, нийгмийн хамгаалал, улсын бүртгэл болон батлах хамгаалах салбарын хаана нь ч байхгүй байна.

- Мөн хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй суурь хууль болох Хөдөлмөрийн тухай хуульд зөвхөн цэргийн зарлан дуудах хуудас авсан ажилтны ажлын байрыг цэргийн жинхэнэ албанд татсан тухай цэрэг татлагын комиссын шийдвэр гартал хадгалах зохицуулалттай бөгөөд 2016 онд батлагдсан ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангах” үүргийг нэмж оруулаагүй нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлж байна.
- ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор 40 хугацаат цэргийн алба хаагчаас анкетын судалгаа авахад 65 хувь нь цэрэгт явахаас өмнө ажиллаж байсан ажлын байрандаа эргэж ажиллах боломжгүй болон энэ тухай тодорхой мэдэхгүй гэж хариулснаас харахад хуулийн энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Судалгааны дүнгээс харахад ерөнхийдөө ажлын байрандаа эргэж ажиллаж чадах эсэх нь тодорхойгүй гэж хариулсан хугацаат цэргийн алба хаагчдын 53 хувь нь бүрэн дунд, 23 хувь нь дээд боловсролтой байх ба 30 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад, 23 хувь нь их, дээд сургуулийн оюутан байсан бол 0,3 хувь нь төрийн байгууллагад ажиллаж байсан байна.
- Хугацаат цэргийн алба хаасан бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байсан иргэд ажлын байрандаа эргэж ажиллах боломж бага бол төрийн байгууллагуудын тухайд энэ заалтын хэрэгжилт хангалттай сайн гэж дүгнэж болох байна.
- Цэргийн алба хаасан иргэдийн дунд хуулиар олгогдсон эрхээ эдлэх, ЦАТХ-ийн уг заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хууль, шүүхийн байгууллагад хандахгүй байгаа нь уг заалтыг хаа хаанаа мөрдөхгүй байх нэг шалтгаан болж байна.
- Зэвсэгт хүчний салбарын зүгээс хугацаат цэргийн алба хаагчдад цэргийн мэргэжил олгохоос гадна мэргэжлийн сургалтад хамруулах замаар тэдний хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг дээшлүүлж байгаа нь сайшаалтай байна.

ЦАТХ-ийн 7.7 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь

Цэргийн албаны тухай хуулийн хуулийн 7.7-д “Цэргийн сургуулиас бусад их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн /цаашид МСҮТ гэх/ эрэгтэй суралцагч сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдаж болно” гэх зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлж үзэхэд уг хуулийн зохицуулалт нь нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тодорхой үр дүнд хүрсэн тул **“Зорилгодоо хүрсэн”** байна.

Харин хууль хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагуудын зүгээс хуулийн хэрэгжилтийг тогтмол байлгах, шударга, ил тод зохион байгуулах үүднээс “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах оюутан, сурагчдын сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, нийтэд ойлгомжтой байдлаар зохион байгуулах, нийтийг хамарсан цар тахал, гамшгийн үед сургалт зохион байгуулах талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

ЦАТХ-ийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь

ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийг “Хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэл хууль тогтоомжид нийцсэн, бодит шаардлагад тулгуурласан байна” гэх томъёоллын хүрээнд “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлэн “**Зорилгодоо хүрсэн**” гэж дүгнэсэн. Гэхдээ хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх үндэслэлтэй холбогдуулан дараах асуудлууд байгааг хөндлөө. Үүнд:

- ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т “эхнэр нь хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон” бол хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөхөөр заасан. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг орхигдуулсан байна. Иймээс Батлан хамгаалах салбарын зүгээс Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлага, дотоодын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд харилцан уялдаатай ажиллах үүднээс “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй” иргэнийг хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалт бий болгох боломжийг судлах шаардлагатай байна.
- ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т “цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан,” тохиолдолд хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас чөлөөлнө гэж заасан нь ЦАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.6, 30.7 болон 31 дүгээр зүйлийн 31.3-аар зохицуулсан харилцааг давхардуулан тусгасан байх тул энэ заалтыг хасах эсэх асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай гэж үзлээ.

ЦАТХ-ийн 36 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь

ЦАТХ-ийн 36 дугаар зүйл буюу энэ хуулийг зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг “Хууль тогтоомж зөрчсөн бол хариуцлага тооцох хариуцлага гарцаагүй хүлээлгэнэ” гэх томъёоллын хүрээнд “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээд зэвсэгт хүчний байгууллагуудын алба хаагчдад хариуцлага хүлээлгэх асуудал харьцангуй тодорхой байх боловч цэргийн үүрэгтэн цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин хангалтгүй байх тул “**Зорилгодоо хүрэхгүй**” гэж дүгнэв. Ийнхүү үнэлэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн болно. Үүнд:

Цэргийн бүртгэлд хамаарах асуудлын тухайд

- Монгол Улсын 18 насанд хүрсэн эрэгтэй иргэн бүр Үндсэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн алба хаах журамт үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээс зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөгдөх боломжтой. ЦАТХ-д заасан цэргийн бүртгэлд хамрагдах үүргээ зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17-д тусгасан бөгөөд цэргийн бүртгэлийн журам зөрчсөн тохиолдолд 100,000-150,000 төгрөгийн торгууль оногдуулж байна. Одоогоор ЦАТХ зөрчсөний улмаас Зөрчлийн хуулиар хэрэг үүсгэж, шийдвэрлэсэн хэргийн талаарх тоо мэдээлэл Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон Шүүхийн шийдвэрийн мэдээллийн нэгдсэн санд байхгүй байна.

- Цэрэг татлага явуулах тухай Засгийн газрын тогтоол нийтлэгдсэн өдрөөс эхлэн цэрэг татлагын хугацаа дуусах өдөр хүртэл цэргийн албанд татагдах насны иргэн тухайн нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад зорчихыг хориглоно” гэсэн ЦАтХ-ийн 12.11 дэх заалт хэрэгжихгүй байна. Энэ заалтын хэрэгжилтийг хянах тогтолцоо байхгүй, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хооронд мэдээлэл солилцох боломжгүй, энэ заалтыг зөрчсөн тохиолдолд цэргийн албанд татагдах насны иргэнд болон эдгээр хүмүүсийг гадаадад зорчих боломжоор хангасан байгууллагуудад хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин байхгүй байна.
- Цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд хамруулах зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох боломж, цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд ЦАтХ-д заасан эрх зүйн зохицуулалтын талаарх мэдлэггүй байгаа нь нөлөөлж байна.
- Цэргийн үүрэгтний үнэмлэхийг үрэгдүүлэх нь зөрчилд тооцогдохгүй байна. Иймээс цэргийн үүрэгтэн энэхүү үнэмлэхээ гээгдүүлсэн тохиолдолд 2000 төгрөг, 2 хувь цээж зурагтай байхад ямар нэг торгууль төлөхгүйгээр хэдэн ч удаа нөхөж авах боломжтой байдаг нь баримт бичигт хайнга хандах гол шалтгаан болж байна.
- Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой зарим асуудал цэргийн бүртгэл хөтлөхөд нөлөөлж байна. Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх асуудлыг ЗГ-ын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмаар зохицуулдаг хэдий ч энэ журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй улсын бүртгэгчдийн хайнга ажиллагаа, иргэдийн хайхрамжгүй байдалд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна. Түүнчлэн сүүлийн үед шилжилт хөдөлгөөнийг цахимаар хийх боломж нээгдсэнтэй холбоотойгоор цэргийн бүртгэлд хамрагддаг иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хянах, улмаар цэргийн үүрэгтний бүртгэлд тогтмол шинэчлэл хийх үйл ажиллагаанд асуудал үүсч байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.
- Зэвсэгт хүчний байгууллага болон төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин хангалтгүй байна. Тухайлбал, Цэргийн штабууд цэргийн насны залуучуудын бүртгэл мэдээллийг бүрэн гүйцэт авч чадахгүй байгаагаас цэргийн бэлтгэл үүрэгтний тоо, чанарт дүн шинжилгээ хийх бүртгэлийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байна.
- ЦАтХ-ийн 29 дүгээр зүйлд “Хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана” гэж үүрэгжүүлсэн. Гэвч хуулийн энэ заалтыг зөрчиж мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагаагүй иргэнд ямар ч хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин байхгүй байна.

Цэргийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагын тухайд

Цэргийн алба хаагчид хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дайчилгааны тухай зэрэг хууль тогтоомжуудад заасны дагуу Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга /цаашид ЭХ гэх/, Зөрчлийн тухай хууль /цаашид ЗтХ гэх/, Төрийн албаны тухай

хууль /цаашид ТАТХ гэх/-иуд агуулж байна. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн 4 дүгээр хавсралтаар баталсан Цэргийн сахилгын дүрэм болон бусад дотоод дүрэм, журам зөрчсөн тохиолдолд цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, хилийн ба дотоодын цэргийн командлагч, онцгой байдлын байгууллагын дарга болон төрлийн цэргийн командлагч, цэргийн анги, нэгтгэлийн удирдах албан тушаалтан шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалт хэрэгжиж байна.

Эрүүгийн хариуцлагын тухайд: ЭХ-ийн Тусгай ангийн 28 дугаар бүлэгт 19 төрлийн “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг”-ийг тусгасан бөгөөд Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд 2020 оны 1 сараас 2021 оны 6 сар хүртэлх хугацаанд ЭХ-ийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийтгэх тогтоол гаргасан 11 тохиолдол бүртгэгджээ. БХЯ-наас гаргасан 2011-2020 оны гэмт хэргийн статистик судалгаанаас харахад, тус салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчил, ёс зүйн зөрчлийн тоо 2018 оноос нэмэгдэж 2020 оноос хойш буурах төлөвтэй байна. Үүнийг зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд нуугдмал гэмт хэргүүд илэрч, гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлийн үзүүлэлт өсөх хандлагатай байгаатай холбож болох юм.

Зэвсэгт хүчний хэмжээнд алба хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчлийн талаар улсын хэмжээнд нэгдсэн тоо, мэдээлэл гаргах боломжгүй байна. Зэвсэгт хүчний хэмжээнд гарч буй цэргийн алба хаагчтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгаа, мэдээлэл тодорхойгүй, нэгдсэн бүртгэлгүй байгаа нь, мөн цэргийн алба хаагчтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо энэ төрлийн хэргийг шалгах эрх бүхий байгууллага болох цагдаа, прокурор, шүүх бүрт өөр өөр байгаа нь 2000-аад оноос өмнө Зэвсэгт хүчинд хэрэг бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан Цэргийн хэрэг бүртгэх алба татан буугдсантай холбоотой байна. Иймээс Зэвсэгт хүчинд сахилга, дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, цэргийн албаны аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй “Цэргийн цагдаагийн алба”-ыг 16 салбар нэгжтэйгээр 2021 онд байгуулсан. Үүнээс өмнө 2019 оноос эхлэн цэргийн алба хаагчдын ажлын бус цагаар, ахуйн орчинд үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдсон цэргийн алба хаагч болон хохирсон цэргийн алба хаагчдын талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага болон шүүх, бусад хууль хяналтын байгууллагаас улирал тутам авч, нэгтгэн судалгаа дүгнэлт гаргаж байна.

Сахилгын шийтгэлийн тухайд. Цэргийн алба хаагчид сахилгын арга хэмжээ авах эрх зүйн орчныг УИХ-аас 2017 баталсан ТАТХ болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн 4 дүгээр хавсралтаар баталсан “Цэргийн сахилгын дүрэм”-ээр зохицуулж байна. БХЯ-наас гаргасан мэдээллээс харахад 2020 онд нийт цэргийн удирдах байгууллага болон цэргийн нэгтгэл, анги, байгууллагын алба хаагч 3013 хүнд албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан үндэслэлээр “Цэргийн сахилгын дүрэм”-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан байна.

ЦАТХ-ийн хэрэгжилтийг үр дагаварт үнэлгээ хийх ажлын хүрээнд цэргийн удирдах байгууллагуудын алба хаагчдын дунд цэргийн алба хаагчдад хүлээлгэх сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээ хэр оновчтой болох талаар хийсэн тандалт судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 52 хувь нь “оновчтой” гэж хариулсан бол 22 хувь нь “оновчгүй”, 26 хувь нь “мэдэхгүй” гэж хариулжээ. Үүнээс харахад цэргийн алба хаагчид оногдуулах

сахилгын арга хэмжээг цаг үедээ нийцүүлэн боловсронгуй болгох, алба хаагчдын дунд сахилгын болон хариуцлагын арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Дотоод болон хөндлөнгийн хяналт, шалгалтыг сайжруулах тухайд. ЗХЖШ-ын зүгээс алба хаагчдын ажлын байрны онцлог, харилцаа хандлага, сахилга, хариуцлагын нөхцөл байдалд дүгнэлт хийж, цэргийн албаны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, салбарт бэхжүүлэх, дотоод болон хөндлөнгийн хяналтыг сайжруулах зорилгоор Цэргийн албаны хэлтэс”, “Иргэний зөвлөл”-ийг шинээр байгуулсан, 24 цагаар мэдээлэл авах “Батлан хамгаалах-Иргэний хяналт 1800-1144” тусгай дугаар ажиллуулж эхэлсэн, “Зэвсэгт хүчинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх болон холбогдох байгууллага, дээд албан тушаалтны өгсөн цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон тушаал, даалгавар, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг удирдлага болгон цэргийн алба хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, архи дан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, зэвсэг, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, гэмт хэрэг, осол, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлийн 1-ийн 4/-т “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” иргэний цэргийн үүрэг нь Монгол Улсын иргэн цэргийн албанд татагдах, элсэх, цэргийн мэргэжил эзэмших, цэргийн байгууллагад цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэх, цэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн бүртгэлд байх, цэргийн дайчилгааны цугларалт, сургуульд оролцох мөн цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлэх гэсэн ойлголтоор тодорхойлогдоно.

2016 онд баталсан Цэргийн албаны тухай хууль нь үндсэндээ дээр дурдсан харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 7 дугаар зүйлийн 7.5, 7.7, 12 дугаар зүйлийн 12.5, 12.7, 16 дугаар зүйлийн 16.1, 34 дүгээр зүйлийн 34.4, 36 дугаар зүйлийн 36.1, 36.2 дахь хэсгүүдэд тусгасан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлээд дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Цэргийн бүртгэл нь жилд 1 удаа зохион байгуулагддаг бөгөөд түүнд Монгол Улсын 18-50 насны эрэгтэй иргэн, цэргийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд бүртгүүлэх үүрэгт хүлээдэг. Гэвч цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй иргэдийн идэвх сул, зарим тохиолдолд энэхүү үүргээ мэдэхгүй байгаагаас гадна төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох боломж, түүнийг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт дутмаг, мөн хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй, эсхүл хэмжээ нь бага байгаа зэргээс шалтгаалан энэ зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй иргэдийн дунд цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүд, цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн болон ямар нэг үндэслэлээр хугацаат цэргийн алба хаагаагүй иргэдийг цэргийн бүртгэлд бүртгэхэд хүндрэлтэй байна. Энэ нь цэргийн мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн хувьд энэ үүргээ төдийлөн сайн мэддэггүйтэй, цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн иргэдийн хувьд хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар мэдээлэлгүйтэй холбоотой бол бусад иргэдийн хувьд цэргийн бүртгэлд заавал бүртгүүлэх хөшүүрэг бага буюу хүлээлгэх хариуцлагын хэмжээ бага байгаатай тус тус холбоотой байна. Түүнчлэн цэргийн бүртгэлийг бүрэн төгс хөтлөхөд ЗХЖШ болон бүртгэлийн байгууллагын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчин дутмаг, иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн асуудлууд бэрхшээл үүсгэж байна. Цэргийн бүртгэлтэй холбоотой гарч буй бусад асуудлын тухайд цэргийн үүрэгтний үнэмлэхийг үрэгдүүлэх үзэгдэл их гарч байгаа нь энэ төрлийн зөрчилд хүлээлгэх хариуцлага байхгүйгээс үүддэг. Мөн цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын болон үзэл бодол, ёс зүйн асуудлууд ч цэргийн бүртгэл, цэрэг татлага, цэргийн нөхөн хангалтын хувьд асуудал үүсгэж байна. Иймээс цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй иргэдийг энэ үүргээ хэрэгжүүлэхэд хөшүүрэг болохуйц арга хэмжээ төлөвлөх, мэдээлэл сурталчилгаа хийх, зэвсэгт хүчний байгууллага бүртгэлийн байгууллага хооронд цэргийн бүртгэлд шаардлагатай мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
2. Хугацаат цэргийн алба хаасан иргэнийг цэрэгт татагдахаас өмнө ажиллуулж байсан аж ахуйн нэгж, албан байгууллага ажлын байраар хангах үүргийг ЦАТХ-д шинээр тусгасан. Гэвч хуулийн энэ заалтын зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хуультай уялдуулаагүй, мөн хэрэгжилтийг хэрхэн хангаж буй талаар судалгаа, мэдээлэл гаргах, хяналт, шалгалт хийх бүтэц байхгүй, хуулийн энэ заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй, ажлын байраар хангагдаж чадаагүй залуус хууль

хяналтын байгууллагад хандадгүй зэргээс энэ зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна. Иймээс ЦАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах үүднээс Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хариуцлагыг тодорхой болгох, судалгаа мэдээлэл гаргадаг байх шаардлагатай байна.

3. Хугацаат цэргийн алба хаах шинэ төрөл болох “Оюутан-цэрэг” сургалт нь богино хугацаанд цэргийн онолын болон дадлагын мэдлэг олгодог, хугацаат цэргийн алба хаасанд тооцогддог зэрэг давуу талаараа цэргийн насны их, дээд сургуулийн оюутнуудад эрэлт хэрэгцээнд нийцсэн зохицуулалт болсон бөгөөд хангалттай сайн хэрэгжиж байна. Харин нэг жилд хугацаат цэргийн албанд татах оюутан цэргийн тоон хязгаар бага байгаа нь, мөн сонгон шалгаруулалт сургууль тус бүр дээр зохиогддог, үйл явц нь ил тод, нээлттэй биш байгаа нь оюутан цэргээр элсүүлэх үйл ажиллагаа шударга бус явагддаг гэх хардлагыг бий болгодог байна. Иймээс оюутан-цэрэг сургалтын сонгон шалгаруулалтыг нэгдсэн, нээлттэй, ил тод хэрэгжүүлэх мөн оюутан цэргийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр их, дээд сургуулиудтай хамтран ажиллах боломжтой юм.
4. ЦАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан хугацаат цэргийн албанаас чөлөөлөх үндэслэлд Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлага, дотоодын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүднээс “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй” гэх үндэслэлийг нэмж тусгах нь зүйтэй байна. Харин ЦАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.6, 30.7 болон 31 дүгээр зүйлийн 31.3-д цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэнийг цэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэж цэргийн алба хаасанд тооцож байхад хуулийн 16.1-д заасан хугацаат цэргийн албанаас чөлөөлөх үндэслэлд оруулах шаардлага байгаа эсэхийг дахин судлах хэрэгтэй байна.
5. Цэргийн албаны тухай хууль зөрчигчид Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх зохицуулалтын хүрээнд цэргийн насны иргэдэд хүлээлгэх хариуцлага, цэргийн жинхэнэ алба хаагчдад хүлээлгэх хариуцлагын асуудлыг тус тусад нь авч үзлээ. Ингэхэд цэргийн жинхэнэ алба хаагчид дээрх хуулиудаас гадна “Цэргийн сахилгын дүрэм”-д заасан сахилгын шийтгэл оногдуулдаг бөгөөд 2020 онд цэргийн нийт байгууллагын алба хаагчдаас 3013 хүнд сахилгын шийтгэл оногдуулсан бол Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 28-д заасан “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” үйлдэж Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийтгэх тогтоол гаргасан 11 тохиолдол бүртгэгдсэн байна. ЦАТХ-ийн зарим зүйл заалтын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор цэргийн жинхэнэ алба хаагчдаас авсан анкетын судалгаанд оролцогчдын 52 хувь нь тэдэнд авч буй сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээг оновчтой гэж, 22 хувь нь оновчгүй гэж үздэгээс харахад цэргийн алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа гаргасан зөрчил, дутагдалд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин хангалттай гэж үзэж болох байна.
6. Харин цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтний хувьд зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрхэг байна. Тухайлбал, цэргийн бүртгэлийн журам зөрчсөн иргэнд Зөрчлийн тухай хуулийн 15.17-д зааснаар иргэнийг 100-150 нэгжтэй, хуулийн этгээдийг 1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох зохицуулалт үйлчилж байна. Энэ нь зарим иргэдийн хувь бага хэмжээтэй байх тул цэргийн албатай холбоотой иргэний үүргээ үл ойшоох шалтгаан болж байна. Мөн ЦАТХ-ийн 12 дугаар зүйлд заасан цэргийн албанд татагдах насны иргэн цэрэг

татлагын үеэр гадаадад зорчихыг хориглосон заалт, 29 дүгээр зүйлд заасан мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулах хаах зохицуулалтыг зөрчсөн, цэргийн үүрэгтний үнэмлэхийг үрж гээгдүүлсэн, шилжилт хөдөлгөөн хийхдээ цэргийн штабт бүртгүүлээгүй иргэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин байхгүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна. Түүнчлэн цэргийн штабууд улсын бүртгэлийн байгууллагаас шаардлагатай мэдээллээ бүрэн авч чадахгүй байгаагаас үүдэн цэргийн насны залуучуудын бүртгэлийг баг, хорооны ажилтнуудтай хамтран өөрийн бүртгэл мэдээлэлдээ түшиглэн хийж байгаа нь хүндрэлтэй үүсгэж байна. Энэ нь ялангуяа улсын бүртгэлийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж байгаагаар холбоотой улам хүндрэлтэй болох эрсдэл байна.

Цэргийн албаны тухай хуулийн зарим зүйл заалтад хийсэн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн холбогдох хэсгүүдээс дээрх дүгнэлттэй холбоотой судалгаа, үнэлгээтэй дэлгэрэнгүй байдлаар танилцах боломжтой.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Бодлогын түвшинд анхаарах асуудал

1. Орчин цагийн монгол хүний бие бялдрын онцлогт тохирсон бэлтгэл, дадлага сургуулилтын хөтөлбөр боловсруулах, түүнд шаардлагатай суурь судалгаа хийх,
2. Хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын болон оюуны хөгжлийг дэмжих, эх оронч үзэл, хүмүүжил суулгах чиглэлээр эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах салбарууд хууль тогтоомж, үйл ажиллагааны тал дээр харилцан уялдаатай хамтран ажиллах,
3. Цэргийн бүртгэлд хамрагдах үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх, Тухайлбал, төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлэх, ЦАТХ-иар хүлээсэн үүргээ зөрчсөн, цэргийн бүртгэлийн үйл ажиллагаанд санаатай болон санамсаргүй үйлдлээр саад учруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй иргэдэд мэдээллийг хүртээмжтэй түгээхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар цэргийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтний идэвх, оролцоог нэмэгдүүлэх,
4. Зэвсэгт хүчний бүх шатны байгууллагад хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс хүний эрхийн зөрчил, дүрмийн бус харилцаа, гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх мэдээллийн нэгдсэн сантай болох, зөрчил илэрсэн тохиолдолд нэн яаралтай таслан зогсоох, дүрмийн бус харьцаа, гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд хариуцлага тооцох, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх, эдгээрийг бүртгэдэг байх,
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, тусгай хэрэгцээг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй иргэний хугацаат цэргийн албанд татахгүй байх зохицуулалтыг ЦАТХ-д нэмэх

Хэрэгжилтийн төвшинд анхаарах асуудал

6. Цэргийн албаны талаар үнэн зөв мэдээлэл олгох зорилгоор олон нийтийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, нөлөөллийн арга хэмжээ тогмол зохион байгуулах,
7. Цэргийн байгууллагад тавих иргэний хяналтыг сайжруулах, дотоод хяналтыг сайжруулах үүднээс техник, технологийн шинэчлэл хийх,
8. Цэргийн алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цэргийн алба хаагчдын ёс суртахуун, харилцаа, хандлагын түвшнийг сайжруулах зорилгоор тодорхой давтамжит хугацаанд хууль тогтоомжийн мэдлэгийн болон сэтгэл зүйн түвшний үнэлгээ хийдэг байх,
9. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагад ажиллах нөхцөл, хугацаат цэргийн алба хаагчдын амьдрах, алба хаах орчныг сайжруулах замаар цэргийн албанд ажиллах, цэргийн алба хаах хүсэл эрэмэлзлийг нэмэгдүүлэх,

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм. Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолын хавсралт.
2. Засгийн газарт чиглэл өгөх тухай. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг. 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдөр. Дугаар 92.
3. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 он.
4. Зэвсэгт хүчний тухай (Шинэчилсэн найруулга) 2016 он
5. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс. Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “баримт бичиг
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017-2021 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 97 дугаар зарлигийн хавсралт
7. Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай. ЗГ-ын 2018 оны 332 дугаар тогтоол
8. Монгол Улсын Үндсэн хууль.
9. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол
10. Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль
11. Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд. 2019 он.
12. Монгол Улсын шүүхийн цахим сан
13. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг. Журам батлах тухай /Цэргийн цол олгох журам/
14. Оюутан-цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтын журам. ЗГ-ын 2017 оны 32 дугаар тогтоол “Журам батлах тухай
15. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга. 2017 он.
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц. 2008 он.
17. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. 2017 он.
18. Хөдөлмөрийн тухай хууль
19. Хөтөлбөр батлах тухай. Засгийн газрын тогтоол. 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдөр. Дугаар 40
20. Хууль тогтоомжийн тухай хууль.
21. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт.
22. Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1990 он.
23. Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай. Батлан хамгаалах сайдын 2017 оны А/331 дугаар тушаал.
24. Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай. ЗГ-ын 2019 оны 249 дүгээр тогтоол, 2020 оны 336 дугаар тогтоол, 2021 оны 72 дугаар тогтоол
25. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол, Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоох сүлжээ. УИХ-ын тогтоол. “Болзол батлах тухай”, 2009 оны 4 сарын 30 өдөр, Дугаар 33.
26. Цэргийн сахилгын дүрэм

27. Эмч, багш нарыг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцох алслагдсан сумдын жагсаалт. ЗГ-ын 2009 оны 246 дугаар тогтоолын хавсралт..
28. Батлан хамгаалах яамнаас гаргасан мэдээлэл. 2021 он
29. Батлан хамгаалахад иргэний оролцоо, иргэдийг бэлтгэх зарим арга зам. Б.Нэргүй. БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор(Ph.D), дэд хурандаа. “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл. №39 /29/2020.
30. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. 2020 он.
31. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа. Хөдөлмөр , нийгмийн хамгааллын судалгааны институт. 2019 он.
32. ЦАТХ-ийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх зорилгоор хугацаат цэргийн алба хаагч болон цэргийн жинхэнэ албан хаагчдаас 70 ширхэг анкетын судалгаа
33. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
34. Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан
35. legalinfo.mn
36. gsmaf.gov.mn
37. mids.gov.mn
38. mlsp.gov.mn
39. mod.gov.mn
40. new.shuukh.mn
41. news.mn
42. vip76.mn
43. www.1212.mn
44. www.internal-troops.police.gov.mn
45. www.worldbank.org
46. zasag.mn

ХАВСРАЛТ №1 “ЦАТХ-д тусгагдсан шинэ зохицуулалт”

1992 оны “Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай”-хуулиар зохицуулагдаагүй байсан Цэргийн албаны тухай хуульд шинээр нэмэгдсэн зүйл заалтын түүвэр

№	Сонгосон хуулийн зүйл, заалт	
1.	4 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүрэг	4.3.Дайны байдлын үед иргэний цэргийн үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.
2.		4.4.Цэргийн бүртгэлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд нэг удаа зохион байгуулах ба түүнд ц эрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана.
3.	5 дугаар зүйл. Цэргийн тангараг	5.3.Цэргийн тангараг өргөсөн баримт бичгийг цэргийн алба хаагчийн хувийн хэрэгт хадгална.
4.	6 дугаар зүйл. Цэргийн алба, түүний төрөл	6.4.Цэрэгт бүртгэлтэй мэргэжлийн жагсаалтыг Засгийн газар батална.
5.	7 дугаар зүйл. Хугацаат цэргийн алба	7.2.Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч онцгой нөхцөл бий болсон үед хугацаат цэргийн алба хаагчийн алба хаах хугацааг гурав хүртэл сараар сунгаж болно.
6.		7.5.Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангана.
7.		7.7.Цэргийн сургуулиас бусад их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эрэгтэй суралцагч сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдаж болно.
8.		7.9.“Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмыг Засгийн газар батална.
9.	8 дугаар зүйл. Цэргийн гэрээт алба	8.3.Шаардлагатай мэргэжил, албан тушаалд иргэнийг ахлагч, офицероор тав хүртэл жилийн хугацаагаар цэргийн гэрээт албанд элсүүлж болно.
10.		8.4.Ахлагч, офицероор цэргийн гэрээт албанд элсүүлэх мэргэжил, албан тушаалын жагсаалтыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын болон цэргийн мэргэжлийн байгууллага батална.
11.	9 дүгээр зүйл. Цэргийн сургуулийн сонсогч, сурагч	9.5.Цэргийн сургуулийн сонсогч, сурагчийн ахуй хангалт, дүрэмт хувцсыг төр хариуцна.
12.		9.6.Цэргийн хөгжмийн болон цэргийн дунд сургуулийн үлгэрчилсэн дүрэм, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, элсэлтийн журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.
13.		9.7.Цэргийн сургуулийн дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
14.	10 дугаар зүйл. Ахлагчийн алба	10.1.Цэргийн зохих шатны сургууль, дамжаанд суралцаж, цэргийн мэргэжил эзэмшсэн 30 хүртэлх насны иргэнийг ахлагчийн албанд элсүүлж болно.
15.		10.2.Ахлагчийн албан тушаал нь даргалах, гүйцэтгэх гэсэн ангилалтай байна.

16.		10.3.Ахлагчийн алба хаагч нь боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн зохих шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
17.		10.4.Энэ зүйлийн 10.3-т заасан шалгуур үзүүлэлтийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага батална.
18.		10.5.Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана.
19.	11 дүгээр зүйл. Офицерын алба	11.1.Офицерын алба хаагч нь боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн зохих шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
20.		11.2.Энэ зүйлийн 11.1-д заасан шалгуур үзүүлэлтийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага батална.
21.		11.7.Ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан цэргийн сургуулийн багш, цэргийн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн офицерын алба хаах хугацааг дахин сунгаж болно.
22.	15 дугаар зүйл. Хугацаат цэргийн албанаас халах	15.3.Цэргийн албаа үлгэр жишээчээр хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчийг хилийн ба дотоодын цэрэг, төрлийн цэргийн командлалын саналыг үндэслэн цэргийн мэргэжлийн дээд удирдлагын даргын шийдвэрээр цэргийн албаны хугацаа дуусахаас гурван сарын өмнө бэлтгэлээр халж болно.
23.	16 дугаар зүйл. Тайван цагт хугацаат цэргийн албанд татахаас чөлөөлөх	16.1.1.эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдсон;
24.		16.1.2.цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан;
25.	17 дугаар зүйл. Цэргийн гэрээт албанд элсүүлэх	17.1.Цэргийн гэрээт албанд хугацаат цэргийн алба хаасан иргэнийг цэргийн анги, байгууллагын захирагч, дарга элсүүлж, гэрээ байгуулан албан тушаалд томилно.
26.	18 дугаар зүйл. Цэргийн гэрээт алба дуусгавар болох	18.1.Цэргийн гэрээт алба дараахь тохиолдолд дуусгавар болно:
27.		18.1.1.цэргийн жинхэнэ алба хаах гэрээний хугацаа дууссан;
28.		18.1.2.эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдсон;
29.		18.1.3.цэргийн гэрээт алба хаах насны дээд хязгаарт хүрсэн
30.	19 дүгээр зүйл. Цэргийн жинхэнэ алба хаах болзол	19.1.Офицер, ахлагчийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг баримтлан албан тушаалд томилно.
31.		19.2.Офицер, ахлагч нь дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан байна:
32.		19.2.1.дипломын болон түүнээс дээш боловсролтой байх;
33.		19.2.2.мэргэжил, мэргэшил, ур чадварын түвшин нь томилогдох албан тушаалын ажлын байрны шаардлагыг хангасан байх;
34.		19.2.3.биеийн эрүүл мэндээр цэргийн жинхэнэ албанд тэнцэх тухай цэргийн эмч нарын комиссын дүгнэлт гарсан байх;
35.		19.2.4.бие бялдрын ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангасан байх;
36.		19.2.5.цэргийн алба хаагчийн ёс зүйн шаардлага хангасан байх.
37.		19.3.Ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан офицер, ахлагчийн алба хаагчид тавигдах ерөнхий шаардлагыг хангасан 35 хүртэлх насны иргэнийг офицерын, 30 хүртэлх насны иргэнийг ахлагчийн албанд авч болох бөгөөд офицер, ахлагчийн албанд авах уг иргэнийг цэргийн бэлтгэл, сургалтад хамруулна.

38.		19.4.Орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэнд, ар гэрийн гачигдлын улмаас цэргийн албанаас чөлөөлөгдсөн бэлтгэл офицер, ахлагчийг цэргийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш таван жилийн дотор энэ зүйлийн 19.2-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд офицер, ахлагчийн албанд эгүүлэн авч болно.
39.		19.5.Алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн тэтгэвэр тогтоолгосон дээд офицер, офицер, ахлагч, энэ зүйлийн 19.3-т заасан наснаас хэтэрсэн цэргийн мэргэжил эзэмшээгүй иргэнийг офицер, ахлагчийн орон тоонд ажиллуулахыг хориглоно.
40.		19.6.Цэргийн анги, байгууллагын захирагч, дарга, түүнээс дээших удирдах албан тушаалд цэргийн алба хаагч ажиллах хугацаа дөрвөн жил байх бөгөөд ажлын шаардлагаар нэг жилээс илүүгүй хугацаагаар сунган ажиллуулж болно.
41.		19.7.Офицерын удирдах албан тушаалд цэргийн мэргэжил эзэмшээгүй иргэнийг ажиллуулахыг хориглоно.
42.		19.8.Энэ зүйлийн 19.6-д заасан хугацаа нь ижил түвшний албан тушаалд сэлгэн ажиллуулах болон дэвшүүлэн томилогдсон тохиолдолд хамаарахгүй.
43.	20 дугаар зүйл. Офицер, ахлагчийн албан тушаалыг түр хавсран гүйцэтгэх	20.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр гурваас дээш сарын хугацаагаар түр эзгүй байгаа алба хаагчийн үүргийг өөр алба хаагчаар хавсран гүйцэтгүүлж болно.
44.		20.2.Албан үүргийг түр хавсран гүйцэтгэсэн алба хаагчид хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувиар урамшуулал олгоно.
45.		20.3.Цэргийн алба хаагчийн түр суларсан орон тоог нөхөж ажиллуулах, албан үүргийг түр хавсран гүйцэтгэх журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
46.	21 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах	21.1.Цэргийн жинхэнэ алба хаагчийг албан ажлын шаардлага, эсхүл эрүүл мэндийн байдал, өөрийн хүсэлтийг харгалзан өөр албан тушаалд шилжүүлэн томилж болно.
47.		21.2.Ажлын шаардлагыг харгалзан офицерыг захиргааны санаачилгаар нэг албан тушаалаас нөгөө албан тушаалд сэлгэх болон шилжүүлэн томилно.
48.		21.3.Цэргийн жинхэнэ алба хаагчийг өөр албан тушаалд сэлгэн ажиллуулахдаа эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлс, цэргийн цолыг бууруулж болохгүй.
49.	22 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийг албан тушаалаас чөлөөлөх	22.1.2.өөр ажилд томилогдсон;
50.		22.1.4.тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;
51.		22.1.5.алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;
52.	23 дугаар зүйл. Албан тушаал бууруулан томилох	23.1.Цэргийн алба хаагчийн албан тушаалыг захиргааны санаачилгаар доор дурдсан үндэслэлээр бууруулан томилж болно:
53.		23.1.1.цэргийн нийтлэг дүрэмд заасны дагуу албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан;
54.		23.1.2.албан тушаалын үүрэгтээ тэнцэхгүй тухай харьяа анги, байгууллагын захирагч, даргын дүгнэлт гарсан.
55.	25 дугаар зүйл. Цэргийн цол	25.2.Цэргийн цол, түүний зэрэглэл нь цэргийн алба хаагчид цэргийн дүрмээр тогтоогдсон эрх, үүрэг, мөнгөн болон материаллаг хангалтын хэмжээг тодорхойлох үндэслэл болно.

56.	26 дугаар зүйл. Цэргийн цол олгох албан тушаалтан	26.1.Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч дээд офицерын цолыг олгоно.
57.		26.2.Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын дарга нь дараахь цэргийн цолыг олгоно: 26.2.1.офицерын анхны цолыг; 26.2.2.ахлах офицерын “хурандаа” цолыг; 26.2.3.цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын цэргийн алба хаагчийн цолыг.
58.		26.3.Цэргийн байгууллагын дарга, төрлийн цэргийн командлагч нь дараахь цэргийн цолыг олгоно: 26.3.1.“хурандаа” цолноос бусад офицерын цолыг; 26.3.2.ахлагчийн анхны болон “сургагч ахлагч”, “тэргүүн ахлагч” цолыг.
59.		26.4.Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нь дараахь цэргийн цолыг олгоно: 26.4.1.ахлагчийн анхны болон “сургагч ахлагч”, “тэргүүн ахлагч”-аас бусад ахлагчийн цолыг; 26.4.2.хугацаат болон цэргийн гэрээт алба хаагчийн цолыг.
60.		26.6.Дээд офицeroос бусад цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.
61.		26.7.Офицер, ахлагчид цэргийн цолыг анхны цолноос эхлэн дэс дараалан олгоно.
62.	28 дугаар зүйл. Цэргийн цолыг бууруулах, хураан авах, сэргээх	28.1.Цэргийн алба хаагч сахилгын зөрчил гаргаж албан тушаал буурсан тохиолдолд түүнд тухайн ажиллах албан тушаалын цолыг эдлүүлнэ.
63.		28.2.Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн болон Монгол Улсын харьяатаас гарсан цэргийн алба хаагчийн цэргийн цолыг цол олгосон албан тушаалтны шийдвэрээр хурааж авна.
64.		28.3.Бэлтгэл офицер, ахлагчийг ажлын зайлшгүй шаардлагаар цэргийн жинхэнэ албанд эгүүлэн авбал түүний цэргийн цолыг сэргээнэ.
65.	29 дүгээр зүйл. Цэргийн дүйцүүлэх алба, түүний төрөл	29.1.Цэргийн дүйцүүлэх алба нь биеэр дүйцүүлэх болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах гэсэн хэлбэртэй байна.
66.		29.2.Монгол Улсын иргэн шашин шүтлэг, ёс зүйн болон хуульд заасан бусад шалтгаанаар биеэр дүйцүүлэн хааж болно.
67.	30 дугаар зүйл. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах	30.6.Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний албанд цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр хоёроос дээш жил алба хаасан төрийн тусгай алба хаагчийг цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасанд тооцож, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.
68.	32 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл алба	32.1.Цэргийн бэлтгэл албанд байгаа нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнийг цэргийн анги, салбарт цэргийн мэргэжлийн дагуу зохих албан тушаалд бүртгүүлэх, цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалтад хамруулах, цэргийн дайчилгаатай сургуульд оролцуулах үүргийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб хүлээнэ.
69.		32.2.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн бэлтгэл албанд байх хугацаандаа цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдах, орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд оролцох томилгоот үүргээ гүйцэтгэх бэлтгэлтэй байх үүрэг хүлээнэ.

70.		32.4.Цэргийн сургуулийг иргэний мэргэжлээр төгссөн боловч цэргийн мэргэжлээр дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн иргэнийг бэлтгэл офицероор бүртгэнэ.
71.	33 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл албаны сургалт	33.8.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтыг аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.
72.		33.9.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад төрлийн цэргийн командлал дэмжлэг үзүүлнэ.
73.	34 дүгээр зүйл. Цэргийн бүртгэл	34.1.Цэргийн бүртгэлийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.
74.		34.2.Цэргийн бэлтгэл үүрэгтэн нь цэргийн үүрэгтний үнэмлэхтэй байна.
75.		34.3.Цэргийн бэлтгэл алба хаах насны иргэн жил бүр цэргийн бүртгэлд бүртгүүлж, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийлгэнэ.
76.		34.4.Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ.
77.		34.5.Цэргийн бүртгэлд дараахь иргэн хамрагдахгүй: 34.5.1.энэ хуулийн 16.1-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн; 34.5.2.цэргийн жинхэнэ алба хааж байгаа; 34.5.3.ял эдэлж байгаа.
78.		34.6.Цэргийн бүртгэлд хамрагдах иргэн дараахь үүргийг хүлээнэ: 34.6.1.нутгийн захиргааны анхан шатны нэгж /баг, хороо/-ийн байранд тогтоосон хугацаанд ирж цэргийн бүртгэлд хамрагдах; 34.6.2.цэргийн үүрэгтний үнэмлэхийг хаяж, үрэгдүүлэхгүй байх, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нөхөж авах; 34.6.3.цэрэг татлагын үеэр гурван сараас дээш хугацаагаар гадаад улсад зорчих бол энэ тухайгаа мэдэгдэх; 34.6.4.өөр газар шилжин суурьших тохиолдолд тухайн оршин суугаа газрынхаа цэргийн бүртгэлээс хасуулж, шилжин очсон газраа цэргийн бүртгэлд бүртгүүлэх.
79.	35 дугаар зүйл. Хувийн хэрэг, тоо бүртгэл, хувийн баримт бичиг	байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж, албан тушаалтан эрхлэн нээж, жил бүр баяжилт хийж хадгална.
80.		35.2.Офицер, ахлагчийн хувийн хэрэг нь түүний цэргийн алба хаасан тухай болон үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшний үнэлгээ, ажил байдлын тодорхойлолт, холбогдох судалгааг багтаасан байна.
81.		35.3.Офицер, ахлагчийн хувийн хэрэг нээгдмэгц офицер, ахлагчийн үнэмлэх олгох бөгөөд үнэмлэх нь цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг батлах үндсэн баримт бичиг болно.
82.		35.4.Цэргийн албанаас халагдаж байгаа офицер, ахлагчийн үнэмлэхэд халагдсан тухай тэмдэглэл хийж хувийн хэрэгт нь хадгална.
83.		35.5.Цэргийн жинхэнэ албанд эргэж орсон офицер, ахлагчид үнэмлэхийг дахин олгоно.
84.		35.6.Бэлтгэлээр халагдсан офицер, ахлагчид бэлтгэл офицер, ахлагчийн үнэмлэх олгоно.
85.	36 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	36.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
86.		36.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
87.		36.3.Цэргийн албаны тухай хууль зөрчигчид торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ХАВСРАЛТ №2 Батлан хамгаалах салбарын төрийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийн жагсаалт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ⁹⁶

2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 247

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2019 оны 196 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 220, 48 дугаар тогтоолоор тус тус нэмэлт орсон)

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Б.Хурцад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭРДЭНЭБАТ

Ж.МӨНХБАТ

Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралт

-

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

е/ БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1-д заасан төрийн нууцад хамааруулсан мэдээллээс гадна батлан хамгаалах салбарын хэмжээнд дараах мэдээллийг төрийн нууцад хамааруулна:

№	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл		Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	
1	Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлолын нууцалбал зохих хэсэг	+		30
2	Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)		+	20
3	Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилт, угсралт, төслийн ажил, технологийн тухай мэдээлэл		+	20
4	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, хүч хэрэгслийн тооцоо, судалгаа, арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл (улсын болон нийслэл, аймгийн хэмжээнд)		+	20
5	Зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвч	+		30
6	Төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн байлдааны цагийн орон тоо, зохион байгуулалт, бүтэц, холбогдох баримт бичиг		+	20

⁹⁶ Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/12878>

7	Төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн орон тоо, бүтэц зохион байгуулалттай холбоотой мэдээлэл агуулсан үеийн жинхэнэ нэр		+	20
8	Төрийн цэргийн байгууллагын байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл		+	20
9	Улсыг агаарын довтолгооноос хамгаалах тогтолцоо, төлөвлөгөө, удирдамж		+	20
10	Зэвсэглэл, байлдах чадварыг тодорхойлсон үнэлэлт бүхий байлдааны бэлтгэл сургуулийн нэгдсэн дүн, шалгалтын акт, тайлан, илтгэл		+	20
11	Байлдааны цагийн орон тооны зэвсэглэл, цэргийн техник, тусгай зориулалтын багаж, галт хэрэглэлийн хангалт, хэрэгцээ, хөдөлгөөнийг тодорхойлсон мэдээ, данс бүртгэл, тайлан, захиалга		+	20
12	Төрийн цэргийн байгууллагын стратегийн удирдамж, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо	+		30
13	Зэвсэгт хүчнийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байлдаанд бэлтгэх, шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, хавсралт төлөвлөгөөнүүд	+		30
14	Зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл		+	20
15	Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх болон өөрчлөн зохион байгуулах хэтийн төлөвлөгөө, анги, байгууллагыг байгуулах, шилжүүлэн байрлуулах, татан буулгахтай холбогдсон баримт бичиг, тооцоо, мэдээ (төслийн шатанд нэгэн адил)		+	20
16	Зэвсэгт хүчний анги, салбар, байгууллагын байлдааны бэлэн байдлыг хангах, тэдгээрийг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх удирдамж, захирамж, төлөвлөгөө, мэдээ		+	20
17	“Түгшүүр”, “Цугларалт” дохиогоор ажилласан дүнгийн тухай нэгдсэн мэдээ, баримт бичиг		+	20
18	Зэвсэгт хүчний бүх шатны тагнуулын нэгжийн бүтэц, орон тоо, зохион байгуулалт, зэвсэглэл, техник хэрэгслийн тухай баримт бичиг, мэдээ, мэдээлэл		+	20
19	Тагнуулын удирдамж, захирамж, байлдааны даалгавар, төлөвлөгөө, тайлан, мэдээ, сэлт, туршилт судалгааны ажлын үр дүнтэй холбоотой баримт бичиг, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө		+	20
20	Төрөл мэргэжлийн цэргийн тагнуулын төлөвлөлт, арга тактик, үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг, тагнуулын мэдээ, мэдээлэл солилцох журам		+	20
21	Цэрэг-улс төр, цэрэг-стратегийн орчин, гадаад орнуудын зэвсэгт хүчинд өгсөн үнэлгээ, түүнд холбогдох мэдээлэл		+	20
22	Байлдааны болон хил хамгаалалтын бэлэн байдлын мэдээ, байлдааны тушаал, захирамж, байлдааны ажиллагааны газар, орныг төхөөрөмжлөхтэй холбогдсон мэдээлэл		+	20
23	Байлдааны ажиллагааны бүс, чиглэл, зааг, районы өгөгдөхүүн, тэдгээрийг төхөөрөмжлөхтэй холбогдсон баримт бичиг, мэдээ, мэдээлэл		+	20
24	Цэргийн тусгай объектын харуул хамгаалалтын байдал, байлдааны жижүүрлэлтийн зохион байгуулалт, ажиллагаатай холбогдсон удирдамж, захирамж, баримт бичиг, мэдээ, мэдээлэл		+	20
25	Батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай, хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан нутаг дэвсгэрийн гравиметрийн зураглалын төрөл бүрийн хэмжээст зураглал, геодези, байрзүй, агаарын зураг		+	20
26	Цэргийн барилгын газар олголтын материал 1:500, 1:1000-ны газрын зураглал, холбогдох тайлбар бичиг		+	20
27	Улсын болон цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөө, нөөц, нөхөн хангах тооцоо		+	20
28	Төрийн цэргийн байгууллагын байлдааны техник зэвсэглэл, материал, галт хэрэглэлийн хангалт, захиалга, нөөцийн талаарх мэдээлэл		+	20
29	Зэвсэгт хүчин, анги, байгууллагыг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулж, бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө, түүнтэй холбогдсон бүх төрлийн мэдээ, баримт бичиг, судалгаа тооцоо, бүдүүвч		+	20
30	Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, тодотгох удирдамж, заавар	+		30

31	Дайчилгаатай сургуулийн баримт бичиг, дайчлах хүч хэрэгслийн тухай мэдээлэл		+	20
32	Цэргийн ангийн болон байлдааны дугаар, цэргийн мэргэжлийн дугаарын нэгдсэн жагсаалт		+	20
33	Дайчилгааны зарлан мэдээллийн дохио, захирамж, явуулах төлөвлөгөө, заавар		+	20
34	Дайчилгааны болон байлдааны үеийн улсын болон батлан хамгаалах материаллаг нөөцийг хадгалж байгаа газрын хаяг, агуулахын тоо, багтаамж, ажиллагаатай холбогдсон баримт бичиг, мэдээлэл		+	20
35	Зэвсэг, галт хэрэглэл, хүнс, шатахуун тосолгооны материал, санхүүгийн хангалт, нэгдсэн захиалга, мэдээ, тайлан, төлөвлөгөө, тооллогын актууд		+	20
36	Цэргийн зориулалттай цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх зүйлийн нөөцийн тоо, хэмжээ, хадгалж байгаа газар, тээвэрлэлт, харуул хамгаалалтын тухай мэдээ тэдгээрийг бэлтгэх журам, арга ажиллагаатай холбогдсон баримт		+	20
37	Төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл		+	20
38	Бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл		+	20
39	Цэргийн мэргэжлийн ангилал болон оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо (улсын болон нийслэл, аймгийн хэмжээнд)		+	20
40	Төрийн цэргийн байгууллагын автоматжуулсан болон далдуур (удирдлага холбооны) удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалт, хангалтын тухай мэдээлэл		+	20
41	Зэвсэгт хүчний бүх шатны удирдлагын байруудтай зохион байгуулах холбоо, мэдээллийн системийн болон техник зохион байгуулалтын бүдүүвч		+	20
42	Цэргийн далдуур удирдлагын зохион байгуулалттай холбогдох баримт бичиг, хангалтын тухай мэдээлэл, ном материал, дүрэм, заавар		+	20
43	Цэргийн далдуур удирдлага, шифрийн үйл ажиллагаа, харилцаа, арга, хэрэгсэл, материал, түүнтэй холбоотой мэдээлэл, техник, хэрэгсэл, түлхүүрийн хангалт		+	20
44	Агаарын цэргийн радио долгионы давтамжийн хуваарилалт, солих хугацаа, бүдүүвч		+	20
45	Зэвсэгт хүчний бүх шатны удирдлагын байгууллага, анги, салбарууд, зангилгаануудын байлдааны цагийн нэр, радио өгөгдөхүүн, радио тор, чигийн бүрэлдэхүүн, долгионы тухай жагсаалт, бүртгэл тооцоо		+	20
46	Холбооны сүлжээ, радио долгионы давтамжийн хуваарилалтын тухай мэдээлэл		+	20
47	Удирдлагын байрны бүтэц, зохион байгуулалт, холбоо мэдээллийн сүлжээний төхөөрөмжлөл, зураг, бүдүүвч хамгаалалтын зохион байгуулалт		+	20
48	Улсын болон цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр		+	20
49	Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө	+		30
50	Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөөний тухай мэдээлэл		+	20
51	Зэвсэглэл, цэргийн техник, галт хэрэглэлийн нөөц агуулахын хүчин чадал, өнгөлөн далдлалт, байрлалт, хамгаалалт, түүнд хүрэх замын тухай мэдээ		+	20
52	Зэвсэг, байлдааны техник, хүн хүчний тоог тодорхойлсон ар тал, санхүүгийн хангалт, төлөвлөгөө, төсөв, тооцоо, мэдээ, шалгалтын акт		+	20
53	Мөнгөн хөрөнгийн нэгдсэн захиалга, санхүүжилт, түүнд холбогдох мэдээ, баримт тооцоо		+	20
54	Улсын болон батлан хамгаалах материаллаг нөөцийн жилийн болон дунд, урт хугацааны үндсэн чиглэлийн төслийн тооцоо, үндэслэл, түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг		+	20
55	Улс орныг дайны байдалд шилжүүлэх төлөвлөгөө	+		30
56	Дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох мэдээлэл		+	20

57	Онцгой нөхцөл байдал бий болсон үед үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөө		+	20
58	Онцгой байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл		+	20
59	Төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээллийн сан		+	20
60	Мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, радио долгионы давтамжийн хуваарилалтын мэдээлэл		+	20
61	Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тооцоо, судалгаа, мэдээ, мэдээлэл		+	20
62	Кибер аюулгүй байдлын бодлого, төлөвлөлт, нэгжийн бүтэц зохион байгуулалт, сүлжээний бүдүүвч, хамгаалалтын төхөөрөмж, төхөөрөмжийн хүчин чадал, программ хангамж, эх код, тайлан, илтгэл, мэдээллийн сан		+	20
63	Мэдээллийн сүлжээн дэх нэвтрэлт, хандалт, шуурхай ажиллагаа, судалгаа үйлдвэрлэлийн чиглэлийн үйл ажиллагаа		+	20
64	Төрийн шифр харилцааны бодлого	+		30
65	Төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны болон шифрийн криптографын боловсруулалт, сан, нөөц, шифрийн арга ажиллагаа, аргачлал, тэдгээрийг ашиглах заавар, код, түлхүүр, түүнтэй холбоотой мэдээлэл	+		30
66	Төрийн шифр мэдээ, шифрийн харилцааны дүрэм, заавар, шифрийн материалын бүртгэл	+		30
67	Зэвсэгт хүчний холбооны системийг байлдааны цагт дэлгэн байгуулах төлөвлөгөө, байлдааны дохио дамжуулах түлхүүрийн техник хэрэгсэл, нууцлалын баримт бичиг		+	20
68	Төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл		+	20
69	Төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тайлан, илтгэл, мэдээлэл, дүгнэлт, хурал, зөвлөгөөн, лекц, гүйцэтгэх ажлын сургалтын хөтөлбөр, хичээлийн тэмдэглэл		+	20
70	Хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлыг шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцлал зохих баримт бичиг, мэдээлэл		+	20
71	Хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл		+	20
72	Улсын онц чухал болон тусгай объектын байршил, олгосон газрын нэр, зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл		+	20
73	Цэвэр ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн байршлын зураг, хамгаалалтын тухай мэдээлэл		+	20
74	Хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат шуудан, битүүмжлэхээс хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа		+	20
75	Хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг		+	20
76	Хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн болон хурал, чуулган, арга хэмжээ, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн байнгын болон цаг үеийн хамгаалалтын зохион байгуулалт, хүч, хэрэгслийн тухай мэдээлэл		+	20
77	Улсын хил халхлах, хамгаалах удирдамж, шийдвэр, төлөвлөгөө, түүнд холбогдох хавсралт, тооцоонууд		+	20

78	Улсын болон цэргийн онц чухал объектуудыг агаараас халхлах төлөвлөгөө, хүч хэрэгслийг ашиглах журам		+	20
----	---	--	---	----

ё/ ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРЭГ, ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАР

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1-д заасан төрийн нууцад хамааруулсан мэдээллээс гадна хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбарын хэмжээнд дараах мэдээллийг төрийн нууцад хамааруулна:


№	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл		Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	
1	Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)		+	20
9	Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилт, угсралт, төслийн ажил, технологийн тухай мэдээлэл		+	20
10	Хууль зүй, дотоод хэргийн яамны дайчилгааны даалгавар, төлөвлөгөө		+	20
11	Төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн орон тоо, бүтэц зохион байгуулалттай холбоотой мэдээлэл агуулсан үеийн жинхэнэ нэр, холбогдох баримт бичиг		+	20
12	Төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо		+	20
13	Төрийн цэргийн байгууллагын удирдлагын байрны байршил, мэдээлэл, холбооны сүлжээ, радио долгионы давтамжийн хуваарилалтын тухай мэдээлэл		+	20
14	Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм, улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах тухай удирдамж, тушаал, захирамж		+	20
15	Хил хамгаалах албаны бэлэн байдлын төлөвлөгөө, холбогдох баримт бичиг		+	20
16	Улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны арга ажиллагаа, хангалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл		+	20
17	Хилийн болон шалган нэвтрүүлэх албаны дэвтэр (хөтөлж эхэлмэгц нууц)		+	20
18	Төрийн цэргийн байгууллагын байлдааны техник, зэвсэг, тусгай зориулалтын материал хэрэгсэл, галт хэрэгслэлийн тоо, бүртгэл, захиалга, нөөцийн талаарх мэдээлэл		+	20
19	Хил хамгаалах байгууллагын холбоо, цэргийн далдуур удирдлагын заавар		+	20
20	Улсын хил хамгаалах зориулалттай болон хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан гравиметрийн зураглалын төрөл бүрийн хэмжээст зураглал, геодези, байрзүй, агаарын зураг		+	20
21	Онцгой нөхцөл байдал бий болсон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөө		+	20
22	Хил хамгаалах байгууллагын бэлэн байдлын сар бүрийн үйл ажиллагааны мэдээ		+	20
23	Онцгой байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл		+	20
34	Цагдаагийн байгууллагаас үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээсэн мэдээлэл		+	20
37	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа		+	20
38	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын өөрийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, арга, тактик, хүч, хэрэгсэл, төлөвлөгөөний мэдээлэл		+	20

39	Гүйцэтгэх ажлын зориулалттай зэвсэг, тусгай хэрэгсэл, материал техникийн хангалт, нөөцийн мэдээлэл		+	20
45	Шифрийн харилцааны заавар, шифр мэдээ, шифрийн материалын бүртгэл	+		30
46	Төрийн тусгай хэрэглээний радио долгионы давтамжийн хуваарилалтын мэдээлэл		+	20
47	Төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тайлан, илтгэл, мэдээлэл, дүгнэлт, хурал, зөвлөгөөн, лекц, гүйцэтгэх ажлын сургалтын хөтөлбөр, хичээлийн тэмдэглэл		+	20
48	Төрийн нууцад хамаарах асуудлыг шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл		+	20
49	Улсын онц чухал болон тусгай объектын байршил, олгосон газрын нэр, зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл		+	20

ХАВСРАЛТ №3 ЦАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зорилгоор хугацаат цэргийн алба хаагчдаас болон цэргийн жинхэнэ алба хаагчдаас авсан анкетын судалгааны үр дүн

Хугацаат цэргийн алба хаагчдын нас

■ 18-20 ■ 20-22 ■ 22-25




Хугацаат цэргийн алба хаагчдын нас

■ дээд ■ мэргэжлийн ■ бүрэн дунд ■ дундаас доош




Хугацаат цэргийн алба хаагчдын ажиллаж байсан салбар

■ хувийн хэвшил ■ төрийн байгууллага ■ оюутан ■ ажилгүй



Хугацаат цэргийн алба хаах нь эр хүний төлөвшилд эерэгээр нөлөөлөх үү?




“Танилтай эсхүл мөнгөтэй хүн тухайн жилийн цэрэг татлагаас чөлөөлөгддөг” гэж үздэг үү?



Та хугацаат цэргийн алба хааж дуусаад цэргийн албанд үлдэж ажиллах хүсэлтэй юу?



Цэргийн алба хааж ирсний дараа Таны өмнө ажиллаж байсан ажлын байрандаа буцаж орж чадах уу?



Жил бүр цэргийн бүртгэлд биеэр очиж бүртгүүлэх нь хүндрэлтэй санагддаг уу?




Цэргийн алба хаахыг хүсдэг үү?



Таны бодлоор хуулиар зөвхөн эр хүнд цэргийн алба хаах үүрэг хүлээлгэх нь зөв үү?







Цэргийн алба хааснаар эх орноо хамгаалах мэдлэг олж авах боломжтой юу?








0% 10% 20% 30% 40% 50% 60% 70% 80% 90% 100%

■ тийм ■ үгүй ■ мэдэхгүй




ЦАтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зорилгоор цэргийн жинхэнэ алба хаагчдаас болон цэргийн жинхэнэ алба хаагчдаас авсан анкетын судалгааны үр дүн







Цэргийн албан хаагчид олгож буй цалин, хангамжийн талаарх Таны бодол




Та ажлын онцлогоос хамаарсан стресс, бухимдлаа хэрхэн тайлдаг вэ?




Цэргийн жинхэнэ албан хаагчид оногдуулж буй хариуцлагын төрөл, хэмжээ хэр оновчтой вэ?




Та хамгийн сүүлд хэзээ сургалтанд хамрагдсан бэ?



Та цэргийн албаны харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, дүрэм журмыг хэр сайн мэдэх вэ?



Батлан хамгаалахын багц хууль хэрэгжсэнээр Таны эрх зүйн байдалд ямар өөрчлөлт гарсан бэ?



ХАВСРАЛТ №4 УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хүргүүлсэн албан бичгийн хуулбар



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.04.12. № 15

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна.

Батлан хамгаалах салбарт хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн дэг нэрийн дор дарамтлах, эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулах зүй бус үйлдлүүд удаа дараа гарч байгаатай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр хуралдаж 02 тоот тогтоолыг танд хүргүүлсэн. Үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Батлан Хамгаалах Яам хамтран ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгнө үү. Үүнд:

1. Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн албаны тухай хууль зэрэг цэргийн албаны үйл ажиллагаанд баримталдаг хууль тогтоомжуудын хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан;
2. 2010 оноос өнөөг хүртэл Батлан Хамгаалах салбарын хэмжээнд хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан гэмт хэргийн тухай нэгтгэсэн мэдээлэл болон хохиролыг хэрхэн барагдуулж, хариуцлага тооцсон тухай мэдээ тайлан;
3. Цэрэгт татагдаж буй залуусын мэдлэг, соёл, хандлага өөрчлөгдөхийн хэрээр цэргийн номлол болон тогтолцоонд шинэчлэлт хийх шаардлагатай. Дээрх зүй бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний богино болон урт хугацааны төлөвлөгөө, тухайлбал салбарын эрх зүйн орчин, дүрэм журмын нэмэлт өөрчлөлтүүдийн тухай мэдээлэл зэрэг болно.

Энэ асуулгыг танд хүргүүлж байх үед Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн хугацаат цэргийн хоёр албан хаагч харуулын даргаа буудан хөнөөгөөд зугтсан мэдээлэл гарлаа. 10 хоногийн өмнө Зэвсэгт хүчний 326 дугаар ангид алба хааж байсан байлдагч даргадаа зодуулсаны улмаас нас барсан харамсалтай хэрэг гарсан нь энэ асуудал хэр ноцтойг харуулж байна.

2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр болсон Хүний Эрхийн Дэд Хорооны хуралд оролцсон Батлан Хамгаалах Яам болон бусад холбогдох газрууд харилцан адилгүй

2020000150

тоо мэдээлэлтэй, цэргийн анги, салбарт гарч буй хүний эрх, эрх чөлөөнд халдаж буй зүй бус байдалтай хэрхэн тэмцэж, ямар үр дүнд хүрч байгаа тухай мэдээлэл хангалтгүй байсан болно.

Иймд асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.ОДОНТУЯА

2000000150